

ХУРААНГУЙ ХЭВЛЭЛ

ОЛОН УЛСЫН АРГА ЗҮЙ, ХӨТӨЛБӨРИЙН УДИРДАМЖ

СУРГУУЛИАС ГАДУУР БЭЛГИЙН ЦОГЦ БОЛОВСРОЛ ОЛГОХ

АЛБАН БУС, СУРГУУЛИАС ГАДУУРХ ХӨТӨЛБӨР
БОЛОВСРУУЛАХ НӨСӨЛГӨОНД СУУРИЛСАН АРГАЧЛАЛ



ОЛОН УЛСЫН АРГА ЗҮЙ, ХӨТӨЛБӨРИЙН УДИРДАМЖ

СУРГУУЛИАС ГАДУУР БЭЛГИЙН

ЦОГЦ БОЛОВСРОЛ ОЛГОХ

Албан бус, сургуулиас гадуурх хөтөлбөр
боловсруулах нотолгоонд суурилсан аргачлал



НҮБ-ын Хүн амын сан хэвлэв.

605 Third Avenue, New York, NY 10158, United States
of America

Зохиогчийн эрх © Нэгдсэн Үндэстний Байгууллагын
Хүн амын сан (НҮБХАС), 2020 он

ISBN 978-08-9-714045-4

Өнөөдөр дэлхий дахинд түүхэндээ хамгийн олон тооны залуучууд амьдарч байна. Тэдний эрүүл мэнд, боловсролд хөрөнгө оруулсанаар засгийн газрууд залуучуудын нийгмийн оролцоо, сайн сайхан байдлыг хангаж, нөөц бололцоогоо бүрэн дайчлахад нь тусалж чадна. Боловсрол, эрүүл мэндийн салбарын аль алинд нь хамаарах бэлгийн цогц боловсрол (БЦБ) нь эрүүл мэнд, жендэрийн тэгш байдлыг сайжруулахад чухал ач холбогдолтой. Энэ нь залуучуудад эрүүл саруул амьдарч, бусадтай эрүүл, зөв зохистой харьцах үр чадвар олгож, тэдэнд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндтэй холбоотой амьдралын чухал шийдвэр гаргахад тусална.

Олон залуус бэлгийн амьдрал, жендэрийн талаар шинжлэх ухааны үндэслэлгүй, зөрчилтэй, ойлгомжгүй мэдээлэл өдөр бүр авч байгаа нь залуусыг эрүүл мэнд, сайн сайхан байдал, нэр хүндээ ноцтой эрсдэлд оруулахад хүргэж байна. Улмаар өнөөдөр олон залуус бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудалтай тулгарч байна. Тиймээс БЦБ-ыг өргөн хүрээнд нэн яаралтай олгох шаардлагатай байна. Иймд НҮБ-ын Хүн амын сан, ЮНЕСКО, НҮБ-ын Хүүхдийн сан, ДОХ-той тэмцэх НҮБ-ын хөтөлбөр, ДЭМБ-тай хамтран *Сургуулиас гадуур бэлгийн цогц боловсрол олгох олон улсын арга зүй, хөтөлбөрийн удирдамжийг* боловсруулан гаргаж, энэхүү үйлсэд хувь нэмрээ оруулж байна.

Энэ удирдамжийг гаргаж буй цаг үед дэлхий даяар бэлгийн цогц боловсролын хэрэгцээ өсч, НҮБ-ын Хүн амын сан байгуулагдсаны 50 жилийн ой, Хүн ам ба хөгжлийн асуудлаарх олон улсын бага хурлаар дэлхий дахинаа хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг баталсаны 25 жилийн ой тохиож байна. Энэ нь мөн залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ХДХВ-ийн халдвартай хүмүүс, уугуул иргэд, дүрвэгсэд, цагаачид зэрэг хөгжлийн үр шимийг хүртэж чадахгүй орхигдсон хүн амд хүрэх зорилго бүхий Тогтвортой хөгжил 2030 болон түүний зорилтуудыг хэрэгжүүлэхэд тус дөхөм болно. Дээрх бүлгүүдийн ихэнх нь сургуульд сурдаггүй, сургуульд сурсан ч БЦБ олж авах боломжгүй хүүхдүүдэд сургуулиас гадуурх хөтөлбөрөөр дамжуулан мэдлэг олгох боломжтой болох бөгөөд тэдний хэрэгцээг үр дүнтэйгээр олж тогтооход туслах юм.

Сургуулиас гадуур бэлгийн цогц боловсрол олгох олон улсын арга зүй, хөтөлбөрийн удирдамж нь 2018 онд хэвлэгдсэн Бэлгийн боловсролын олон улсын арга зүйн удирдамж (ББОУАЗУ)-ийн агуулгыг баяжуулж, түүнээс иш татсан болно. Хүний эрхэд суурилсан арга болон баримт нотолгоонд тулгуурлан боловсруулсан энэхүү хөтөлбөр нь эмзэг бүлгийн залуучуудад бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар мэдээлэлд тулгуурлан сонголт хийх мэдлэг, үр чадвар олгох удирдамж, зөвлөмжтэй.

Энэхүү удирдамжийг боловсруулахад хувь нэмэр оруулсан ЮНЕСКО, НҮБ-ын Хүүхдийн сан, ДОХ-той тэмцэх НҮБ-ын хөтөлбөр, ДЭМБ болон НҮБ-ын Хүн амын сангийн хамт олон бид сөрөг үр дагаварт өртөх хамгийн их эрсдэл бүхий залуучууд ялангуяа хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт, ядуурал, ХДХВ, бэлгийн замын бусад халдвар, сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай залуучуудыг чадавхижуулж, бие даан шийдвэр гаргаж, эрүүл мэндээ хамгаалдаг болгох хөтөлбөр боловсруулахдаа үүнийг ашиглахыг уриалж байна. Бид энэхүү удирдамжид тусгасан жендэрийн тэгш байдал, хүний эрхэм чанар, нийгмийн тэгш оролцоо, хүний эрх зэрэг нийтлэг үнэт зүйлийг бэхжүүлж, дэмжин сайжруулахын төлөө тууштай ажиллах болно.

Залуу хүн бүр эрүүл амьдралын зөв хэв маягаар амьдрах мэдлэгтэй болж, нөөц боломжоо бүрэн дайчилж, илүү сайн сайхан ирээдүйг цогцлооход хувь нэмрээ оруулах чадавхитай болтол бид үргэлжлүүлэн хичээнгүйлэн ажиллах болно.

Др. Наталья Канем

НҮБ-ын Хүн амын сангийн Гүйцэтгэх захирал

Товчилсон үгийн тайлбар

ДОХ	Дархлалын олдмол хомсдолын хам шинж	НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
АНДЭрБЭМЭ (АРСОМ)	Ази, Номхон далайн орнуудын Эрэгтэйчүүдийн бэлгийн эрүүл мэндийн эвсэл	ДОХ-той тэмцэх НҮБ-ын хөтөлбөр	ХДХВ / ДОХ-той тэмцэх НҮБ-ын хөтөлбөр
АНДХДХВ+ХС (АРН+)	Ази Номхон далайн ХДХВ / ДОХ-н халдвартай амьдарч буй хүмүүсийн сүлжээ	НҮБХХ	НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр
БЦБ	Бэлгийн цогц боловсрол	ЮНЕСКО	НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага
ОУХДХВ+ХС (GNP+)	Олон улсын ХДХВ / ДОХ-ын халдвартай амьдарч буй хүмүүсийн сүлжээ	НҮБХАС	НҮБ-ын Хүн амын сан
ХДХВ	Хүний дархлал хомсдолын вирус	НҮБДАЭДКГ	НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газар
МБХХОУС	Мансууруулах бодис хэрэглэдэг хүмүүсийн олон улсын сүлжээ	НҮБ-ын Хүүхдийн сан	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан
ГБТОУХ (IPPF)	Гэр бүл төлөвлөлтийн олон улсын холбоо	НҮБМБГХТА	Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх НҮБ-ын алба
ОУААХ (IRC)	Олон улсын аврах ажиллагааны хороо	НҮБ-Эмэгтэйчүүд	НҮБ-ын Жеңдэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийг чадавхижуулах байгууллага
ББОУАЗУ	<i>Бэлгийн боловсролын олон улсын арга зүйн удирдамж</i>	ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЛГБК+	лесби, гей, бисексуал, пансексуал, бэлгийн дур хүсэлгүй болон гетеросексуал-бус бэлгийн чиг баримжаатай хүмүүс		
ЛГБТК+	лесби, гей, бисексуал, трансжендэр, күйр/өөрийн төрөлхийн хүйсээс өөрөөр тодорхойлогддог (интерсекс, эр эм хоёр туйлт хүйсийн аль нэгэнд хамаарахгүй/нийцэхгүй байх, ажендэр- ямар ч хүйстэй ижилсдэггүй гэх мэт)		
БҮТС /NSWP/	Биеэ үнэлэгчдийн төслүүдийн сүлжээ		

Энэхүү удирдамжийг НҮБ-ын Хүн амын сангийн техник, арга зүйн хэлтсийн Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн салбарын Бэлгийн цогц боловсролын олон улсын зохицуулагч Илья Жуков санаачилж, зохион байгуулан, боловсруулж, бэлгийн боловсрол, жендэр, хүний эрхийн зөвлөх **Андреа Ирвин**, НҮБ-ын Хүн амын сангийн дадлагажигч **Лили Уоррен**, **Илья Жуков** нарын дэмжлэгтэйгээр бичив. ДЭМБ-ын Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, судалгааны хэлтэсийн **Марина Плесонс**, **Венкатраман Чандра-Мули** нар удирдамжийн агуулгыг баяжуулж, **Жеймс Баер** хянан тохиолдуулав.

Зорилтот бүлгийн хүүхэд, залуучуудын бэлгийн боловсролын хэрэгцээ шаардлагын талаар ярилцлага болон удирдамжинд санал өгсөн; Норвегийн Осло хотноо 2017 оны 12-р сарын 12-13-нд болсон олон улсын шинжээчдийн зөвлөлдөх үүлзалтад оролцож санал бодлоо хуваалцсан болон бусад хэлбэрээр энэхүү удирдамжинд хувь нэмрээ оруулсан дараах хүмүүст гүнээ талархаж байна. Үүнд:

Оливер Анене ХДХВ залуу удирдагч сан
Мэттью Барклай Галлаудетийн их сургууль
Мария Бакарудис НҮБ-ын Хүн амын сан
Аруп Баруа ДЭМБ-ын дадлагажигч
Элизабет Беномар НҮБ-ын Хүн амын сан
Кимберли Берг Нью-Йорк мужийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөвлөгөөний зөвлөл
Ами Бишоп Олон улсын эрүүл мэнд, хүний эрхийн зөвлөл
Rune Brandrup НҮБ-ын Хүн амын сан
Жална Бродерик Ямаик улсын иргэний чанар
Пьер Бруард Преториагийн Их Сургууль ба Өмнөд Африкийн Сэтгэлзүйн Нийгэмлэг
Келвин Браун Азийн хөгжлийн банк
Кристофер Кастл ЮНЕСКО
Ставика Чаласани НҮБ-ын Хүн амын сан
Танака Чиромбо ХДХВ-ийн халдвартай залуучуудын үндэсний холбоо (Малави)
Эмили Кристи ДОХ-той тэмцэх НҮБ-ын хөтөлбөр
Эстер Корона Варгас Дэлхийн бэлгийн эрүүл мэндийн нийгэмлэг
Чу Тхань Ха It's Time (трансмэнүүдэд)
Амелиа Коулман НҮБ-ын Хүн амын сан
Пол-Гилберт Коллетаз Биеэ үнэлэгчдийн төслүүдийн олон улсын сүлжээ

Рейн Кортес Ази, Номхон далайн трансжендэрүүдийн сүлжээ
Кристина Де Карвальо Эрикссон НҮБ-ын Хүүхдийн сан
Ральф ДиКлементе Нью-Йоркийн их сургууль
Мэри Донохью Нью-Йорк хотын Боловсролын үйлчилгээ ба насанд хүрэгчдийн өдрийн үйлчилгээний хэлтсүүд
Даниел Энгел НҮБ-ын Хүн амын сан
Ингунн Эйдхаммер Норвегийн Хөгжлийн хамтын ажиллагааны агентлаг
Аденике Эсиет Action Health Incorporated
Бенте Фаугли НҮБ-ын Хүн амын сан
Жессика Филдс Сан Францискогийн их сургууль
Иэхенте Футе Уугуул залуучуудын бэлгийн эрүүл мэндийн сүлжээ
Хейли Глисон Олон улсын гэр бүл төлөвлөлтийн холбоо
Лианне Мари Гонсалвес ДЭМБ
Хантер Грей ЮНЕСКО
Гаж Б.Гүрунг Залуучууд LEAD
Марли Гүтиеррес-Паттерсон Ази, Номхон далайн трансжендэрүүдийн сүлжээ
Жилл Ханасс-Хэнкок Өмнөд Африкийн анагаах ухааны судалгааны зөвлөл
Камилла Холст Салвесен Норвегийн хөгжлийн хамтын ажиллагааны агентлаг
Лаура Херли Олон улсын гэр бүл төлөвлөлтийн холбоо
Феликия Жонс НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссар
Аксель Кийтинг InterACT
Ники Ханна, зөвлөлх
Елена Кирюшина ДОХ-той тэмцэх НҮБ-ын хөтөлбөр
Аннака Кнутссон НҮБ-ын Хүн амын сан
Поорна Кушалнагар Галлаудетийн их сургууль
Ирин Куземко Интерсекс Орос, Европын Интернэшнл Интертерс Байгууллага (OII), & InterACT
Шахназ Исламова Tais Plus ТББ
Жонатан Леггетт InterACT, Хүний эрхийн аян, ба GLAAD
Хосе Роберто Луна НҮБ-ын Хүн амын сан
Деус Лупенга Малави улсын Засгийн газар, Хөдөлмөр, залуучууд, спорт, боловсон хүчний хөгжлийн яам
Сара Мартин Онцгой байдлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах мэргэжилтэн
Нейл Маккүлоч Биеэ үнэлэгчдийн төслүүдийн дэлхийн сүлжээ
Кэтрин Маклафлин Элеватус Трэйингинг ХХК
Жефф Миглиоззи Перкинсийн Хараагүйчүүдийн Сургууль

Петр Младенов БЦБ-ын Сурталчилгааны төв
Курайш Мобиру Уганда Эерэг Залуучууд
Лебоганг Моцуми Африкийн залуучууд, өсвөр насныхны хүн ам, хөгжлийн асуудлаарх сүлжээ Geeta Narayan UNFPA
Гита Нараян НҮБ-ын Хүн Амын Сан
Лада Нужна Евро-Азийн өсвөр үе, залуучуудын холбоо
Грейс Осаку Охидыг хүчирхэгжүүлэх санаачилга
Яна Панфилова Евро-Азийн өсвөр үе, залуучуудын холбоо
Пиотр Павлак Жендэрийн зөвлөх
Морин Фири Залуучуудын үндэсний сүлжээ (Малави)
Кенита Пласид Зүүн Карибын олон талт байдал, эрх тэгш байдлын төлөөх холбоо
Дипа Прасад НҮБ-ын Хүн Амын Сан
Хабиб Рахман Ази Номхон далайн биеэ үнэлэгчдийн сүлжээ
Инад Рендон APCOM
Артуго Рекесенс Галнарес Уугуул иргэдийн асуудлаарх байнгын форумын нарийн бичгийн дарга нарын газар
Аманда Саенз InterACT
Брайан Шрэйфельс Элеватус Трейнинг ХХК & Арк Миннесота
Консуэло Сениор Насанд хүрсэн залуучуудын хүрээлэн
Лейла Шарифи НҮБ-ын Хүн амын сан
Венкатеш Шринивасан НҮБ-ын Хүн амын сан
Налини Шривастава НҮБ-ын Хүн амын сан
Дани Столбунов Евро-Азийн өсвөр үе, залуучуудын холбоо
Анна Шзегельниак Бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийн төлөө залуучуудын эвсэл
Гиллес Виргили НҮБ-ын Хүн амын сан
Эмили Видеруд АСТ холбоо ба Шведийн сүм
Женни Уильямс Хүний наймаа, жендэрийн зөвлөх
Кэй Тхи Вин Ази, Номхон далайн бүсийн Биеэ үнэлэгч ажилчдын сүлжээ
Сюзан Вуд Олон улсын эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн нэгдэл
Наталья Закарешвили НҮБ-ын Хүн амын сан
Кимберли Зизельман InterAct; мөн InterACT-ийн ажилтнууд, удирдах зөвлөл, залуу гишүүд
Энэ бүх үйл явцын туршид бидэнд дэмжлэг үзүүлж,

санал бодлоо илэрхийлж, хамтран ажилласан НҮБ-ын агентлагуудын дараах нөхдөдөө талархал илэрхийлье.

Женел Баб ЮНЕСКО

Салли Бийдл ЮНЕСКО

Назнин Дамжи НҮБ-эмэгтэйчүүд байгууллага

Жоанна Херат ЮНЕСКО

Елена Кудравцева НҮБ-эмэгтэйчүүд байгууллага

Хеге Ваган ДОХ-той тэмцэх НҮБ-ын хөтөлбөр

Дамилола Волкер НҮБ-ын Хүүхдийн сан

Мөн үе тэнгийнхэний боловсролын хэсгийг хянасан дараах байгууллагуудад бид талархалаа илэрхийлье. Үүнд:

Залуучуудын төлөөх өмгөөлөгчид; ЕвроТББ; Гүржийн залуучуудын хөгжил, боловсролын холбоо; Македоны эрүүл мэндийн боловсрол, судалгааны нийгэмлэг; Олон улсын анагаахын оюутны холбоо – Төгсөгчдийн холбоо; Залуучуудын хөгжлийн олон улсын хүрээлэн PETRI – София; Киргизийн Улаан хавирган сар нийгэмлэг; Y-PEER (Глобал, Албани ба Македон); Европ дахь залуучуудын бэлгийн боловсрол (YSAFE); YouAct байгууллага; Бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийн төлөө залуучуудын эвсэл; Залуучууд-LEAD.

Нэмэлт талархал илэрхийлэх нь:

Түүнчлэн олон улсын экспертүүдийн зөвлөлдөх уулзалтыг бэлдэж, зохион байгуулж, тайлагнахад дэмжлэг үзүүлсэн НҮБ-ын Хүн амын сангийн **Мика Ямай**, энэхүү удирдамжийг бүс нутгийн хэмжээнд танилцуулж, түгээн дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлж санхүүжүүлсэн **Норвеги улс**, удирдамжийн график дизайныг гаргаж хэвлэсэн **PrintOnline.ru**-д гүнээ талархаж байна.

Өмнөх үг	3
Товчилсон үгийн тайлбар	4
Талархал	5
Удиртгал	8
1. Сургуулиас гадуурх Бэлгийн цогц боловсролын тойм	9
2. Сургуулиас гадуурх Бэлгийн цогц боловсролын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх нь	11
2.1 Хөтөлбөр боловсруулах нь	11
2.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь	13
2.3 Сургуулиас гадуурх БЦБ-д үе тэнгийн сургагчдыг татан оролцуулах нь	15
2.4 Сургуулиас гадуурх БЦБ-д эцэг эх, асран хамгаалагчдыг оролцуулах нь	17
2.5 Сургуулиас гадуурх БЦБ-д технологийг ашиглах нь	18
3. Сургуулиас гадуурх Бэлгийн цогц боловсролыг Залуучуудын онцлог бүлгүүдэд хүргэх нь	20
3.1 Жендэрийн онцлог бүлгүүд	20
3.1.1 Охид, бүсгүйчүүд	20
3.1.2 Хөвгүүд, залуу эрчүүд	21
3.2 Хөгжлийн бэрхшээлтэй залуучууд	22
3.2.1 Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын тухай ерөнхий мэдээлэл	22
3.2.2 Бие махбодын хөгжлийн бэрхшээлтэй залуучууд	23
3.2.3 Оюуны хөгжлийн бэрхшээлтэй залуучууд	24
3.2.4 Сонсголгүй болон сонсголын бэрхшээлтэй залуучууд	25
3.2.5 Хараагүй залуучууд	26
3.2.6 Аутизм болон спектрийн эмгэгтэй залуучууд	27
3.2.7 Нийгэм-сэтгэл зүйн бэрхшээлтэй залуучууд	27
3.3 Хүмүүнлэгийн нөхцөл байдалд байгаа залуучууд	28
3.4 Уугуул залуучууд	30
3.5 Лесби, гей, бисексуал залуус мөн эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог бусад залуу эрчүүд	32
3.6 Трансжендэр залуучууд	34
3.7 Интерсекс залуучууд	36
3.8 ХДХВ-ийн халдвартай залуучууд	38
3.9 Мансууруулах бодис хэрэглэдэг залуучууд	40
3.10 Секс үйлчилгээ үзүүлдэг залуучууд	41
3.11 Хоригдож буй залуучууд	43
Нэр томьёоны тайлбар толь	45

Бэлгийн боловсролын олон улсын арга зүйн удирдамж (ББОУАЗУ)-ын анхны хэвлэлийг 2009 онд ЮНЕСКО, ДОХ-той тэмцэх НҮБ-ын хөтөлбөр, НҮБ-ын Хүн амын сан, НҮБ-ын Хүүхдийн сан, ДЭМБ хамтран гаргасан. Түүнээс хойш бэлгийн цогц боловсрол (БЦБ) нь олон улсын хэмжээнд өргөжин хөгжиж, түүнийг үндэсний, бүс нутгийн болон олон улсын түвшинд хэрэгжүүлэхэд шаардлагатай улс төр, соёлын орчинд эерэг өөрчлөлтүүд гарсаар байна.

2016, 2017 онд ЮНЕСКО ББОУАЗУ-ийг шинэ нотолгоо баримт, сайн тэргүүн туршлагыг тусган шинэчлэх үйл явцыг удирдаж, 2018 онд шинэчилсэн ББОУАЗУ нь хэвлэгдсэн (ЮНЕСКО ба бусад, 2018; ББОУАЗУ-ийн талаарх бүх ишлэлд энэ шинэчилсэн хэвлэлийг дурдах болно). Энэхүү шинэчилсэн хэвлэлд БЦБ-ын тойм, үр дүн, баримт; 5-8 нас, 9-12 нас, 12-15 нас, 15-18 нас гэсэн дөрвөн насны бүлгийн онцлогт тохируулсан сургалтын хөтөлбөрт оруулах БЦБ-ыг шинжлэх ухааны үндэслэлтэй үндсэн ойлголтууд, сэдэв болон түүнд суралцах зорилгыг багтаасан болно. Мөн БЦБ-ын хөтөлбөрүүдийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, төлөвлөх, түгээх зөвлөмж, удирдамжийг оруулсан. ББОУАЗУ нь сургуулийн орчинд болон сургуулиас гадуурх БЦБ-ын хөтөлбөрүүдийн аль алинд нь хамаардаг боловч албан боловсролын хүрээнд БЦБ-ыг олгоход түлхүү анхаардаг.

2015 онд Тогтвортой хөгжлийн зорилтуудыг 2030 он хүртэл хэрэгжүүлэхээр баталж, Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын төрөлжсөн агентлагууд, хөгжлийн бусад түншүүд хэнийг ч орхигдуулахгүй хөгжих, орхигдсон хүн амыг хамгийн түрүүнд хөтөлбөрт хамруулах зорилт тавьсан. Хүүхэд, залуучуудын дундаас хамгийн их орхигдсон бүлэг бол сургууль завсардсан, янз бүрийн шалтгаанаар ялгаварлан гадуурхагдсан, хүний эрх нь зөрчигдөж буй залуучууд юм. Үүнд мөн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндэд нь сөрөг үр дагавар гарах эрсдэлтэй хүүхэд, залуучууд багтана. Иймд оролцогч талууд сургуулиас гадуурх БЦБ олгох удирдамж боловсруулахыг хүссэн юм.

Удирдамжийн зорилго

Энэхүү хураангуйгаар хэвлэгдсэн *Сургуулиас гадуурх бэлгийн цогц боловсролын олон улсын арга зүйн ба хөтөлбөрийн удирдамжийг* ББОУАЗУ-тай хамт ашиглахаар боловсруулсан болно. ББОУАЗУ нь БЦБ олгох хөтөлбөрийн бүхий л үндэс суурийг тайлбарласан ба БЦБ гэж юу болохыг нарийвчлан тодорхойлж (ББОУАЗУ, 2-р бүлэг); энэ нь хүүхэд, залуучуудын эрүүл мэнд, сайн сайхан байдлыг хэрхэн хангах (3-р бүлэг); БЦБ-ын нотолгоо үндэслэл (4-р бүлэг); гол ойлголтууд, сэдвүүд ба суралцахуйн зорилтууд (5-р бүлэг); БЦБ-ын үр дүнтэй хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх дэмжлэгийг бий болгох, төлөвлөх талаарх удирдамжуудыг (6-р бүлэг) багтаасан.

Энэхүү удирдамж нь ББОУАЗУ-д үндэслэн нэмж сайжруулсан хувилбар юм. БЦБ-ыг сургуулиас гадуурх орчинд зохион байгуулдаг хөтөлбөрүүд болон хүүхэд, залуучуудад зориулсан БЦБ-ыг хүргэх боломжгүй тодорхой бүлгүүдийн хэрэгцээ шаардлагыг хангахад чиглэсэн нотолгоонд болон практик мэдээлэлд суурилсан удирдамж юм. Энэхүү хэвлэл нь эдгээр бүлгийн хүүхэд, залуучуудад тохирсон, аюулгүй БЦБ-ын хөтөлбөрийг хэрхэн боловсруулах талаарх дэлгэрэнгүй удирдамжийг багтаасан болно. Энэхүү удирдамжийн зорилго нь:

- **сургуулиас гадуурх БЦБ-ыг нарийвчлан тодорхойлох**
- хүүхэд, залуучууд, тэр дундаа тодорхой бүлгийн хүүхэд, залуучуудад нөлөөлж буй, сургуулийн орчинд орхигдуулж болзошгүй бэлгийн амьдрал, эрүүл мэнд, хүний эрхийн асуудлууд, санаа зовниж буй асуудлын талаарх мэдлэгийг нэмэгдүүлж **сургуулиас гадуурхи БЦБ-ын хэрэгцээ шаардлагын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, сурталчлах.**
- **сургуулиас гадуурх БЦБ хөтөлбөрийг хэрхэн боловсруулах удирдамжаар хангах**, үүнд нотолгоонд суурилсан, соёлыг харгалзан үзсэн, хүүхдийн нас, хөгжлийн онцлогт тохирсон, сэтгэцийн эрүүл мэндэд анхаарсан (14-р хуудсыг үзнэ үү), тодорхой бүлгийн хүүхэд, залуучуудын хэрэгцээнд нийцсэн сургалтын хөтөлбөр, заах арга зүй, сургалтын материалыг боловсруулах удирдамжаар хангах юм.

Энэхүү хэвлэл нь тус удирдамжийн хураангуй хувилбар юм. Үүгээр сургуулиас гадуурх үр дүнтэй БЦБ-ын хөтөлбөрийг төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэхтэй холбоотой хамгийн бодит практик мэдээллийг агуулсан бөгөөд ашигласан материалын жагсаалтыг хавсралтаар оруулсан. Энэхүү хураангуй хэвлэлд агуулагдах мэдээлэл болон тус удирдамжийн бүрэн хэмжээний хэвлэлд дараах мэдээлэл багтсан болно. Үүнд:

- энэхүү удирдамжийн үндэслэл болох ном зохиолын тойм
- энэхүү удирдамжинд дурдсан бүлгийн хүүхэд, залуучуудын бүлэг тус бүрийн онцлог хэрэгцээний талаар нарийвчилсан танилцуулга, тэдний БЦБ-ын статусын талаарх танилцуулга
- сургуулиас гадуурх БЦБ-ын үр дүнтэй байдлын талаарх нотолгоо, ерөнхий болон энэхүү удирдамжид дурдсан хүүхэд, залуучуудын бүлэг тус бүрд зориулагдсан нотолгоонууд
- сурган хүмүүжүүлэх хэд хэдэн үзэл баримтлал, хандлагын талаарх дэлгэрэнгүй тайлбар
- сургуулиас гадуурх БЦБ-ын хэрэгжилтийн өнөөгийн байдал, боломж, бэрхшээлийн талаар авч үзсэн.

Энэхүү удирдамж хэнд зориулагдсан бэ?

Энэхүү удирдамж нь сургуулиас гадуурх орчинд БЦБ-ын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлж буй хэн бүхэнд туслах зорилготой юм. Үүнд засгийн газар, олон улсын болон иргэний нийгмийн байгууллагууд, олон нийтийн байгууллагууд, НҮБ-ын агентлагууд, залуучууд багтана.

Удирдамжийн бүтэц

1-р бүлэгт сургуулиас гадуурх БЦБ-ын талаарх тойм, түүний тодорхойлолт, зорилго, үүрэг, сургуулиас гадуурх БЦБ олгох боломж, хязгаарлалтуудыг багтаасан болно.

2-р бүлэгт сургуулиас гадуурх БЦБ-ыг боловсруулж хэрэгжүүлэх ерөнхий удирдамж, түүнчлэн үе тэнгийн сургагч багш нарыг татан оролцуулах, эцэг эх, асран хамгаалагчдыг хамруулах, технологийг ашиглах удирдамжийг танилцуулна. Үүнд 3-р бүлэгт яригдах хүн амын бүх бүлэгт хамааралтай зөвлөмжүүдийг багтаасан болно.

Сургуулиас гадуурх Бэлгийн цогц боловсролын тойм

3-р бүлэг нь сургуулиас гадуурх БЦБ-ыг хүүхэд, залуучуудын тодорхой бүлэгт хүргэх зааварчилгаа, удирдамжийг багтаасан. Үүнд: (Хүүхэд, залуучууд эдгээр бүлгүүдийн аль алинд нь харьяаглагдаж болохыг хүлээн зөвшөөрч) охид, хөвгүүд тус тусдаа; хөгжлийн бэрхшээлтэй залуучууд; хүмүүнлэгийн нөхцөлд байгаа залуучууд; нутгийн уугуул үндэстэн залуучууд; лесби, гей, бисексуал, жендэрийн хоёр хүйст ангилагдахгүй/нийцэхгүй залуучууд; трансжендэр залуучууд; интерсекс залуучууд; ХДХВ-ийн халдвартай залуучууд; мансууруулах бодис хэрэглэдэг залуучууд; биеэ үнэлдэг залуучууд; хорих ангид байгаа залуучууд багтана.

Удирдамжийг хэрхэн боловсруулсан бэ?

2017 онд НҮБ-ын Хүн амын сангийн захиалгаар сургуулиас гадуурх БЦБ-ын үр дүнтэй байдлын талаарх ном зүйн тойм судалгааг хийсэн. Үүнд дэлхийн өнцөг булан бүрт боловсрол, эрүүл мэнд, залуучуудын хөгжил, хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлын чиглэлээр ажилладаг шинжээчид, судлаачид, боловсролын яамны албан тушаалтнууд, ТББ-ын хөтөлбөр хэрэгжүүлэгчид, хөгжлийн түншүүд, залуучууд зэрэг олон хүмүүсийн саналыг авсан.

Ном зүйн тойм судалгааны үр дүнг 2017 оны сүүлээр НҮБ-ын Хүн амын сангаас зохион байгуулсан олон улсын шинжээчдийн зөвлөлдөх уулзалтад танилцуулж, хэлэлцүүлсэн бөгөөд уг уулзалтанд оролцогчид энэхүү удирдамжийн агуулгын төслийг боловсруулсан юм.

Агуулгын тоймтой холбоотой нэмэлт санал хүсэлтийг авсаны дараа залуу шинжээчидтэй нэмэлт ярилцлагуудыг зохион байгуулж практикт хэр нийцсэн, хүүхэд, залуучуудын тодорхой бүлгүүдэд тулгарч буй асуудалд хариу өгөх боломжтой эсхийг судалсаны дараа анхны хувилбарыг төсөл хэлбэрээр боловсруулсан. Удирдамжинд дурьдсан бүлгүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн хэрэгцээ шаардлагын талаар туршлагатай шинжээчдээр холбогдох бүлэг, хэсгүүдийг хянуулсан. Иймд энэхүү удирдамж нь нотолгоонд суурилан боловсруулагдсанаас гадна, залуучуудын үзэл бодол, одоогийн тэргүүн туршлага, амжилттай хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийн талаарх мэдлэг, шинжээчдийн оруулсан өргөн хүрээний мэдээлэлд үндэслэсэн болно. Удирдамжийн эцсийн хувилбарыг үндсэн шинжээчид болон НҮБ-ын зохицуулагчидтай хуваалцаж, тэдний санал, сэтгэгдлийг тусгасан болно.

Энэхүү удирдамж нь ББОУАЗУ-ийн шинэчилсэн хэвлэлд орсон БЦБ-ын тодорхойлолтыг ашигласан.

“Бэлгийн цогц боловсрол гэдэг нь бэлгийн амьдралын танин мэдэхүйн, сэтгэл хөдлөлийн, бие махбодын, нийгмийн талуудыг сургалтын хөтөлбөрт суурилан¹ сургах ба түүнд суралцах үйл явц юм. Энэ нь хүүхэд, залуучуудад өөрсдийн эрүүл мэнд, сайн сайхан байдал, хүний эрхэм чанараа таньж мэдэн хөгжүүлэх; харилцан бие биеэ хүндэтгэсэн нийгмийн болон бэлгийн харилцааг бий болгох; тэдний хийж буй сонголт нь бусад хүмүүсийн сайн сайхан байдалд хэрхэн нөлөөлөхийг анхаарч үзэх; насан туршдаа өөрсдийн эрхийг ханган баталгаажуулахад шаардлагатай мэдлэг, чадвар, хандлага, үнэт зүйлийг төлөвшүүлэх зорилготой.”

Чанартай БЦБ нь дараах шинж чанарыг агуулсан байдаг. Үүнд:

- шинжлэх ухаанаар нотлогдсон үнэн зөв
- өмнөх мэдлэг дээр суурилан тасралтгүй хөгжиж байдаг
- биеийн хөгжил, насны онцлогт тохирсон
- сургалтын хөтөлбөрт суурилсан
- цогц
- хүний эрхийн хандлагад суурилсан
- жендэрийн тэгш байдалд суурилсан
- соёл, ёс заншилд нийцтэй, тухайн орчин нөхцөлд тохиромжтой
- өөрчлөлтөд чиглэсэн
- эрүүл сонголтуудыг хийхэд дэмжлэг үзүүлэхүйц амьдрах ухааны үр чадварыг хөгжүүлэх боломжтой байх.

Эдгээр шинж чанаруудын талаарх дэлгэрэнгүй тодорхойлолтыг ББОУАЗУ-ийн 2.1-р хэсэгт оруулсан болно.

Сургуулийн орчин дах БЦБ-ыг сурагчдад сургалтын хөтөлбөрийн хүрээнд сургууль дээр (хичээлийн цагийн хуваарийн дагуу эсвэл хичээлээс гадуурх хэлбэрээр) олгодог. ББОУАЗУ-нд дурьдсанаар БЦБ-ыг сургуулийн орчинд олгох нь “олон тооны хүүхэд, залуучуудад бэлгийн харилцаанд орохоос нь өмнө бэлгийн боловсролыг эзэмшүүлэх маш чухал боломжийг олгодог оос гадна эдгээр залуучуудад энэ сэдвийг суралцах зохистой орчин бүрдүүлж өгдөг” гэжээ.

Харин сургуулиас гадуурх БЦБ нь сургуулийн сургалтын хөтөлбөрөөс гадуур олгогддог БЦБ юм. Сургуулиас гадуурх БЦБ нь дараах хэд хэдэн зорилготой. Үүнд:

- сургуулийн сургалтын хөтөлбөрөөр БЦБ олгодоггүй нөхцөлд хүүхэд, залуучуудад БЦБ олгох
- сургуульд сурдаггүй хүүхэд, залуучуудад БЦБ олгох

¹ ББОУАЗУ-д тодорхойлсноор “Сургалтын хөтөлбөрт суурилсан” гэдэг нь “багшлахуйн үндсэн зорилтуудыг агуулсан, суралцахуйн зорилтыг тодорхойлж, үндсэн ойлголт, ухагдахууныг танилцуулж, түлхүүр мэдээллийг системтэйгээр хүргэх арга замуудыг багтаасан” сургагч багш нарт суралцагчдын суралцах үйл явцыг дэмжихэд нь чиглүүлэх бичмэл баримт бичиг юм. БЦБ-ын хөтөлбөрийг сургуульд болон сургуулиас гадуур хэрэгжүүлж болно

- тухайн сургуулийн орчин дахь БЦБ-ыг нөхөж олгох, ялангуяа хөтөлбөр нь цогц бус эсвэл чанар муутай нөхцөлд нэмэлтээр олгох
- хүүхэд залуучуудын тодорхой бүлгийн хэрэгцээнд нийцсэн БЦБ-ыг олгох.

ЮНЕСКО-гийн тооцоолсноор дэлхийн хэмжээнд 263 сая хүүхэд сургуульд хамрагдаагүй байгаагаас 63 сая нь бага боловсрол эзэмших насандаа завсардсан, 61 сая нь дунд боловсрол эзэмших насандаа завсардсан, 139 сая хүүхэд дунд сургуулийн ахлах ангийн боловсрол эзэмших насандаа завсардсан байгаа нь сургуулиас гадуурх БЦБ чухал ач холбогдолтойг харуулж байна. (ЮАЙЭс, 2018).

Сургуулиас гадуурх БЦБ-ыг сургагч багш нар, үе тэнгийн сургагч багш нар эсвэл эцэг эхчүүд нүүр тулсан сургалтаар зохион байгуулж болох ба мөн техник технологи, түүний дотор компьютер, гар утас ашиглан хүргэж болно. Энэ сургалтыг төрөл бүрийн орчин нөхцөлд явуулж болно. Үүнд:

- иргэний нийгмийн эсвэл олон нийтийн байгууллагууд
- залуучуудын төвүүд эсвэл залуучуудын клубууд
- эрүүл мэндийн төвүүд
- зуны хүүхэд залуучуудын зуслан
- шашны байгууллагууд эсвэл итгэл үнэмшилд суурилсан байгууллагууд
- хичээлийн бус цагаар сургууль дээр (хэрэв тухайн сургуулийн багш тухайн сургуулийн сурагчдад явуулж байгаа тохиолдолд үүнийг сургуулийн орчин дахь БЦБ гэж үзнэ)
- гэр бүл (эцэг эх-хүүхдийг хамарсан бүтэцчлэгдсэн хөтөлбөрүүд)
- ажлын байрууд
- Хорих газар, цагдан хорих төв, насанд хүрээгүй хүмүүжигчдийн засан хүмүүжүүлэх төв
- дүрвэгсдийн хуаран эсвэл хүмүүнлэгийн дэмжлэг үзүүлдэг бусад хоргодох байрууд.

ББОУАЗУ-ийн дагуу сургуулиас гадуурх БЦБ хөтөлбөрийг өсвөр насныхан, залуучуудад төдийгүй бага насны хүүхдүүдэд нас, хөгжлийн онцлогт нь тохирсон хэлбэрээр олгох ёстой гэдгийг анхаарах нь чухал юм. Хүүхдүүд бэлгийн амьдралын талаарх мэдээллийг багаасаа олон эх сурвалжаас олж авч байдаг тул БЦБ нь тэдний олж буй мэдлэг үнэн зөв, аюулгүй, тэдэнд хамааралтай, жендэрийн тэгш байдлыг дэмжсэн байхад нь тусалдаг (Играс нар, 2014; Лундгрэн ба Амин, 2015, Көгестен нар, 2016; Блум нар, 2017; Чандра-Моли нар, 2017).²

Сургуулиас гадуурх БЦБ нь сургуулийн орчин дахь БЦБ-той харьцуулахад илүү албан бус, уян хатан орчинг бий болгох боломжийг олгодог бөгөөд энэ нь цөөн хүүхэдтэй анги, бүлгүүдээр хичээллэх, хичээлийн хугацаа урт, сургалтын хөтөлбөр нь илүү олон янзын, бүтээлч байдлаар хүргэх, суралцагчдын хооронд илүү харилцан ярилцах боломжтой юм. Ийм хөтөлбөр нь ижил төстэй амьдралын туршлагатай, эсвэл ижил төстэй орчин нөхцөлд амьдардаг, ялангуяа хамгийн орхигдсон хэсгийн хүүхэд, залуучуудыг нэгтгэж, тэдний хэрэгцээ шаардлагад нийцүүлэн БЦБ-ыг олгохоос гадна, тэднийг бие биенээ дэмжихэд нь уриалж чадна.

Сургуулиас гадуурх БЦБ нь сургуулийн орчинд тэр бүр

хэрэгжих боломжгүй эсвэл хүлээн зөвшөөрөгдөхгүй хэцүү сэдвүүдийг хамарч, жендэрийн тэгш байдлыг хангах, эрх мэдэлжүүлэхэд чиглэсэн хүний эрхэд суурилсан хандлагыг сурталчилах боломжтой юм.

Сургагч багш нар суралцагчдыг өөрийн сургуулийнхаа багштай ярихаас болгоомжилдог асуулууд болон үзэл бодлыг хуваалцахыг нь дэмжиж өгч болно. Эцэст нь хэлэхэд, сургуулиас гадуурх хөтөлбөрүүд нь бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн бүтээгдэхүүнүүдээр илүү сайн хангаж, хүүхэд, залуучуудыг үйлчилгээнд, зөвлөн туслагчидтай болон бусад төрлийн дэмжлэгтэй холбож өгөх боломжтой юм.

Сургуулиас гадуурх БЦБ-ыг хэрэгжүүлэхэд нийгмийн зүгээс тодорхой саад бэрхшээлтэй тулгардаг ба энэ нь ихэвчлэн сургуулийн орчин дахь БЦБ-д тулгардагтай ижил бэрхшээл байдаг болохыг тэмдэглэх нь зүйтэй. Жишээлбэл, сургалтын агуулгыг бусдын дургүйцлийг хүргэх магадлалтай эсвэл хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзвэл олон нийтийн дэмжлэгийг бий болгоход хэцүү байж болно. Гэхдээ сургуулиас гадуурх орчинд, ялангуяа оролцогчид нь нийгмээс гадуурхагдсан бүлгийн гишүүд байвал тэднийг олон нийтийн зүгээс сургалтанд оролцсоных нь төлөө дургүйцэж, буруутгаж магадгүй бөгөөд тэр ч байтугай цагдаа нарт онилогдох магадлалтай. Иймд урам зоригтой, чадварлаг, зохистой хандлагатай сургагч багш нарыг тодруулж сургах, тэднийг дэмжиж, сургалтын хөтөлбөрийн дагуу хичээлээ заадаг болгох нь зохистой юм (Vanwesenbeeck нар, 2016).

Түүнчлэн сургалтын гарын авлага болон бусад хэрэгслээр хангах, БЦБ-ын хичээлийн аюулгүй, тав тухтай орчин бүрдүүлэх, хугацаа олгох зэрэг бэрхшээлтэй тулгарч болно. Эцэст нь зорилтот бүлгийн залуучуудад сургуулиас гадуурх БЦБ олж авах боломжтойг ойлгуулж, тэдэнд энэ асуудал хамааралтай бөгөөд сургалтанд хамрагдсанаар тэдэнд тулгарч буй аливаа бэрхшээл буюу алслагдсан байдал, цаг хугацааны бэрхшээлийг даван туулах чадвартай болно гэдгийг гэдгийг ойлгуулах шаардлагатай. Эдгээр хүчин зүйлс нь хүүхэд, залуучуудыг БЦБ-д бүрэн хамруулах, зорилтот бүлгийн суралцагчдыг үргэлжүүлэн хамруулж, сургалтын тасралтгүй байдлыг хангах, сургалтын агуулгыг бүрэн хамрахад бэрхшээл учруулж болзошгүй юм (Vanwesenbeeck нар, 2016).

Эдгээр бэрхшээлүүдийг шийдэн сургуулиас гадуурх БЦБ хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлсэн тохиолдолд, энэ нь сургуулийн орчин дахь БЦБ-ын нэгэн адилаар дараах өргөн цар хүрээтэй зорилгуудад хувь нэмрээ оруулах боломжтой юм. Үүнд:

- Нийгмийн хэм хэмжээг өөрчлөх: Зөвхөн суралцагчдын хувь хүний болон хоорондын хандлага, зан үйлийг төлөвшүүлэх, өөрчлөхөд чиглэсэн хөтөлбөрүүдийн үр дүн хугацааны хувьд хязгаарлагдмал байж болно. Хөтөлбөрүүд нь жендэрийн тэгш бус байдал, эмзэг байдлыг бууруулах, гутаан доромжлох, ялгаварлан гадуурхахад нөлөөлж буй нийгмийн хор хөнөөлтэй хэм хэмжээнүүдийг өөрчлөхөд хувь нэмэр оруулах ёстой (Абрамский нар, 2014; Сванемыр нар, 2015; Абрамский нар, 2016).

²Энэхүү удирдамж нь ихэнх тохиолдолд сургуулиас гадуурх БЦБ-ын хөтөлбөрийн насны онцлогтой агуулгыг авч үздэггүй. Бэлгийн харьцаа, бэлгийн хавьтагч, жирэмслэхээс хамгаалах хэрэгсэл гэх мэт сэдвүүдийн ашигласан материал болон сэдэв нь сургуулиас гадуурх БЦБ-д насны ангилал бүрд тохирно гэж үзэж болохгүй. Уншигчдын насны онцлогт тохирсон сургалтын агуулгын талаарх удирдамжийг ББОУАЗУ-аас авахыг зөвлөж байна

- Бодлогын өөрчлөлтөд хувь нэмэр оруулах: дээрхийн адил хөтөлбөрүүд нь хүүхэд, залуучуудын бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, тэдний хүний эрхэд нөлөөлөх хууль, бодлогыг боловсруулж хэрэгжүүлдэг засгийн газар, эрх бүхий байгууллагад нөлөөлөх арга замд хувь нэмэр оруулах ёстой (Сванемыр нар, 2015). Ялангуяа энэ нь хүүхэд, залуучуудын бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах боломжийг сурталчилна гэсэн үг юм. Олон улс оронд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаархи мэдээлэл, үйлчилгээ авахыг насаар болон гэр бүлийн байдлаар нь хязгаарласан хууль тогтоомж байдаг нь 18-аас доош насны хүүхдийг эцэг эх, асран хамгаалагч, эхнэр / нөхрийнхөө зөвшөөрөлгүйгээр үйлчилгээ авахыг зөвшөөрдөггүй. Хүүхдийн Эрхийн Хорооны 4-р Ерөнхий зөвлөмжинд оролцогч улсууд хүүхдүүд гэрлэлтийн байдал, эцэг эх, асран хамгаалагч нь зөвшөөрсөн эсэхээс үл хамааран бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх зохих мэдээллийг авах боломжоор хангах бөгөөд оролцогч улсууд эцэг эхийн зөвшөөрөлгүйгээр эмчилгээ хийлгэх боломжийг баталгаажуулах ёстой гэж заасан ч (Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 5-р зүйлд заасан) хүүхдийн өсөн нэмэгдэж буй чадварын тухай ойлголтыг ерөнхийдөө дагаж мөрддөггүй. Нөлөөллийн ажил нь өсвөр насныхны эрүүл мэндийн чиглэлээр сургагдсан мэргэжилтнүүдийн зүгээс өгсөн эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд шаардлагатай бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ, эрүүл мэдээллээр хангагдах боломжийг хүүхэд, залуучуудад олгох ёстой.

Хэдийгээр энэхүү удирдамж нь одоогийн байгаа судалгаа, нотлох баримтууд болон сургуулиас гадуурх БЦБ-ын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлсэн туршлагауд дээр үндэслэсэн боловч сургуулиас гадуурх БЦБ-ын талаарх ерөнхий болон энэхүү гарын авлагад дурдсан хүүхэд, залуучуудын тодорхой бүлгүүдийн талаарх мэргэжлийн шүүмжтэй судалгааны ном зохиол хомс байна. Ихэнх мэргэжлийн шүүмжтэй ном хэвлэлд сургууль дээрх болон сургуулиас гадуурх үйл ажиллагааг аль алиныг нь багтаасан байдаг боловч дүн шинжилгээ хийж, үр дүнг дурьдахдаа тэднийг хооронд нь ялгаатай авч үзээгүй байв. Энэ чиглэлээрх нотолгоо дутагдалтай байгаа нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- бага, дунд орлоготой улс орнуудын болон хүмүүнлэгийн орчин нөхцөл дэх нотолгоо харьцангуй бага,
- үр дүнтэй гэж үзсэн хөтөлбөрүүд яагаад үр дүнгүй байгаа, тэдгээрийг үр дүнтэй болгох гол хүчин зүйлсийн талаар дүн шинжилгээ, ойлголт хангалтгүй,
- хөтөлбөрийн чанар, түүнийг бүрэн хамарч байгаа эсэх эсвэл хэр үнэнч дагаж мөрдөж байгаа эсэх болон сургагч багш нар сургалтын үр дүнд хэрхэн нөлөөлж байгаа талаар судалгаа хангалтгүй,
- сайн чанартай технологид суурилсан боловсрол олгох тоглоомууд (үгсийн тайлбарыг үзнэ үү) болон бусад интерактив програмуудын нөлөөллийн талаарх нотолгоо

Ирээдүйд хүүхэд, залуучуудын эрүүл мэнд, сайн сайхан байдлыг хангахын төлөө сургуулиас гадуурх БЦБ-ыг дэмжих нотолгооны суурийг бүрдүүлэхийн тулд эдгээр дутагдалтай чиглэлүүдийг судлах нь чухал юм.

2. Сургуулиас гадуурх Бэлгийн цогц боловсролын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх нь

Сургуулиас гадуурх БЦБ-ын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх ихэнх үндсэн зарчим, арга барил нь ББОУАЗУ-д нарийвчлан тайлбарласан сургуулийн орчин дах БЦБ-ын хөтөлбөртэй ижил төстэй байдаг. Үүнтэй адилаар сургуулиас гадуурх БЦБ-ын үндсэн агуулга нь мөн сургуулийн орчин дах БЦБ-ын агуулгатай ижил байдаг боловч зарим хөтөлбөрүүд нь оролцогчдын онцлог хэрэгцээнд үндэслэн нэмэлт агуулгыг хамарч болно. Удирдамжийн 2.1 ба 2.2 хэсэгт сургуулиас гадуурх БЦБ-ын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэхэд анхаарах зарим асуудлыг танилцуулна. Харин 2.3, 2.4, 2.5 хэсгүүдэд үе тэнгийн сургагч багш нар болон эцэг эхчүүдийг хэрхэн татан оролцуулах, мөн сургуулиас гадуурх БЦБ-д технологийг хэрхэн ашиглах талаар авч үзнэ.

2-р хэсгийн удирдамжийг 3-р хэсэгт хэлэлцсэн хүн амын бүлгүүдэд хүргэгдсэн БЦБ-д ашиглахад зориулагдсан болно. Удирдамжийн 2-р бүлэг нь 3-р бүлэгт авч үзсэн хүүхэд залуучуудын бүлэг бүрт бүгдэд нь хамаарах БЦБ-н хөтөлбөрүүдэд хамаатай.

2.1 Хөтөлбөрүүдийг боловсруулах нь

Дэмжих орчныг бүрдүүлэх нь

Хөтөлбөрийг төлөвлөж эхлэхээс өмнө сургуулиас гадуурх БЦБ-ын дэмжлэгийг бий болгох, мөн тодорхой бүлгийн хүүхэд, залуучуудтай ажиллахад дэмжлэг үзүүлэх нь чухал. Ялангуяа БЦБ-ыг эмзэг сэдэв гэж үзэх магадлалтай эсвэл эсэргүүцэлтэй тулгарах боломжтой орон нутагт маш чухал юм. Олон нийтэд таниулах үйл ажиллагаа нь хувь хүмүүс эсвэл бүлэг хүмүүсийн аль нь ч бай дараах үйл ажиллагааг хамрах ёстой. Үүнд:

- БЦБ яагаад чухал болохыг нотолгоогоор тайлбарлаж, хөтөлбөрийн зорилгуудыг тайлбарлах
- оролцогч талуудын санаа зовниж буй асуудал, асуултуудыг (ээрэг ба сөрөг аль алиныг нь) ойлгож хариулт өгөх, БЦБ-ын бэлгийн зан үйлд үзүүлэх нөлөөллийн талаарх ташаа ойлголт, цуу яриаг тайлбарлах.

Улсын хэмжээнд (зарим тохиолдолд, орон нутгийн түвшинд хүрч хамрах бүлгүүдэд) дараах бүлгүүд багтана. Үүнд:

- хүүхэд залуучууд
- эцэг эх, асран хамгаалагчид, гэр бүлийн бусад гишүүд болон гэрлэсэн залуу эмэгтэйчүүдийн хадмууд
- залуучуудад үйлчилдэг, залуу удирдлагатай иргэний нийгмийн байгууллагууд
- олон нийтийн манлайлагчид, ж.нь. иргэний нийгмийн, шашны эсвэл уламжлалт манлайлагчид
- эрүүл мэндийн үйлчилгээ болон бусад үйлчилгээ үзүүлэгчид
- хэвлэл мэдээллийн хэрэгсэл
- хувийн хэвшил
- орон нутгийн засаг захиргааны төлөөлөгчид (жишээлбэл дүүргийн түвшинд)
- хүүхэд, залуучууд, эрүүл мэнд, эмэгтэйчүүд, жендэр, нийгмийн хамгаалал, хууль зүй, нийгмийн халамж, уугуул иргэдийн асуудал хариуцсан яамдууд, боловсрол болон албан бус боловсролын хэлтсүүд (НҮБХАС, 2014b)

Төлөвлөлт

- **Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх:** Дэмжлэг авахаар холбоо барьсан оролцогч талуудтай ижил төрлийн оролцогч талуудыг хамарч болно. Нөхцөл байдлын дүн шинжилгээ нь сургалтын хөтөлбөр боловсруулах үндэслэлийг бүрдүүлж болно. (Эмэгтэй Хүн Бүр, Хүүхэд Бүр, 2017; НҮБ-ын Хүн амын сан, 2014b). Дүн шинжилгээ нь дараах үйл ажиллагааг хамрах хэрэгтэй. Үүнд:
 - холбогдох хууль тогтоомж, бодлогод дүн шинжилгээ хийх
 - БЦБ-ын хүүхэд, залуучуудын бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндэд гарсан үр дүн, БЦБ-ын хэрэгцээтэй холбоотой үндэсний болон орон нутгийн түвшний нотолгоог цуглуулах. Үүнд ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх, эмчилгээ, тусламж үйлчилгээнд хамрагдах асуудалд хангалттай анхаарал хандуулахын тулд газарзүйн тодорхой бус нутагт болон янз бүрийн хүн амын дундах ХДХВ-ийн тархалт буюу өвчлөлийг багтаасан байх.
 - Сургуулиуд одоо хэрэгжиж буй бэлгийн боловсролын хөтөлбөрийг хянаж дутагдалтай талуудыг олж илрүүлэх.
- **Хөтөлбөрийг оролцогчдын хэрэгцээ, сонирхол, хүсэл эрмэлзэлд нийцүүлэхийн тулд тэдний бүх хэрэгцээг тодорхойлох:** Энд зөвхөн БЦБ-ын хэрэгцээнээс гадна төлөвлөгөө гаргах, зорилгоо тодорхойлох, тэдний нийгэм, эрүүл мэнд, эдийн засгийн байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн боловсрол, сургалт, хөдөлмөр эрхлэх боломж зэргийг авч үзэх шаардлагатай.
- **Хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэхэд хүн амын тодорхой бүлгийн орон нутаг дахь төлөөллийг оролцуулах:** Жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл, тэдний эрх, сайн сайхан байдлыг хамгаалагчид, хүмүүнлэгийн чиглэлээр ажиллагсад нь БЦБ-ын хөтөлбөрийн агуулга болон түүнийг орон нутагт хэрэгжүүлэх нөөц боломжоор хангаж, дэмжлэг үзүүлэх боломжтой.
- **Сургуулиас гадуурх БЦБ-ыг одоо хэрэгжиж буй хөтөлбөрүүдтэй нэгтгэх эсвэл холбох:** Үүнд жендэрийн тэгш байдал, охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлийн санаачилгууд, хөвгүүд, залуучуудыг жендэрийн тэгш байдал эсвэл бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудалд татан оролцуулах хөтөлбөрүүд, насанд хүрээгүй хүүхдийн гэрлэлтийг устгахыг сурталчлах компанит ажлууд, ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх, охидод боловсрол олгохыг сурталчлах, бэлгийн бойжилтын талаарх боловсрол олгох эсвэл өсвөр насанд хүрснийг тэмдэглэх уламжлалт зан үйл, эсвэл жендэрт суурилсан хүчирхийллийн тухай хуулийг шинэчлэн сайжруулах зэрэг багтана. (НҮБХАС, 2014b).
- **Хувь хүнд боловсрол олгох үйл ажиллагааг олон нийтийн түвшний үйл ажиллагаагаар нөхөж өгөх:** Эдгээр нь тухайн бүлэг хүмүүст нийтэд нь боловсрол олгох, хүүхэд залуучуудад тулгарч буй гутаан доромжлол, ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийг олж тогтоон шийдвэрлэхэд чиглэгдэх ёстой. Энэ нь олон нийтийн сонирхлыг нэмэгдүүлж, хөтөлбөрт хамрагдах олон төрлийн арга замыг бий болгох боломжтой юм.
- **Холбогдох үйлчилгээнүүдийн хүртээмжээр хангаж өгөх:** Төрөл бүрийн үйлчилгээнүүдтэй холбогдож, хүүхэд, залуучуудад зориулсан үйлчилгээнд зуучлах боломжтой эсэхийг болон хууль эрх зүй, нийгмийн нөхцөл байдлын хүрээнд тодорхой бүлгүүдтэй (жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, трансжендэрүүд, хүмүүнлэгийн орчинд ажилладаг хүмүүс гэх мэт) хамтран ажиллах хүсэлтэй эсэхийг ярилцах хэрэгтэй. Эдгээр үйлчилгээнд эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ, нийгмийн хамгаалал; техникийн болон мэргэжлийн сургалт; тасралтгүй сурах, хоцрогдол арилгах эсвэл албан бус боловсрол; болон хууль зүйн туслалцаа үзүүлэх үйлчилгээнүүд багтаж болно. Сургагч багш нар хүүхдүүд, залуучуудыг итгэлтэйгээр зуучилж болох шалгагдсан найдвартай үйлчилгээний жагсаалтыг гаргах.
- **БЦБ хичээлүүдийн цаг хугацаа болон давтамжийг оновчтой эсэхийг харгалзан үзэх:** Сургуулиас гадуурх БЦБ-ыг хэдэн өдрийн турш тасралтгүй үргэлжлэх дамжаа хэлбэрээр,

эсвэл тодорхой хугацааны турш долоо хоногт нэг эсвэл хоёр удаа хичээллэх, аль эсхүл энэ хоёрын хоёуланг нь хослуулан хэлбэрээр явуулж болно. БЦБ-ыг хүргэхдээ нэг дор хэдэн өдөр дараалж биш, харин долоо хоног бүр тодорхой цагаар уртавтар хугацаанд үргэлжлүүлэх тусам оролцогчдод сурч мэдсэн зүйлээ өөрийн болгож, хэрэгжүүлэх илүү их боломж олгодог. Олон удаагийн давтамжтай хичээллэх нь хичээлээр өгч буй мессежийг улам бататгах үр дүнтэй байдаг бөгөөд тухайн асуудалтай удаан хугацааны турш холбоотой байж суралцах, хандлага зан үйлээ өөрчилж эхлэх боломжийг олгодог (Нааяр нар, 2014; Маркус нар, 2017). Хөтөлбөрийг хүргэхдээ оролцогчдын амьдралын бусад асуудлуудыг тасалдуулахгүй байхаар зохион байгуулах хэрэгтэй.

Сургалтын хөтөлбөрийн агуулга

- **Сургалтын хөтөлбөрийг арга зүйтэйгээр төлөвлө:** Логик загварыг ашиглан зорилго, суралцахуйн зорилтуудыг нарийвчлан тодорхойлж, заах арга зүй болон сургалтын хөтөлбөр боловсруулах чиглэлийн мэргэжилтнүүдийг татан оролцуул. Хөтөлбөр боловсруулагчид ББОУАЗУ-ийг удирдлага болгон ажиллах ба сургалтын хөтөлбөр нь өргөн хүрээний сэдвүүдийг хамарсан байхад анхаарах ёстой. Боловсруулсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхээс өмнө туршиж үзэж, тохируулсан байх шаардлагатай (НҮБХАС, 2014b).
- **Насны онцлогт тохирсон агуулга боловсруул:** ББОУАЗУ нь янз бүрийн насны хүүхдүүд, залуучуудад чиглэсэн арга зүй, агуулгын талаар удирдамжийг өгдөг. Чанартай БЦБ-ын онцлог шинж чанар нь хүүхэд, залуучуудын өсч хөгжихийн хэрээр өөрчлөгдөж буй хэрэгцээ, чадавхийг харгалзан үзэж өмнөх сургалтад үндэслэсэн мэдээллийг танилцуулдаг.
- **Бодит мэдээлэлд суурилсан, тодорхой байх:** Хөтөлбөрт цуу яриа, хуурамч мэдээллийг засаж залруулж байх хэрэгтэй. Үүнд зөвхөн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар төдийгүй гутаан доромжлол, ялгаварлан гадуурхалтад өртөж болзошгүй бүлгүүдийн талаарх худал мэдээллийг засаж залруулах хэрэгтэй.
- **Бэлгийн амьдралыг прагматик талаас нь, шүүмжлэлгүйгээр авч үзэх:** ББОУАЗУ нь бэлгийн амьдралыг эерэг хандлагаар авч үздэг. Садар самуун, бэлгийн олон хавьтагчтай байх, сексийн чиглэлийн ажил эрхлэх зэрэг асуудлуудыг авч үзэхдээ бодит мэдээлэлд суурилсан, прагматик байдлаар хандах хэрэгтэй.
- **Хүмүүс бусад газруудаас юу сурч авч байгаад анхаарлаа хандуул:** Сургалтын хөтөлбөрт оролцогчдын БЦБ-ын талаар албан болон албан бус эх сурвалжаас хүлээн авч байгаа мэдээллийг харгалзан үзэх ёстой. Мөн эрэгтэйлэг шинж байдал болон эмэгтэйлэг шинж байдалд хандах хандлагад нийгмийн сүлжээ эсвэл хэвлэл мэдээлэл хэрхэн нөлөөлж байгаа, мөн садар самууныг сурталчилах материалын хүртээмжтэй байдал, түүний бэлгийн зан үйл хандлагад нөлөөлөх нөлөөллийг харгалзан үзэх ёстой бөгөөд ялангуяа хор хөнөөлтэй байж болзошгүй материалуудыг түүштэй, идэвхтэй эсэргүүцэх эсвэл хор хөнөөлийг нь багасгах стратеги агуулсан байх ёстой (Браун ба Л'Энгл, 2009; НҮБХС, 2017).
- **Соёлын хувьд нийцтэй байх:** Олон үндэстэн, олон соёлтой газарт сургалтын хөтөлбөр нь зөвхөн давамгайлсан соёлыг бүс бүх соёлыг төлөөлж байх ёстой. Агуулга нь тухайн соёлтой нийцтэй байх ёстой боловч хор хөнөөлтэй уламжлалт зан заншил, соёлоос үүдэлтэй хүний эрхийн зөрчлүүдийг үл тоомсорлож, хэрэгсэхгүй орхиж болохгүй.
- **Сургалтын хөтөлбөрийг оролцогчдын хүйсээс хамааран тэдний онцлог хэрэгцээнд нийцүүлэн боловсруулах:** Жишээлбэл, охидын жендэрт суурилсан хязгаарлалтыг багасгах, сул талуудыг арилгахын тулд чадваржуулах аргачлал нь охидын эрхийн талаарх мэдээллийг агуулсан байх ба өөрсдийн эрхийг хэрхэн хангах, бие даасан байдал, өөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа буюу зөвлөн туслах, спортийн үйл ажиллагаа зэргийг багтаасан байж болно. Хөвгүүдэд эрэгтэй хүмүүст нийгмээс олгосон давуу эрх, эрх мэдлийг таньж мэдэх боломж олгохын зэрэгцээ эрэгтэйлэг шинж ба эмэгтэйлэг шинж байдлын талаарх тогтсон хэвшмэл

ойлголтуудыг няцаахад нь дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн байх хэрэгтэй (Кагестен нар, 2016). Сургуулиас гадуурх БЦБ-ын бүх хөтөлбөрүүд нь хор хөнөөлтэй жендэрийн хэвшмэл ойлголтууд, бүсдэг хүйс, бэлгийн чиг баримжаа, хүйсийн тодорхойлолтоос нь хамааран системчилсэн ялгаварлан гадуурхах явдлыг эсэргүүцэхэд шаардлагатай жендэр, хүмүүсийн олон янз байдал, хүний эрхийн талаарх ойлголтыг өгөх агуулгыг багтаасан байх ёстой.

- **Оролцогчдод нөхцөл байдлын улмаас тулгарч буй эрсдэлт хүчин зүйлсийг авч үзэх:** Эдгээр хүчин зүйлсэд жендэрийн хүчин зүйлсээс гадна ядуурал, арьс өнгө, үндэс үгсаа, шашин шүтлэг, хөгжлийн бэрхшээл, нийгэм эдийн засгийн нөхцөл байдлаар нь ялгаварлан гадуурхах зэрэг багтана.
- **Нөлөөллийн ажил хийх талаар зааж өгөх:** Нөлөөллийн ажил нь суралцагчдыг өөрсдийнхөө амьдралд нөлөөлж, нийгэмдээ манлайлагч болох боломжийг олгодог. Иргэний оролцоо, нөлөөллийн үндсэн үр чадваруудын талаарх модулиуд нь хүүхэд, залуучуудад хичээл дээр сурч мэдсэн зүйлээ өөрсдийн амьдарч буй илүү өргөн хүрээний ертөнцтэй холбож, өөрсдийн орон нутагтаа эерэг өөрчлөлт хийх бодит боломжийг олгодог. Гэсэн хэдий ч нөлөөллийн үйл ажиллагааг сурталчлах эсэх талаарх шийдвэрийг гаргахдаа үргэлж нийгмийн болон хууль эрх зүйн нөхцөл байдлаас хамааралтай авч үзэх ёстой, учир нь зарим газарт хүүхэд, залуучуудыг бусдад нөлөөлөхийг хуулиар хориглосон эсвэл тэдэнд аюултай байж болно. Ямар ч нөхцөлд оролцогчид нөлөөллийн ажилд оролцох эсэхээ өөрсдөө чөлөөтэй сонгох боломжийг олгох ёстой.

2.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь

Сургагч багш нар

Сургагч багш нь насанд хүрэгчид, насанд хүрсэн залуучууд, үе тэнгийнхэн, эрүүл мэндийн мэргэжилтнүүд эсвэл эцэг эх байж болно (Пообалан нар, 2009).

- Насанд хүрсэн сургагч багш нар нь амьдралын туршлагатай, итгэж болохуйц байр суурьтай, сэдвүүдийг гүнзгийрүүлэн судалж, эмзэг сэдвээр хэлэлцүүлэг удирдан зохион байгуулах чадвартай учраас оролцогчид илүү үнэлж магадгүй. Тэд мөн олон нийтийн дунд нэр хүндтэй байж болох тул ингэснээрээ оролцогчдын аюулгүй байдал, өөртөө итгэх итгэлд дэмжлэг болж чаддаг.
- Оролцогчдоос цөөн насаар ах, үе тэнгийнхэн болон залуучууд нь үр дүнтэй сургагч багш болохоос гадна үлгэр дууриалал болж чаддаг. Гэсэн хэдий ч насанд хүрсэн сургагч багштай харьцуулахад тэд багшлах туршлага багатай тул тэднийг үр дүнтэй чиглүүлэгч багш болгохын тулд сургалтанд хамруулах, мэргэжлийн удирдагчаар хангах, дэмжлэг үзүүлэх нь нэн чухал юм.
- Сургуулиас гадуурх БЦБ-ыг олгох эрүүл мэндийн мэргэжилтнүүдийг бусад чиглүүлэгч багш нарын адил сургалтанд хамруулах ёстой. Тэдний мэргэжлийн суурь мэдлэг нь БЦБ, сурган хүмүүжүүлэх эсвэл хүүхэд залуучуудтай харилцах, сургалтыг идэвхжүүлэх арга зүйг бүрэн хамардаг гэж үзэж болохгүй.
- **Сургагч багш нар соёлын хувьд мэдрэмжтэй, оролцогчидтой ойлгомжтойгоор харилцаж чаддаг эсэхийг баталгаажуулах:** Хэрэв сургагч багш нь нийгмийн өөр анги давхарга эсвэл орчин нөхцлөөс гаралтай бол оролцогчдод амархан ойлгохуйц, тэдэнтэй холбоо хамрааралтайгаар ярьж чаддаг байх ёстой.
- **Тодорхой бүлэг хүүхэд, залуучуудын (тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ХДХВ-ийн халдвартай хүмүүс гэх мэт) сургагч багш нарыг сонгохдоо тухайн ижил төрлийн олон нийтийн бүлгээс сонгохыг хичээ:** Хэрэв сургагч багш нар оролцогчидтой ижил төстэй шинж чанарыг агуулаагүй бол тэд оролцогчдын хэрэгцээ шаардлагыг бүрэн ойлгож,

тэдгээр хүүхэд залуучуудын туршлага, үзэл бодолд нээлттэй хандах ёстой.

- **Сургагч багш нарыг шалгаруулахдаа үр чадвараас гадна хувь хүний шинж чанаруудыг нь үнэлэх:** Үр чадвартай сургагч багш нар хүүхэд, залуучуудыг үнэн сэтгэлээсээ ойлгодог, тэдэнд бэлгийн амьдралын талаар заах хүсэл эрмэлзэлтэй, тэдэнд халуун дулаан, шүүмжлэлгүйгээр ханддаг байх ёстой. Тэд БЦБ-ын олон төрлийн агуулгуудыг заахад бэлэн, БЦБ-ыг хэрхэн үр дүнтэй хүргэх талаар суралцах эрмэлзэлтэйгээ харуулах хэрэгтэй.
- **Сургагч багш нарыг сургалтын хөтөлбөрийн бүхий л агуулгыг заах талаар сургах:** Тэд хамтран ажиллаж буй бүлгүүдийнхээ ойлголтыг нэмэгдүүлж, хөтөлбөрийн оролцогчдын санал хүсэлтийг тусган, байнгын мэргэжлийн хяналт дэмжлэг үзүүлж байх ёстой. Дэлгэрэнгүй мэдээллийг 2.3-р хэсгийн Сургалт ба Хяналт дэмжлэг, ББОУАЗУ, х.95-аас үзнэ үү.
- **Сургагч багш нарт тасралтгүй сургалт явуулж байх:** Сургагч багш нарын мэргэжлийн хөгжлийг дэмжих, чадавч бэхжүүлэх боломжууд болон платформууд нь тэднийг чанартай БЦБ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нь дэмжлэг болдог. Ажлын байрны өндөр чанартай тусламж дэмжлэг, хэрэгжилтийн арга хэрэгслийг боловсруулж, хөтөлбөрийг шинэчилсэний дагуу хэрэгжүүлж буй эсэх, холбогдох агуулгыг хамарч байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж байх ёстой.

Багшлах, суралцах арга барилууд

- **Бусад арга барилуудын давуу талыг ашигла:** Үр дүнтэй багшлах болон суралцахад олон төрлийн, интерактив аргуудыг ашиглахыг шаарддаг. Үүнд оюун санаагаа уралдуулах, хэлэлцүүлэг хийхээс эхлээд эргэцүүлэл, дүн шинжилгээ хийх, дүрд тоглох, кейс судалгаа хийх, жижигчилсэн бүтээлүүд болон бүтээлээ хийх төслүүд гэх мэт олон янзын хэлбэртэй байж болно. Биеийн хөдөлгөөнийг дэмждэг дүрд тоглох болон театрчилсан тоглолтын арга эсхүл оролцогчдын сэтгэл хөдлөлийг илрүүлэх арга буюу тухайлбал сэтгэл хөдлөм түүхээ хуваалцах зочин илтгэгчийг урих нь хувь хүмүүсийн ойлголт, зан үйлийг өөрчлөхөд илүү үр дүнтэй байдаг (ЮНЕСКО, ДОХ-той тэмцэх НҮБ-ын хөтөлбөр, НҮБ-ын Хүн амын сан, НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-Эмэгтэйчүүд ДЭМБ, 2018; Пообалан нар, 2009). Мэдлэг, хандлага, үнэт зүйл, үр чадварыг бие даасан хичээл дээр ярихаас илүүтэйгээр аль болох сэдэв болгонтой үялдуулах хэрэгтэй.
- **Хүртээмжтэй тэгш хамруулах:** Бүх хүнийг хүндэтгэх хандлагыг бий болгож, үүнийг биеэрээ үлгэрлэх. Бүх сэдвүүдийн хөндөж буй жишээ, төсөөлөл, хувь хүний түүх, дүрд тоглох, зочин илтгэгчид зэрэг нь бүх бүлгийн төлөөлөл оролцогчид болон олон төрлийн хувь хүний харилцааг багтаасан байх ёстой. Хүмүүсийн олон талт байдал, өрөөсгөл хандлага, гутаан доромжлол, ялгаварлан гадуурхлын үр дагаварын талаар шулуун шударгаар зааж өг. Аль болох олон хүнийг хамруулах боломжтой уян хатан хичээлийн цагийг санал болгоорой.
- **Чадваржуулахад чиглэсэн арга хандлагыг ашиглах:** Энэхүү гарын авлагад тайлбарласан ихэнх оролцогчид ялгаварлан гадуурхагдсан, аливаа нэг дарлалд өртсөн бүлгийн хүмүүс байдаг. Шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэх сурган хүмүүжүүлэх арга зүй (Нэр томьёоны тайлбарыг үзнэ үү) нь сурган хүмүүжүүлэгчид болон суралцагчид хамтран суралцах сургалтын үйл явцаар дамжуулан харилцан бие биенээсээ суралцаж, асуудал ба бэрхшээлийг хамтдаа даван туулах шинэ арга хэлбэрийг боловсруулах замаар ийм бүлгийн хүүхэд, залуучуудыг чадавхижуулж чадна гэж үздэг. Шүүмжлэлт сурган хүмүүжүүлэх арга зүй нь тухайн олон нийтийн амьдралын туршлагад суурилан хүмүүсийг чадваржуулж, олон нийтийн эв нэгдлийг бий болгодог.

- **Сэтгэцийн өөрчлөлтийг харгалзсан арга барилыг ашигла:** Зарим хүүхэд, залуучууд ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл (үүнд, бэлгийн хүчирхийлэл), гэр бүлийн зөрчил, зэвсэгт мөргөлдөөн эсвэл бусад хүмүүнлэгийн хямралаас улбаалан хувь хүнийхээ хувьд эсвэл тодорхой бүлгийн гишүүнийхээ хувьд сэтгэцийн гэмтэл авсан байж болзошгүй. Ийм сэтгэцийн өөрчлөлт нь үе дамжин ирсэн ч байж болох юм. Сэтгэлийн гэмтлийг харгалзан үзсэн арга хандлага нь бэлгийн амьдралын талаар заахдаа сэтгэцийн цочролд орсон түршлагатай холбоотой мэдрэмж, дурсамжийг өдөөж (сэдрээж), оролцогчиг дахин цочролд оруулахгүй байх аргачлалаар заадаг. Сэтгэл зүйн эмгэгт суурилсан арга хандлагын мөн чанар нь нээлттэй, аюулгүй, энэрэнгүй орчин, бүлгийн соёлыг бий болгох явдал юм. Хичээлүүдийн эхэнд тухайн хичээлийн агуулгыг заавал урьдчилан танилцуулж байх хэрэгтэй ба ингэснээр оролцогчид тухайн хичээлд оролцох эсэхээ сонгож боломжтой болох буюу хичээлийг дараа тухайн агуулгатай танилцахад хялбар байхаар түгээх хэрэгтэй.³
- **Сонирхолтой, хувь хүний онцлогт тохирсон аргуудыг ашигла:** Зураг, зурагт хуудас, видео бичлэгийг ашиглаж, хэвлэмэл гарын авлага материалын хэрэглээг багасгах хэрэгтэй. Оролцогчдод үе тэнгийнхэнтэйгээ ярилцах боломжийг олгодог хэлэлцүүлэгт суурилсан арга зүй нь хүн амын тодорхой бүлгийн зарим залуучуудад тохиолдож болзошгүй нийгмээс өөрийгөө тусгаарлах байдлыг арилгахад тусалдаг.
- **Оролцогчид өөрсдийгөө юу мэддэг гэж бодож байгааг тодруулах аргуудыг ашигла:** Тэднээс юу мэдэж сурсан, тэдгээрийг ямар мэдээллийн эх сурвалжаас сурч авсанаа хуваалцахыг хүс, эсвэл үнэн/худал асуултууд болон тоглоомыг ашигла. Энэ нь сургагч багш нарт оролцогчдын мэдэж авсан буруу ойлголт, худал мэдээллийг олж тогтоох, засаж залруулах боломжийг олгоно.
- **Аль болох оролцогчдын эх хэлийг ашиглах:** Энэ нь оролцогчдод эмзэг эсвэл хувийн асуудлаа ойлгож, хэлэлцүүлэг өрнүүлэхэд нь дэмжиж өгдөг.
- **Оролцогчдын бичиг үсгийн түвшинг анхаарч үзэх:** Сургуулиас завсардсан хүүхэд, залуучууд бичиг үсэг тайлагдалтын түвшин доогуур эсвэл бичиг үсэг мэдэхгүй байж болно. Иймээс унших, бичихтэй холбоотой үйл ажиллагааг багасгах шаардлагатай. Үүний оронд түүх ярих, дүрд тоглох, хэлэлцүүлэг, зураг, видео, график гэх мэт бодит амьдралаас суралцах болон оролцооны аргуудыг ашиглах хэрэгтэй. Эсрэгээр бичиг үсгийн боловсрол олгох хөтөлбөрүүд нь сурагчдын бичиг үсгийн түвшинд тохируулсан бэлгийн боловсролын агуулгыг оруулж өгөх нь чухал ач холбогдолтой эхлэлийн цэг байж болох юм.
- **Оролцогчдыг асуулт асуух боломжоор хангах, үүнд тэдний асуухаас ичдэг байж болох асуултуудыг ч гэсэн багтаах:** Нэрээ нууцалсан асуултын хайрцаг (оролцогчид бичиг үсэг тайлагдсан бол) нь хүүхэд залууст айдас, ичгүүргүйгээр асуулт асуух боломжийг олгох ашигтай арга байж болох юм.
- **Оролцогчдод сурч мэдсэн зүйлээ өөрийн болгох, практикт хэрэгжүүлэх хугацаа олго:** Эргэцүүлэн бодох цаг олгох, хэлэлцүүлэг, дүрд тоглох, нэг хичээлийн үед болон хэд хэдэн хичээлүүд дээр мэдээллийг давтах нь хүүхэд, залуучуудад шинээр мэдэж авсан материал, үзэл санааг өөрийн болгож, ойлгоход нь тусална.
- **Оролцогчдод сурч мэдсэн зүйлээ амьдралдаа хэрэгжүүлэхэд нь туслах:** Хүүхэд, залуучуудыг хүлээн авсан мэдээллээ өөрсдийн амьдрал, бусадтай бий болгосон харилцаа, шийдвэр гаргахдаа хэрхэн ашиглах талаар бодохыг уриал. Үүнийг зургаар илэрхийлсэн удирдамжаар

дүрслэх, тэмдэглэл бичих, зураг зурах, зургуудыг тайлбарлаж өгөх эсвэл бүлгийн хэлэлцүүлгээр хийж болно. Гэсэн хэдий ч сургагч багш нар бэлгийн болон бэлгийн эрүүл мэндийн талаарх мэдээллийг өгөхдөө үүсч болзошгүй сэтгэцийн гэмтлийн талаар мэдрэмжтэй байх нь чухал юм (сэтгэцийн гэмтэлд мэдрэмжтэй арга хандлагын талаарх мэдээллийг 14-р хуудаснаас үзнэ үү).

- **Оролцогчдыг өөрсдийн шийдлийг боловсруулахыг уриалах:** Оролцогчдоос өөрсдийнхөө эрсдлийг бууруулах цэс эсвэл аль болох олон төрлийн хувилбаруудыг гаргахыг хүсэх нь эрх мэдэлтнүүдийн боловсруулсан, тэдний хувьд хэрэгжүүлэх боломжгүй шийдлүүдийг биш харин үнэхээр ашиглаж болохуйц стратегиудыг тодорхойлоход нь тусална. (ЮНЕСКО нар, 2018). Ийм байдлаар хүүхэд, залуучууд бие биенийхээ үе тэнгийн үлгэр дууриал болж, шинээр олж авсан мэдлэгтээ үндэслэн зан үйлээ өөрчлөх нь тухайн бүлгийн зан үйлийн хэм хэмжээ болж, суралцахуйд эерэгээр нөлөөлдөг.
- **БЦБ-ыг олгохдоо соёлын хувьд аюулгүй байдлаар хүргэх:** Соёлын аюулгүй байх тухай ойлголт нь соёлын мэдрэмжтэй байх тухай ойлголтоос илүү өргөн хүрээтэй. Үүнд эрх мэдлийн тэнцвэргүй байдал, институцийн ялгаварлан гадуурхалт, колоничлол ба колоничлогчидтой ямар харилцаатай, нийтлэг соёл иргэншил, болон тэдгээрийн эрүүл мэндийн боловсрол, үйлчилгээнд хэрхэн ашиглагддаг талаар дүн шинжилгээ хийх зэрэг багтана. Соёлын аюулгүй байдал нь хүүхэд залуучуудын бие бялдар, оюун санаа, сэтгэцийн болон сэтгэл хөдлөлийн хоорондын холбоог таньж мэдэхэд маш чухал үүрэг гүйцэтгэдэг.

Аюулгүй байдал, хамгаалал ба нууцлал

- **Аюулгүй орон зайг бий болгох:** Аюулгүй орон зай (дэлгэрэнгүй тодорхойлолтыг тайлбар толь хэсгээс үзнэ үү) нь бие махбодын болон сэтгэл санааны аюулгүй байдлыг хангаж, хамгаалж, оролцогчдод бухимдал, бэрхшээлийнхээ талаар ярих боломжийг бий болгохоос гадна өдөр тутмын амьдралдаа зарим зүйлийг өөрөөр хийх боломжийг олгоно.
- **Аюулгүй байдал, аюулгүй байдлаа хамгаалах талаар маш тодорхой үндсэн дүрмийг бий болгох:** Энэ нь ялангуяа олон нийтийн гишүүд эсвэл цагдаагийн байгууллагын хавчлага, ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэлд өртөмтгий хэсэг бүлэг хүүхэд, залуучуудын хувьд чухал ач холбогдолтой юм. Аюулгүй байдлыг хангах үндсэн дүрэмд дараах зүйлс багтана. Үүнд: бусад оролцогчдын мэдээллийн нууцлах (өөрөөр хэлбэл оролцогчдын хэн болохыг эсвэл тэдний хэлсэн зүйлсийг оролцогч бус хүмүүст мэдээлэхгүй байх); зөвшөөрөлгүй зураг авахуулахгүй байх, нүүр царай нь гарсан аливаа зургийг байршуулах, бусадтай хуваалцахгүй байх; нэр болон байршлыг дурдахгүй байх, үүний талаар нийгмийн сүлжээнд мэдээлэл оруулахдаа анхаарах; зөвхөн таньдаг хүмүүстээ хөтөлбөрийн талаар мэдээлэл өгөх; хүмүүс байнгын холбоотой байхыг хүсвэл мессенжерийн бүлэг, чат эсвэл “нууцлалтай фейсбүүк бүлэг”-ийг ашиглах (гэхдээ аюулгүй гэж байгаа програмууд ч гэсэн үнэхээр хувийн, нууц биш, худал мэдээлэл агуулж болзошгүйг анхаарах); тэдний зөвшөөрөлгүйгээр хэн нэгний талаар ямар нэг зүйл хэзээ ч нийтлэхгүй байх.
- **Оролцогчдын хувийн орон зай, биеийн хил хязгаарыг хүндэтгэх:** Оролцогчдыг үе тэнгийнхэн эсвэл сургагч багш нар тэвэрч, энхрийлж, массаж хийж, үнсэж, илж таалж болохгүй.
- **Бэлгийн хүчирхийлэл, дарамтыг мэдээлэх талаар хэлэлцэх үед, оролцогчид хүчирхийллийн талаар мэдээлэх боломжтой хэн нэгнийг ойр байлгах:** Хэрэв гол холбоо барих хүнийг байлцуулах боломжгүй бол оролцогчид хэнд хандах ёстойгоо маш тодорхой ойлгосон байхад анхаар.

³ Дэлгэрэнгүй мэдээллийг Сэтгэцийн гэмтэлд өртсөн оюутнуудад үзүүлэх дэмжлэг: SSET хөтөлбөр, Бүлгийн ахлагчийн сургалтын гарын авлага, хичээлийн төлөвлөгөө, хичээлийн хэрэглэгдэхүүн, ажлын хуудас (RAND, 2009), Сэтгэцийн гэмтэлд суурилсан бэлгийн боловсрол олгох гарын авлага (CARDEA, 2016) –с үзнэ үү.

- **Мэдээллийн нууцлалын ач холбогдол, хязгаарлалтын талаар маш тодорхой тайлбарлах:** Хөтөлбөрийн хүрээнд мөрдөх нийтлэг журмууд нь бүх оролцогчид мэдээллийн нууцлалыг хадгалах үүрэгтэй гэдгийг онцолж, энэ нь жинхэнэ утгаараа юу гэсэн үг болохыг тодорхой тайлбарлаж өгөх ёстой. Түүнчлэн сургагч багш нар оролцогчдын хувийн мэдээлэл, тэдний хэлсэн үгсийн талаарх нууцлалыг хадгалах нь зайлшгүй чухал юм. Зарим тохиолдолд үүнийг хийгээгүйгээс болж тэдний аюулгүй байдал, аюулгүй байдлаа хамгаалахад эрсдэл учруулж болзошгүй юм. Гэхдээ сургагч багш нар зарим тохиолдолд насанд хүрээгүй хүүхдийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс оролцогчдоос авсан мэдээллийг эрх мэдэл бүхий холбогдох байгууллагатай хуваалцах үүргийг хуулийн дагуу хүлээдгийг оролцогчдод тайлбарлах ёстой.

Хяналт шинжилгээ

- **Байнгын хяналт шинжилгээ, үнэлгээг оруулж өгөх:** Хөтөлбөрийн агуулгыг хэрхэн хүргэж буй түршлага, оролцогчдын санал хүсэлтийг үндэслэн тогтмол хянаж, шинэчилж байх ёстой. Хөтөлбөрийг анхнаас нь орц, үйл явц, гарцын мониторинг, үнэлгээг тогтмол хийж байх ёстой бөгөөд ингэснээр хэрэгжүүлэгчид олон нийтийн болон үндэсний түвшинд гарч буй өөрчлөлтүүдэд үндэслэн хөтөлбөрөө боловсронгуй болгож, тохируулга хийх боломжтой болно.
- **Сургагч багш нар хөтөлбөрийг үнэнчээр хэрэгжүүлж буй эсэхэд хяналт тавих:** Энэ нь хөтөлбөрийн агуулга, арга зүй, үнэ цэнэ зэрэгтэй холбоотой.
- **Хөтөлбөрт оролцогчдыг сургалтын дараах судалгааг хэрхэн хийх аргыг эхнээс нь тодорхойлох:** Сургуулийн орчин дахь хөтөлбөртэй харьцуулахад сургуулиас гадуурх хөтөлбөрүүдийн оролцогчдын мөшгих судалгааг хийхэд илүү төвөгтэй байж болох дараах асуудлуудыг авч үзэх хэрэгтэй. Үүнд: хөтөлбөрийн хэчнээн хувийг оролцогч бүрт хүргэсэн болох; зарим хүүхдүүд, залуучууд олон хичээлүүдээс бүрдсэн хөтөлбөрт хамрагдаж байгаа эсэх; хөтөлбөрийг оролцогчидтой хамтран урт хугацаанд үнэлэх.

Үндсэн баримт бичиг ба сургалтын хөтөлбөр

- Сургуулиас гадуурх бэлгийн цогц боловсролын ашиглах материалын багц (НҮБХАС, 2018)
- НҮБ-ын Хүн амын сангийн Бэлгийн боловсролыг хэрэгжүүлэх удирдамж: Хүний эрх ба жендэрийн асуудалд анхаарлаа хандуулах нь (НҮБХАС, 2014)
- Бэлгийн цогц боловсролын хөтөлбөрүүдийн үнэлгээ: Жендэр ба чадваржуулах үр дүнд анхаарлаа хандуулах нь (НҮБХАС, 2015)
- Гэр бүл төлөвлөлтийн олон улсын холбоо /ГБТОУХ/. Бэлгийн цогц боловсролын хүрээ (ГБТОУХ-IPPF, 2010)
- Бэлгийн цогц боловсролын үнэлгээний арга хэрэгсэл: Дотор болон гадна тал: (ГБТОУХ-IPPF, 2015)
- Бүгд нэг сургалтын хөтөлбөр болох нь: Бэлгийн амьдрал, жендэр, ХДХВ ба хүний эрхийн боловсролын нэгдсэн хандлагын удирдамж ба үйл ажиллагаа (Хүн ам зүйн зөвлөл, 2009)
- ДЭМБ-аас өсвөр насныхны бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн талаарх зөвлөмж (ДЭМБ, 2018)
- Өсвөр насныханд зориулсан эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээний олон улсын стандарт (ДЭМБ, 2015)
- Өсвөр насны охид ба залуу эмэгтэйчүүд дунд ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх нь: Өсвөр насны охид, залуу эмэгтэйчүүдийн дунд ХДХВ-ийн халдвараас

урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, эрэгтэйчүүд ба хөвгүүдийг татан оролцуулах нь (ДОХ-той тэмцэх НҮБ-ын хөтөлбөр, 2016)

- *Европ дахь бэлгийн боловсролын стандартууд: Бодлого боловсруулагчид, боловсрол ба эрүүл мэндийн удирдах байгууллагууд, мэргэжилтнүүдэд зориулсан хүрээ* (ДЭМБ-ын Европын бүсийн оффис ба Германы холбооны улсын Эрүүл мэндийн боловсролын төв /BZgA/, 2010)

2.3 Сургуулиас гадуурх БЦБ-д үе тэнгийн сургагчдыг оролцуулах нь

Үе тэнгийн сургагч гэдэг нь оролцогчидтой ижил түвшний буюу нас, суралцаж буй анги, нийгмийн байдал болон бусад шинж чанараараа ижил нийгмийн бүлэгт багтдаг хүмүүс бөгөөд өөрийн ижил бүлгийн бусад гишүүдийн дунд эерэг өөрчлөлтийг бий болгоход сургагдсан, энэ чиглэлээр дэмжлэгт хамрагдсан хүмүүс юм. Хүүхэд, залуучуудийн хувьд нас, хүйс, жендэр зэрэг нь ихэвчлэн үе тэнгийнхэн гэж тооцогдох гол шалгуур байдаг боловч зарим тохиолдолд бусад нийтлэг шинж чанарууд, тухайлбал тэдний тодорхойлсон бүлэг эсвэл бүлгүүд илүү ач холбогдолтой байж болно. Үе тэнгийнхэн нь мэдээллийг өгөхдөө бусад аргуудаас гадна ганцаарчилсан ярилцлага, бүлгийн хэлэлцүүлэг, гарын авлага материал тараах, зөвлөгөө өгөх ба тоглоом тоглох зэргээр хүргэж болох ба түүнчлэн үйлчилгээнд зүүчилж, сурталчилгааны ажлыг манлайлж, олон нийтийг дайчлах үйл ажиллагааг удирдан зохион байгуулахад тусалж болно (ДОХ-той тэмцэх НҮБ-ын хөтөлбөр, 1999).

Үе тэнгийн боловсрол нь цогц арга хэмжээний хүрээнд явуулбал илүү үр дүнтэй байх ба үе тэнгийн сургагч багш нарын чиг үүрэг нь ойлголт мэдрэмжийг дээшлүүлэх, мэргэжилтэн болон үйлчилгээнд холбон зуучлахад чиглэсэн байвал илүү үр дүнтэй байж болох юм (Чандра-Мули нар, 2015a). Үе тэнгийн сургагч нар мэргэжлийн багш нартай хамтран хөтөлбөрийг хүргэх боломжтой. Үе тэнгийн боловсрол нь ялангуяа дараах тохиолдолд ашиг тустай байж болох юм. Үүнд:

- мэргэжлийн багш нарын удирдсан хөтөлбөрүүд байхгүй эсвэл хүртээмжгүй тохиолдолд
- бэлгийн амьдралын талаар ярилцах үед, насанд хүрэгчид залуучуудын хэрэглэдэг үг хэллэг, болон өвөрмөц хэл ярианы талаар мэдлэггүй байх тохиолдолд
- мэргэжлийн хүмүүс эсвэл суралцагчдын үе тэнгийн бүлгийн гишүүн биш бусад хүмүүст итгэхээс илүүтэйгээр, үе тэнгийнхэндээ илүү итгэдэг байх тохиолдолд, жишээлбэл: өнгөрсөнд болон одоо үеийн бүрүү харилцаа хандлага, ялгаварлан гадуурхалтыг төлөөлж буй хүмүүсийг үл итгэсэн байдлаар хүлээж авдаг хүүхэд, залуучуудийн дунд; эсхүл тухайн бүлгийн гишүүн биш хүмүүс соёл, хэл яриа, амьдралын түршлагын хувьд саад бэрхшээлтэй тулгарч болзошгүй угсаатны бүлгүүдийн хувьд.

Судалгаанаас үзэхэд үе тэнгийн боловсрол нь мэдлэгийг нэмэгдүүлж, зарим тохиолдолд хандлага, хүсэл эрмэлзлийг өөрчилдөг боловч энэ нь бэлгэвч хэрэглэх эсвэл жирэмслэхээс хамгаалах бусад хэрэгслийг ашиглах зэрэг зан үйлд чухал нөлөө үзүүлдэггүй нь тогтоогдсон (Ким ба бусад, 2008; Медли ба бусад, 2009; Пообалан нар, 2009; Салам нар, 2016; Толли, 2012). (Эдгээр судалгаануудын аль нь ч ижил насны үе тэнгийн сургагч багш нараас үе тэнгийнхэндээ олгосон БЦБ-ын талаар тусгайлан авч үзээгүй болохыг тэмдэглэх хэрэгтэй; нэг судалгаа нь үе тэнгийнхний удирдсан өсвөр насныхны

“бэлгийн эрүүл мэндийн боловсрол” -ын талаар авч үзсэн боловч ямар агуулгыг заасан талаар судалгаанд дурдаагүй болно.) Үе тэнгийнхний боловсролын үр нөлөө нь зарим хүн амын бүлэгт, тухайлбал хар тамхи, мансууруулах бодис хэрэглэдэг хүмүүс, секс ажилчид зэрэг бүлэгт илүү үр нөлөөтэй байгаагаас харахад үе тэнгийнхний боловсрол нь нийгмийн гадуурхагдсан эсвэл далд оршдог хүн амын бүлэгт илүү үр дүнтэй байж болохыг харуулж байна (Беккер ба Хосек, 2015; Кришнаратне нар, 2016; ДЭМБ, 2017b). Цаашид зарим үе тэнгийнхний боловсролын хөтөлбөр нь бусдаас яагаад илүү үр дүнтэй байдаг талаар илүү нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай байгаа бөгөөд мөн өөр өөр сургагч багш нар, тухайлбал сайтар сургагчдсан бэлгийн боловсролын насанд хүрсэн сургагч багш нар заахын ялгаатай байдал, үр нөлөө, үр дүнтэй байдлыг харьцуулсан судалгаа шаардлагатай хэвээр байна (Толли, 2012; Вилла-Торрес ба Сванемыр, 2015).

Хөтөлбөрийн төлөвлөлт ба боловсруулалт

- **Олон нийтийн хэрэгцээний үнэлгээг хийх:** Энэ нь сургуулиас гадуурх БЦБ-ын бүх хэлбэрийн хөтөлбөрийг боловсруулахад зайлшгүй шаардлагатай салшгүй нэг хэсэг боловч үе тэнгийн сургагч багш нараар удирдуулсан хөтөлбөрүүдэд ихэвчлэн орхигддог. Үе тэнгийн боловсролыг өргөжүүлэх гэдэг нь энгийн нэг хуулбарлах үйл явц биш тул ийм үнэлгээ зайлшгүй чухал ач холбогдолтой юм. Үүнд шинэ орчин нөхцөл бүрийн хувьд үе тэнгийн боловсролд тус болох эсвэл саад болж болзошгүй хүчин зүйлсийг тодорхойлохын тулд нийгмийн нөхцөл байдлыг үнэлэх шаардлагатай болдог (ДОХ-той тэмцэх НҮБ-ын хөтөлбөр, 1999).
- **Үе тэнгийн сургагчдын зорилтот бүлгийг нарийвчлан тодорхойлох:** Үүнд нас, хүйс, арьсны өнгө, үндэс угсаа, бэлгийн чиг баримжаа, нийгэм эдийн засгийн хүчин зүйл, орон нутгийнхны нөлөө зэргийг харгалзан үзэх шаардлагатай (ДОХ-той тэмцэх НҮБ-ын хөтөлбөр, 1999).

Үе тэнгийн сургагч багш нарыг сонгох нь

- **Сонгон шалгаруулалтын шалгуурыг нэр дэвшигчдэд тодорхой тайлбарлаж өгөх:** Үе тэнгийн сургагч багш нарыг зорилтот бүлгийн залуучуудын гол онцлог шинж чанаруудтай (нас, боловсролын түвшин, хүйсийн илэрхийлэл, бэлгийн чиг баримжаа, ХДХВ-ийн статус, үндэс угсаа, шашин шүтлэг, хичээлийн сонголт, сонирхол болон хичээлээс гадуурх үйл ажиллагаанууд) нийцүүлсэн байх ёстой. Тэд харилцааны соёлтой, үр чадвартай, нэр хүндтэй, харизматик, бусдын үзэл бодлыг хүндэлдэг удирдагчид байх ёстой. Тэд хөтөлбөрийн үнэ цэнийг бүрэн ухамсарласан, хувь нэмрээ оруулахыг хүсдэг байх хэрэгтэй.
- **Өргөн хүрээний боломжит нэр дэвшигчдийн дундаас үе тэнгийн сургагч багш нарыг сонгох:** Нэр дэвшигчдийг зараар хариу ирүүлэхийг хүлээхээс илүүтэйгээр тэднийг нийгмийн сүлжээн дэх олон нийтийн дундаас тодорхойлох гэх мэт олон төрлийн аргуудыг ашигла. Сонгон шалгаруулалтыг ил тод, шударгаар явуулах ёстой бөгөөд зорилтот бүлгийн хүүхэд, залуучууд өөрсдийн манлайлагч, үлгэр дуурайлал гэж үздэг хүмүүсээ сонгоход оролцох ёстой.

Сургалт зохион байгуулах, удирдан дэмжих

- **Сургалт зохион байгуулах:** Үр дүнтэй сургалт нь үр

чадварыг хөгжүүлэх төрөл бүрийн бүрэлдэхүүн хэсгүүдтэй байх шаардлагатай бөгөөд үүнд олон нийтийн дунд практик үйл ажиллагааг идэвхжүүлэх, чадамжийн суурь үнэлгээ болон тасралтгүй үнэлгээнүүдийг хийх зэрэг орно. (Энэ нь чиглүүлэгчдийн бүх сургалтанд хамаатай боловч үе тэнгийнхнийг сургахад эдгээр талуудыг авч үздэггүй.) Боломжит тохиолдолд, үе тэнгийн сургагч багш нарыг урьдчилан тогтоосон үр чадварын стандартын дагуу мэдлэг, хандлага, үр чадвараа харуулахыг шаардсан аргачлалыг ашиглан гэрчилгээжүүлэх хэрэгтэй. Үүнийг хүлээн зөвшөөрөгдсөн эрх мэдэл, холбогдох түршлага бүхий албан тушаалтан, байгууллага болон шинжээчид үнэлэх ёстой.

- **Анхны сургалтын дараа зөвлөн туслах дэмжлэгээр хангаж, “дараагийн шатны дэмжлэгийн” сургалтуудад үргэлжлүүлэн хамруулах:** Энэ нь үе тэнгийн сургагч багш нарын явуулдаг БЦБ-ын чанарыг баталгаажуулахад тусална. Тэд сэтгэцийн гэмтлийн асуудалтай тулгарсан тохиолдолд насанд хүрсэн сургагч багш нараас (эрүүл мэндийн тусламж, зөвлөгөө өгөх гэх мэт) илүү их дэмжлэг шаардаж магадгүй. Байнгын арга зүйн дэмжлэг тусламж, дэмжих бүлгүүдэд шаардлагатайгаас гадна, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн буюу яаралтай тусламж авах боломжтой байх ёстой.
- **Арга зүйн дэмжлэг, удирдлагаар хангах:** Үүнд техник арга зүйн чадамжтай, урам зориг өгөхүйц, дэмжлэг үзүүлэх чадвартай хөтөлбөрийн ажилтнуудын зүгээс анхан шатанд болон оффисд суурилсан хэлбэрийн аль алиныг багтаасан арга зүйн дэмжлэг удирдлага байх ёстой. Арга зүйн дэмжлэг, удирдлага нь давуу талыг тодорхойлж, магтан сайшааж, түүнийг бататган бэхжүүлэх; сайжруулах шаардлагатай үр чадвар эсвэл мэдлэгийг тодорхойлох; үе тэнгийн сургагч багш нарыг илүү чадварлаг, үр дүнтэй болоход нь туслах санал зөвлөмжийг өгөх; тэднийг цаашид үргэлжлүүлэхэд нь туслахын тулд байнгын урам зориг өгч, дэмжлэг үзүүлэх шаардлагатай (Симба ба Какоко, 2009).
- **Санал хүсэлтээ тогтмол өгөх боломжоор хангах:** Үе тэнгийн сургагч багш нараас хөтөлбөр, түүний үйл ажиллагаа, өөрсдийн гүйцэтгэлийн талаар санал сэтгэгдлийг нь асуух хэрэгтэй. Үүнтэй адил үе тэнгийн сургагч багш нарын талаарх санал бодлыг хөтөлбөрт оролцогчдоос авах боломжтой

Үргэлжлүүлэн ажиллуулах, солих

- **Үе тэнгийн сургагч багш нарын чадавх, экспертын үр чадварыг хүлээн зөвшөөрсөн тодорхой шаардлагыг бий болгох:** Ажлын удирдамжийн цар хүрээг гүйцэтгэх боломжтойгоор тогтоох, ажил гүйцэтгэх гэрээг ашиглах. Хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх тал дээр үе тэнгийн сургагч багш нарт үүрэг хариуцлага болон шийдвэр гаргах эрх мэдлийг олгох.
- **Нөхөн олговор, урамшуулал олгох:** Үе тэнгийн сургагч багш нарт цалин хөлс олгох нь тэдний урам зоригийг нэмэгдүүлж, нийгэм, эдийн засгийн бүх түвшний залуучуудад оролцох боломжийг олгодог. Ажлаа хийж гүйцэтгэхтэй холбоотой зардал буюу дор хаяж тээврийн зардалыг тэдэнд нөхөн олгох ёстой. Гэсэн хэдий ч бусад төлбөрүүд нь тэдний үе тэнгийнхнээсээ нийгмийн ялгаатай байдлыг бий болгохгүйн тулд тийм их хэмжээтэй байх ёсгүй. Үе тэнгийн сургагч багш нарыг урамшуулах өөр арга замууд нь тэдэнд хувь хүний болон мэргэжлийнхээ хувьд өсөх боломж олгох явдал юм. Үе тэнгийн сургагч нар нь сайн дурын ажилтнууд бол тэднийг хангалттай түвшинд хүлээн зөвшөөрч, тэдний хөдөлмөрийг үнэлдэг байхад анхаарах хэрэгтэй.
- **Сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх:** Үүнд стресс, ажлаас халсрах зэрэг асуудлыг шийдвэрлэх, эсвэл гаргасан амжилт, шинэ санаагаа хуваалцах, бүлгийн эв нэгдлийг бий болгох зорилгоор тодорхой хугацаанд үе үе хувь

хүмүүсийн болон бүлгийн дэмжих үүлзалтуудыг зохион байгуулах үйл ажиллагаа багтана.

- **Сургагч багш нар солигдох эсвэл ажлаас гарах тохиолдолд хэрхэхээ төлөвлөх:** Энэ нь үе тэнгийн боловсролын хөтөлбөрүүдэд түгээмэл тохиолддог ба энэ асуудлыг үе тэнгийн багш нарыг шинээр элсүүлэх, сургах албан ёсны бүтэц бий болгох замаар хэсэгчлэн шийдвэрлэж болно. Сургагч багшийн ажлаас гарах үеийн ярилцлага хийх арга нь хэрэгжүүлэгчдэд үе тэнгийн сургагч багш нар хувийн эсвэл хөтөлбөрөөс улбаатай шалтгаанаар гарч байгаа эсэхийг тодорхойлоход тусалж, хөтөлбөрийн талаарх тэдний түршлагыг үнэлэхэд тусална. Энэ мэдээллийг хөтөлбөрийг сайжруулахад ашиглаж болно. Үе тэнгийн сургагч багш нарыг шинээр элсүүлэх, сургахад одоогийн үе тэнгийн сургагч багш нарыг татан оролцуулах нь тэднийг чадваржуулж, шинэ үр чадварыг хөгжүүлэхэд нь тусалдаг.

Гол баримт бичиг ба сургалтын хөтөлбөрүүд

- *Үе тэнгийн боловсролын арга хэрэгслүүд* (НУБХАС, 2006)
- *Залуучуудын үе тэнгийн боловсролын талаар нотолгоонд суурилсан удирдамж* (FHI 360, 2010)
- *ХДХВ-ийн үе тэнгийн боловсролын хөтөлбөрийн стандартууд* (Олон улсын Улаан загалмай, Улаан хавирган сар нийгэмлэгүүдийн холбоо, 2010)

2.4 Эцэг эх, асран хамгаалагчдыг сургуулиас гадуурх БЦБ-д татан оролцуулах нь

Гэр бүл нь хүүхэд, залуучуудад бэлгийн амьдралын талаар сургахад чухал үүрэг гүйцэтгэдэг боловч тэд ихэвчлэн төлөвлөөгүй, ухамсаргүй байдлаар сургаж байдаг. Хүүхдүүд хайр, хүрэлцэх, бусадтай холбоо тогтоох, бусадтай харилцах, жендэрийн тэгш байдлын талаар суралцахдаа тэдэнд тусгайлан заасан мэдээллээс гадна эргэн тойрныхоо хүмүүсийг ажиглах замаар, мөн тэдэнд өгч буй удирдамж, залруулга болон тэдэнд хэрхэн хандаж буй хандлагаас суралцаж байдаг (ДЭМБ, 2017с).

Сургуулиудад бэлгийн боловсрол олгодоггүй эсвэл бэлгийн боловсролыг цогц байдлаар олгодоггүй газруудад эцэг эх, асран хамгаалагчид, гэр бүлийнхэн нь хүүхдүүддээ энэхүү боловсролыг олгох үүргийн ихэнхийг хүлээдэг (Поп ба Русу, 2015), ба тэд ихэнхдээ бэлгийн амьдралын талаарх мэдээллийн эх сурвалж байхыг илүүд үздэг. Гэсэн хэдий ч эцэг эх, асран хамгаалагчид хүүхдүүдэд нотлох баримтад суурилсан, насны онцлогт тохирсон бэлгийн боловсрол олгох чадвар дутмаг байдаг. Үүнийг шийдвэрлэхийн тулд БЦБ-ын зарим хөтөлбөрүүд нь хүүхдүүддээ бэлгийн боловсрол олгох, эсвэл олгоход нь дэмжлэг үзүүлэхэд эцэг эх, асран хамгаалагчдыг татан оролцуулахыг эрмэлздэг. Үүнд бэлгийн боловсролыг олгох дараах арга зүй хандлагууд багтана. Үүнд:

- **эцэг эх төвтэй:** Эцэг эх, асран хамгаалагчид нь хүүхдүүддээ бэлгийн боловсрол олгох сургалтанд хамрагдсан эсвэл сургагдсан байдаг.
- **эцэг эхийн оролцоотой:** Эцэг эх, асран хамгаалагчид болон хүүхдүүд бэлгийн боловсрол олгох сургалтанд хамтдаа оролцох эсвэл гэрийн даалгавраа хамт хийх.
- **эцэг эхийн дэмжлэгтэй:** Эцэг эх, асран хамгаалагчид бэлгийн боловсрол олгох хөтөлбөрийн талаарх мэдээлэл авсан байх ба ингэснээр тэд хүүхдээ юу сурч мэдэж байгааг мэдэж, өгсөн мессежүүдийг гэр бүлийн орчинд бэхжүүлж эсвэл нэмж байдаг.
- **эцэг эхээр удирдуулсан:** Эцэг эх, асран хамгаалагчдыг сургалтанд хамруулж, бусад эцэг эх, асран хамгаалагчид эсвэл хүүхдүүдэд хөтөлбөрийг зохион байгуулахад бэлдэх.

- **гэр бүлд суурилсан:** Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдүүдтэйгээ хамт тодорхой бүтэцлэгдсэн хөтөлбөрөөр суралцах, ж.нь. хамтдаа видео үзэх эсвэл хөгжим сонсох аргаар суралцах.

Зарим хөтөлбөрүүд нь эдгээр арга хандлагын хоёр ба түүнээс дээш хувилбарыг нэгтгэсэн байж болно.

Хөтөлбөрийн төлөвлөлт ба боловсруулалт

Үр дүнтэй хөтөлбөрийн нийтлэг бүрэлдэхүүн хэсгүүдэд дараах зүйлс орно. Үүнд:

- Эцэг эх, асран хамгаалагчид, тэдний хүүхдүүдэд зориулсан хамтарсан хичээлүүд
- Эцэг эх/гэр бүлийн оролцоог дэмжсэн байх
- Эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан бэлгийн боловсрол олгох, тэдэнд хүүхдүүдтэйгээ хамтран шинээр сурсан харилцааны үр чадваруудаа практикт хэрэгжүүлэх боломж олгох.
- **Эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдийн БЦБ-д хамрагдахын ач холбогдлыг нь тайлбарлаж өгөх:** Хөтөлбөрүүд нь хүүхдүүдийг бэлгийн харьцаанд орохоос нь өмнө эцэг эх-хүүхдийн хоорондын мэдээлэл харилцааг дэмжихэд чиглэсэн байх ёстой бөгөөд эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдүүдтэйгээ бэлгийн харьцааны талаар ярилцахын эерэг үр нөлөөнд итгэх итгэл үнэмшлийг дэмжих ёстой. Жнь: хүүхдүүд үүнд эерэг хариу үйлдэл үзүүлдэг, мөн энэ нь ХДХВ-ээс урьдчилан сэргийлэхэд үр дүнтэй байдаг гэх мэт (Вилларрюэль нар, 2008). Эцэг эх, асран хамгаалагчдад, ялангуяа энэхүү гарын авлагад тусгасан хүүхэд, залуучуудын тодорхой бүлгийн хувьд хүүхдийнхээ бэлгийн амьдралтай холбоотой эмзэг байдал, хэрэгцээ шаардлага, эрх ашгийг ойлгоход нь туслах нь чухал юм.
- **Эцэг эх, асран хамгаалагчтай зөвлөлдөх:** Тэднээс тэдний оролцохыг хүсэж буй түвшин, өөрсдийн мэдлэг, мэдлэгийн зөрүүтэй байдал, хүүхдүүдийнхээ бэлгийн амьдрал болон бэлгийн эрүүл мэндтэй холбоотой тэдний санаа зовж буй асуудал, тэднийг хөтөлбөрийн хүрээнд хэрхэн хамгийн сайнаараа дэмжиж чадах талаар асуух хэрэгтэй.

Заах арга зүй ба суралцах арга зүй

- **Жендэрийн эрх тэгш хэм хэмжээ, хандлагын ач холбогдлын талаарх эцэг эх, асран хамгаалагчдын ойлголтыг нэмэгдүүлэх:** Эцэг эх, асран хамгаалагчид нь өсвөр насныхны жендэрийн хэм хэмжээ, хандлагыг төлөвшүүлэхэд гол үүрэг гүйцэтгэдэг. Ихэнхдээ тэд хүүхдүүдээ жендэрийн нийтлэг хэм хэмжээнд нийцүүлэхийг хүсдэг (гэвч энэ хэм хэмжээ нь ихэвчлэн тэгш бус байдаг) бөгөөд тэд зааварчилах, урам зориг өгөх, шагнах урамшуулах, анхааруулах, шийтгэх зэрэг аргаар дамжуулан үүнийг төлөвшүүлдэг (Чандра-Мули нар, 2017). Тиймээс хөтөлбөрүүд нь эцэг эх, асран хамгаалагчдад илүү эрх тэгш жендэрийн хандлага, хэм хэмжээг үлгэрлэхэд нь туслах ёстой.
- **Эцэг эх, хүүхэд хоорондын харилцааг бэхжүүлэх:** Эцэг эх, хүүхдийн харилцааны ерөнхий шинж чанарууд, тухайлбал холбоотой гэдгээ мэдрүүлэх, дэмжлэг үзүүлэх, ирээдүйн хүлээлтээ илэрхийлэх нь хүүхдийн бэлгийн зан үйлд сексийн талаар ярьж өгөхөөс илүү их нөлөөтэй байж болох бөгөөд бэлгийн боловсролоос илүү үнэ цэнэ, ач холбогдолтой байж болох юм. Тиймээс эцэг эх, асран хамгаалагчийн оролцоог дэмжих арга хэмжээнүүд нь хүүхдийнхээ зан үйлийг хянах, удирдах тэдний чадварыг сайжруулах; эцэг эх, асран хамгаалагчдад бэлгийн харилцааны талаарх өөрсдийн үнэлэмжийн талаар

мэдээллээ хуваалцахад нь туслах; мөн хүүхдүүддээ бий болгохыг хүсч буй зан үйлээ өөрсдөө үлгэрлэхэд нь дэмжихэд чиглэгдэх ёстой (Вайт нар, 2012; Санта Мария нар, 2015).

- **Эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан технологид суурилсан хөтөлбөрүүдийг судлах:** Боломжтой тохиолдолд технологийг ашиглах нь бүлгээр хичээллэх болон олон хичээлүүдэд хамрагдахад тулгардаг нийтлэг бэрхшээлүүдийг багасгаж чадна. Тухайлбал хөтөлбөр, ажил, гэр бүлийн үүрэг хариуцлага давхцах, цаг хугацаа алдах, тээврийн хэрэгслээр явж очих гэх мэт нийтлэг саад бэрхшээлийг багасгаж чаддаг. Дэлгэрэнгүй мэдээллийг 2.5-р хэсгээс авна уу.

Гол баримт бичиг ба сургалтын хөтөлбөр

- *Холбоо харилцаа бий болгох нь (Мельбурны Боловсрол судлалын төгсөлтийн дараах сургууль)*
- *Ярилцъя! Эцэг эх-хүүхдийн бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх харилцаа (НУБ-ын Хүн амын сан, 2018)*
- *Эхнээс нь шууд: Бэлгийн харилцааны талаарх удирдамж, нярайгаас таван нас хүртэлх (АНУ-ын бэлгийн боловсрол, мэдээллийн зөвлөл, 1998)*
- *Эцэг эхчүүд сургуулийн орчинд бэлгийн цогц боловсрол олгохыг сурталчлах нь (Залуучуудын төлөөх өмгөөлөгчид, 2002)*
- *Хүүхдүүдтэй харилцах арга зүй: асран хүмүүжүүлэх, урам зориг өгөх, сэтгэл хөдлөлийг өдөөх, сурган хүмүүжүүлэх, эдгээр зарчим ба дадлууд (НУБ-ын Хүүхдийн сан, 2011)*

2.5 Сургуулиас гадуурх БЦБ-д технологийг ашиглах

БЦБ-ыг хүргэхэд технологийн боломжийг ашиглах явдал нь ихээхэн сонирхол татах болсон. Учир нь олон хүүхэд, залуучууд аль хэдийн технологийг өөртөө итгэлтэй, байнга ашигладаг болсон (Ноар, 2011; Талуқдар, 2013; Холстром, 2015; Оостерхофф нар, 2017). Хүүхэд, залуучууд интернэт, нийгмийн сүлжээг ашиглах боломжтой бол эдгээр нь ихэвчлэн бэлгийн амьдрал, бэлгийн харилцааны талаарх мэдээллийн гол эх сурвалж болдог. Иймээс бүтэцлэгдсэн хөтөлбөр эсвэл хөтөлбөрийн зарим бүрэлдэхүүн хэсгүүдийг хүргэхдээ технологийг ашиглаж болно. Онлайн эсвэл дижитал бүрэлдэхүүн хэсгүүд нь:

- суралцагчид хүссэн цагтаа, хүссэн газраа уян хатан байдлаар, тохь тухтай нэвтрэх боломжтой тул илүү хүртээмжтэй байдаг. Энэ нь ялангуяа газарзүйн хувьд алслагдсан, нүүдэл хийж байгаа эсвэл бусадтай хамт нэг бүлэгт суралцах хүсэлгүй байгаа (эсвэл тэдэнтэй үулзах нь тэдэнд аюултай) суралцагчдад илүү давуу талтай байж болно.
- урт хугацаанд хямд өртгөөр илүү олон тооны хүмүүсийг хамруулах боломжтой тул илүү үр ашигтай байдаг.
- интерактив, татан оролцуулж болохуйц, хувь хүмүүст тохируулсан байдлаар агуулгыг оруулах боломжтой тул энэ нь бусад заах аргуудтай харьцуулахад илүү өөрчлөлтөнд чиглэсэн байх нь бий.
- хэрэглэгчдэд өөрийн хурдаар суралцах боломж олгодог.
- зарим тодорхой хүүхэд, залуучуудын бүлэг, эсвэл цөөн тооны хүмүүст өөрсдөд нь хамааралтай мэдээллийг үр дүнтэй, аюулгүй хүргэх боломжтой.
- БЦБ-ын агуулгыг илүү бүрэн байдлаар хүргэх боломжтой. Учир нь энэ нь сургагч багш нарын тухайн сэдвийг заах хүсэл эрмэлзэлтэй эсэх, эсвэл тухайн сэдвийн талаар өөрийн бодлоо оруулж өрөөсгөл хандахаас шалтгаалахгүйгээр тогтмол байх боломжтой. (Даунс нар, 2015).

БЦБ-д технологийг ашиглахад зарим анхаарах асуудлууд байдаг. Үүнд:

- Технологийг ашигладаг зарим арга хандлага нь нөөц багатай орчинд (эсвэл интернэтийн хүртээмж эсвэл цахилгаан эрчим хүч хязгаарлагдмал нөхцөлд) ашиглах боломжгүй байж болно.
- Сургалтын материал (тайлбар толийг үзнэ үү) эсвэл симуляци гэх мэт зарим арга хэмжээ нь урт хугацааны, нарийн төвөгтэй хөгжүүлэлтийг шаарддаг бөгөөд өндөр чанартай бүтээгдэхүүнийг хөгжүүлэхэд ихээхэн хэмжээний санхүүжилт шаарддаг. Тиймээс цаг хугацаа болон бусад нөөцийг зохих ёсоор төлөвлөх ёстой.
- Оюутнуудын симуляциас хэрхэн суралцаж буй байдлыг үнэлэхэд илүү төвөгтэй байж болно.
- Технологи маш хурдан өөрчлөгдөж магадгүй тул интервенцийг боловсруулж, санамсаргүй түүврийн хяналтын бүлгийг урт хугацааны туршилтийн аргаар үнэлж үзэх үед технологи аль хэдийн хуучирсан байж болно.
- Гар утсаараа интернэтэд хандах хандалт улам бүр өргөн цар хүрээтэй, хямдхан болж байгаа ч бүх хүүхэд, залуучууд, тэр дундаа бага орлоготой улс орнуудын хүүхэд залуучууд жигд нэвтрэх боломжгүй байдаг. түүнчлэн газарзүйн байршил, дэд бүтэц муу (үүнд уулархаг нутаг, арлууд болон зарим хөдөө тосгод), хүйс, хэлний бэрхшээл, бичиг үсэг тайлагдалт, дижитал бичиг үсгийн түвшин зэргээс шалтгаалан хандалтын зөрүү ялгаатай байсаар байна. (ОУМТЭ/ITU/, 2017; НУБХС, 2017; ОУМТЭ/ITU/-ын Өргөн сүлжээний комисс, мөн ЮНЕСКО, 2018; GSMA ба IPSOS, 2018).
- Хүүхэд эсвэл залуучуудын амьдралд насанд хүрэгчдийн үзүүлэх дэмжлэг, зааварчилгааг технологи орлох боломжгүй юм. Иймээс технологийг ашиг тустай арга хэрэгсэл гэж үзэх хэрэгтэй болохоос насанд хүрсэн хүний дэмжлэг үзүүлэх, харилцан ярилцах харилцааг үүгээр орлуулж болохгүй.

Хөтөлбөрийн төлөвлөлт ба боловсруулалт

- **БЦБ-ыг дэмжих технологийн хэрэгцээ, боломжийг үнэлэх:** БЦБ-ыг хэрэгжүүлэхэд тулгар буй бэрхшээлийг тодорхойлж, технологи нь тэдгээрийг хэрхэн шийдэж чадах эсэхэд дүн шинжилгээ хийх. Технологийн хүртээмж, ашиглалтад нөлөөлж болзошгүй хүчин зүйлийг үнэлэх. Энэ нь сонгож авсан тухайн технологи нийцтэй, тогтвортой, давхцалгүй байхыг баталгаажуулахад тусална (Дижитал хөгжлийн зарчим, nd).
- **Одоогийн байгаа зүйл дээрээ тулгуурлан боловсруулах:** Хомс нөөц боломжийг хамгийн үр дүнтэйгээр ашиглах, цаг хугацаа хэмнэх, хүчин чармайлтыг давхардуулахаас зайлсхийх, цоо шинэ зүйл бүтээхээс илүүтэйгээр одоо байгаа бүтээгдэхүүн, нөөц боломж, арга барилаа өөрчлөх замаар хөгжүүлэх хэрэгтэй. Дижитал хөгжүүлэлтийн багууд, онол практикийн бага хурал, блог, хөтөлбөрийн үнэлгээгээр дамжуулан юу туршигдаж, шинээр гарч, түгээмэл болж байгааг олж мэдээрэй. Бүтээгдэхүүнийг сайжруулахад чиглэсэн мэдээллийг цуглуулахын тулд бүтээгдэхүүн дээрээ хяналт шинжилгээ хийх, санал хүсэлт авах системийг бий болго.
- **Боломжит экспертүүдийг ашиглах:** Технологид суурилсан хөтөлбөрүүд эсвэл түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг, ялангуяа илүү боловсронгуй, илүү үр ашигтай хөтөлбөрүүдийг боловсруулахад ихэвчлэн ихээхэн хэмжээний чадавх шаардлагатай байдаг. Технологийн мэргэжилтнүүд, хөтөлбөрийн агуулгын чиглэлээрх мэргэжилтнүүдтэй түншлэх нь бүтээгдэхүүний чанар, үр ашгийг баталгаажуулах боломж олгоно.
- **Хүүхэд, залуучуудтай түншлэх:** Шинэ технологи ашигласан хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг боловсруулахад хүүхэд, залуучуудын онцлог шинж чанар, тэдний хэрэгцээ, сонирхол, бэрхшээл, тэдний нөхцөл байдал,

хэл яриаг ойлгох нь чухал юм. Хөгжүүлэгчид хэрэглэгчийн хэрэгцээнд нийцэхүйц шийдлүүдийг тодорхойлох хүртлээ бүтээгдэхүүн бий болгох, турших, дахин загварчлахдаа хүүхэд залуучуудтай хамтарсан дизайны үйл явцыг ашиглах ёстой (Дижитал хөгжлийн зарчимууд, n.d.).

- **Нууцлал, аюулгүй байдлын асуудлыг үнэлэх, шийдвэрлэх:** Ямар хэрэглэгчийн болон ямар хөтөлбөрийн өгөгдлийг цуглуулах, хэрхэн цуглуулах, ашиглах, хадгалах, хуваалцах талаар сайтар бодож үзээрэй. Хөтөлбөрүүд нь аливаа нууцлалтай мэдээлэл болон мэдээллийн сан дах хувь хүмүүсийг тодорхойлох гол мэдээллүүдийг гуравдагч этгээд зөвшөөрөлгүй нэвтрэх, ашиглахаас хамгаалах ёстой. Хариуцлагатай үйл ажиллагааны практик нь өгөгдлийг хэрхэн цуглуулах, хэрхэн ашиглах талаар ил тод байх, хувийн болон хувь хүний танигдахуйц мэдээллийг цуглуулах хэмжээг багасгах, өгөгдлийг хамгаалах, хувийн нууц, нэр төрийг хамгаалах аюулгүй байдлын бодлогыг бий болгох, хэрэгжүүлэх, төсөл дууссаны дараа нь аливаа өгөгдлийг хэрхэн удирдах бодлогыг бий болгох зэргийг багтаасан байдаг. (Дижитал хөгжлийн зарчмууд, nd).
- **Хувь хүнд зориулан тохируулга хийх болон интерактив харилцааны давуу талыг ашиглах:** Технологи улам бүр боловсронгуй болж байгаа нь БЦБ-ыг илүү үр дүнтэй болгоход түүнийг ашиглах боломжуудыг үндсээр нь өөрчилж байна. Хичээлийн материалыг сурагчдын танин мэдэхүйн үе шат, боловсролын түвшин эсвэл бэлгийн амьдралын туршлага, мэдлэгийн тодорхой зөрүү, хүйс, арьсны өнгө, үндэс угсаа, эрсдлийн ангилалд нь тааруулан тохируулга хийж өөрчилж болно. Технологи нь мөн суралцагчдын сонголтыг харгалзан үзсэн интерактив байж болно. Жишээлбэл, симуляцийн хөтөлбөрүүд (суралцагч нь бодит мэт мэдрэмжийг мэдрэх орчинтой харилцаж, шийдвэр гаргах, сурсан үр чадвараа ашиглах замаар суралцдаг), сурган хүмүүжүүлэх ач холбогдолтой хөгжилтэй мөртлөө өрсөлдөөнтэй элементүүдийг агуулсан симуляцийг шингээсэн тоглоомууд орно. Интерактив технологи нь хувь хүнээс шууд хариулт өгөх, эргэх холбоог бий болгох, суралцагчдад тухайн нөхцөл байдлыг дахин тоглуулах, өөр сонголт эсвэл өөр шийдлийг түршиж үзэх боломжийг олгодог.
- **Технологид суурилсан БЦБ-ын хөтөлбөрүүд нь сургалтын хөтөлбөрт суурилсан байх ёстой:** Бусад бүрэлдэхүүнийг агуулаагүй цэвэр технологид суурилсан БЦБ нь хэрэглэгчид тодорхой дарааллын дагуу үргэлжүүлж, тодорхой элементүүдийг дарааллаар нь гүйцэтгэхийг шаардсан механизмтай байх ёстой. Хэрэв хэрэглэгчид өөрсдөө сургалтын хөтөлбөрт суурилсан хөтөлбөрийн аль бүрэлдэхүүн хэсэгт нэвтрэх, алийг нь алгасахаа өөрсдөө сонгодог байвал энэ нь тэдний суралцах үйл явц, агуулгын хамрах хүрээ нь өргөн хүрээтэй байж чадахгүй.
- **Тохиромжтой контент менежмент ба бүтээгдэхүүний засвар үйлчилгээг төлөвлөх:** Хуучирсан эсвэл буруу мэдээллийг интернэтээр дамжуулан түгээх эрсдлийг бууруулахын тулд аливаа технологид суурилсан хөтөлбөрт багтсан мэдээллийг цаг тухайд нь шинэчилж, холбогдох мэдээллийг оруулж байх ёстой.

Заах ба суралцах арга зүй

- **БЦБ-ын бүрэлдэхүүн хэсгүүдийг хүргэх технологид суурилсан олон янзын хувилбаруудыг харгалзан үзэх.** Үүнд утасны дуудлагаар, мессежээр, имэйл, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, вэбсайт, блог, влог, видео, подкаст, тусгай аппликейшн, нийгмийн сүлжээ болон компьютер эсвэл вэбд суурилсан интерактив боловсрол, хичээлүүд, таавар, тоглоом, симуляци ба танин мэдэхүйн тоглоомууд, виртуал орчин, чат-бот (хүний харилцан яриаг дууриаж, асуултанд хариулж чаддаг компьютерийн програмууд) зэрэг орно.

- **Технологийг бусад арга барилтай хослуулах:** Эдгээр аргуудын ихэнх нь БЦБ-ыг бие даан хүргэх боломжгүй юм. Гэсэн хэдий ч ихэнхийг нь БЦБ хөтөлбөрийн нэг хэсэг, эсвэл нэмэлт ашиглах материал болгон ашиглах боломжтой, мөн эмнэлэгт, эцэг эхтэйгээ хамт гэртээ, эсвэл нүүр тулсан сургалтуудын нэг хэсэг болгон ашиглаж болно. Жишээлбэл, клиникийн видео, компьютер дээр суурилсан хөтөлбөрүүд нь хүүхэд, залуучуудад жирэмслэхээс хамгаалах, бэлгийн замаар дамжих халдвар, ХДХВ-ээс урьдчилан сэргийлэх талаар үр дүнтэй боловсрол эзэмшүүлэх боломжийг олгодог (Ноар нар, 2009; Бэйли нар, 2012; Туонг нар, 2014).

Хөтөлбөрийг хүргэх нь

- **Хүүхэд, залуучууд өөрсдөө технологид хялбар нэвтрэх боломжгүй нөхцөлд шийдлийг эрэлхийлэх:** Хөтөлбөрийг хүргэхэд үүнийг хийх боломжтой орчин нөхцөл (жишээлбэл, клиник эсвэл сургууль) хэрэгтэй болно; эсвэл төсөв хөрөнгө байгаа тохиолдолд хүүхэд, залуучуудыг гар утсаар хангаж болно (Гусе нар, 2012). Өөр нэг арга бол олон нийтэд түшиглэсэн сургагч багш нарт ажлын хэрэгцээний таблет эсвэл компьютерийг өгөх явдал юм (Бэйли нар, 2010).
- **Вэбсайт эсвэл аппликейшны хүрээг өргөжүүлэх:** Хэрэглэгчийн бусад хэрэгцээ шаардлагыг хангасан, хүсэж буй нэмэлтүүдийг нь оруулж өгсөн хөтөлбөрүүд нь илүү олон хүүхэд, залуусыг татан оролцуулж, тэдний оролцоог хадгалахад тусална. Нийгмийн сүлжээний мэдээллийн платформ болон бусад технологийг холбож өгөх нь бас чухал юм.
- **Суралцагчдын оролцоог түүштэй хадгалахад анхаарлаа хандуулах:** Бүтээгдэхүүн нь сайн боловсруулагдсан (хэрэглэгчидтэй хамтран), анхаарал татахуйц, алхам алхамаар хийх аргачлалыг ашигласан бол суралцагчдын оролцоог түүштэй хадгалах чадвар өндөр байх магадлалтай.
- **Фэйсбүүкийн группийн хуудсууд, блог болон интерактив форумуудад хяналт шинжилгээ хийх:** Оролцогчид шууд лайв чатаар харилцах эсвэл бие биедээ мэдээлэл өгөх үед мэдлэг үр чадвартай ажилтнууд тогтмол хяналт шинжилгээ хийж байх нь танилцуулсан мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ нь нийгмийн сүлжээний хуудсуудыг ашиглах үед онцгой чухал бөгөөд учир нь эдгээр хуудсууд нь мэдээлэл авахыг хүссэн иргэдэд тэдний хүсээгүй сурталчилгаа, хүсээгүй постуудыг хүргэх гээд байдаг. (НҮБХС, 2011а; НҮБХАС ба бусад, 2015; НҮБХХ ба бусад, 2016). Группийн админууд онлайн дээрлэхэлт, хүчирхийллийн шинж чанартай мэдээлийг хянах хэрэгтэй.

Гол баримт бичиг

- *Дижитал хөгжлийн зарчим* (вэбсайт)
- *mHealth төлөвлөлтийн удирдамж: Эрүүл мэндийн хөтөлбөрт хөдөлгөөнт технологийг ашиглахад анхаарах зүйлс* (K4Health, 2014)
- *mHealth үндсэн ойлголтууд: Эрүүл мэндийн үйлчилгээнд Мобайл технологийг нэвтрүүлэх нь* (Дэлхийн эрүүл мэндийн суралцахуйн төв, 2013)
- *MAPS аргачлал: mHealth-н үнэлгээ, өргөжүүлэх төлөвлөлт* (ДЭМБ, 2013)
- *mHealth хөтөлбөрийг загварчлах аргачлал: Хөгжиж буй зах зээлд гар утсаар үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээг эхлүүлэх, хөгжүүлэх, өргөжүүлэх арван зарчим* (GSMA, nd)
- *Танин мэдэхүйн тоглоомуудын загварыг үр дүнтэй зохион бүтээх удирдамж* (Researchgate, 2014)
- *Дижитал эрин дэхь бэлгийн боловсрол* (Хөгжлийн Судалгааны Хүрээлэн, 2014)

3. Залуучуудын зарим бүлэгт сургуулиас гадуурх Бэлгийн цогц боловсролыг хүргэх нь

БЦБ-ын бүх хөтөлбөрүүд нь хүүхэд, залуучуудын олон төрлийн бүлгийг аль болох багтаасан байх ёстой бөгөөд хүн бүрд тэдний амьдралд хэрэгтэй мэдлэг олгож, тэдний хэрэгцээнд нийцсэн байх ёстой. Гэсэн хэдий ч хүүхэд, залуучуудад нийтэд нь зориулсан БЦБ нь хүн амын бүлэг тус бүрийн онцлог хэрэгцээг гүнзгийрүүлэн хамарч, нийцүүлэх боломжгүй юм. Цаашилбал, ихэнх тохиолдолд нийгмийн гадуурхагдсан бүлгийн хүүхэд, залуучууд өөрсөдтэйгээ ижил төрлийн залуучуудын бүлэгт зөвхөн өөрсдийн аюулгүй байдал, бэлгийн амьдрал, эрүүл мэндтэй холбоотой асуудлаар чөлөөтэй ярих боломжтой байдаг. Тиймээс энэ хэсэгт зарим тодорхой хүүхэд, залуучуудын бүлэгт сургуулиас гадуурх БЦБ-ыг олгох талаар мэдээлэл, зааварчилгаа өгнө. 2-р бүлэгт өгсөн зөвлөмжүүдээс гадна эдгээр бүлэг тус бүрийн хувьд доорх зөвлөмжүүдийг авч үзэх хэрэгтэй.

Олон хүүхэд, залуучууд эдгээр бүлгүүдийн зөвхөн аль нэгэнд хамаарахгүй гэдгийг хүлээн зөвшөөрөх нь чухал юм. Хүүхэд залуучуудын дунд хөгжлийн бэрхшээлтэй бөгөөд ижил хүйтэн, эсвэл хорих ангид хоригдож байгаа бөгөөд хар тамхи хэрэглэдэг, хүмүүнлэгийн нөхцөл байдал байгаа трансжендэр залуучууд, хөдөө орон нутагт амьдардаг өсвөр насны уугуул охид зэрэг бүлэг байж болно. Үнэндээ хүүхэд, залуучуудын дунд байж болох бүхий л өөрийн илэрхийлэл, хэрэгцээ, сонголтын давхардсан бүлгүүд байж болно. БЦБ-ыг хүргэж байгаа бүх сургагч багш нар оролцогчдын хэн болохыг үргэлж мэддэг байх ёстой бөгөөд олон онцлог шинж чанаруудтай оролцогчид байж болохыг хүлээн зөвшөөрч, тэдний ялгаатай нөхцөл байдалд мэдрэмжтэй хандаж байх хэрэгтэй.

3.1 Жендэрийн онцлог бүлгүүд

Өөр өөр жендэрт харьяаглагдах хүүхэд, залуучууд бэлгийн амьдралын талаар хамтдаа суралцахын давуу талууд байдаг бөгөөд наад зах нь оролцогчид хэзээ нэгэн цагт өөрөөсөө өөр жендэрийн хэн нэгэнтэй романтик харилцаа болон бэлгийн харилцаанд орох болно. Гэсэн хэдий ч соёлын хувьд тусад нь зохион байгуулахаас өөр сонголтгүй нөхцөлд БЦБ-ыг жендэрийн онцлог бүлэгт харьяаглагдах хүүхэд, залуучуудад тусад нь хүргэх шаардлага тулгардаг.

Цаашилбал, жендэрийн болон хүчирхийллийн талаарх зарим агуулга хүн бүрд ижил байх боловч ихэнх үлс оронд эрэгтэй, эмэгтэй хүмүүс, охид хөвгүүдийн хооронд жендэрийн эрх мэдлийн тэнцвэргүй байдал байдаг. Жендэр-Трансформатив хандлагад суурилсан боловсрол (Тайлбар толь бичгийг үзнэ үү) оролцогчдыг жендэрийн асуудал тэдний амьдралд хэрхэн нөлөөлж байгаад шүүмжлэлтэй хандаж сургахын тулд сэдэв тус бүр дээр жендэрийн дүн шинжилгээ хийхэд нь удирдан чиглүүлэг өгөх ёстой. Гэхдээ охид, хөвгүүдэд өөр өөр асуудлыг онцлон авч үзэх арга ашиг тустай байж болох юм. Үүнд, охид бүсгүйчүүдийг чадавхжуулах, хөвгүүдэд охид, эмэгтэйчүүдтэй эрх мэдлээ хуваалцахын ач тус, ач холбогдлыг олж харах боломжийг олгоход (Грин ба Левак, 2010) анхаарч болно.

Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх боловсрол нь оролцогчдын хүйсээс хамаарч өөр өөр хандлагыг авч үзэж болох юм. Учир нь охид болон хоёр хүйст харьяалагдахгүй хүмүүс хүчирхийллийн гол хохирогч, даван туулагчид байдаг бол хэдийгээр хөвгүүд, эрэгтэйчүүд бэлгийн болон бусад төрлийн хүчирхийллийн хохирогч болж болзошгүй ч гэсэн

тэдний жендэрийн нийгэмшилт нь ихэвчлэн хүчирхийлэгч болгож байдаг.

Хөтөлбөрийг бүхэлд нь жендэрийн онцлог бүлэгт хүргэж болно, эсвэл оролцогчдыг зөвхөн тодорхой хичээлүүдэд тусад нь салгаж оруулж болно. Ялангуяа өсвөр насны охидын хувьд зөвхөн нэг хүйст зориулсан БЦБ-ын хичээл үзэхийн давуу талууд бий (Грин ба Левак, 2010; Моррисон-Бийди нар, 2013; AGSA, 2016). Энэ нь жендэрийн хэвшмэл ойлголт болон өөрийн мэдэлгүй өрөөсгөл хандлагууд багатай, эмэгтэй хүний дуу хоолойг гадуурхдаггүй, охид бүх манлайллын үүргийг гүйцэтгэх боломжтой, охидын өөртөө итгэх итгэлийг төрүүлдэг сургалтын орчинг бүрдүүлэх боломжтой юм.

Хөтөлбөр хэрэгжүүлэгчид аль нэг хүйст харьяалагдахгүй оролцогчидтой (Тайлбар толь бичгийг үзнэ үү) тэднийг оролцох дуртай арга хэлбэрийн талаар ярилцах ёстой (Грин ба Левак, 2010). Нэг хувилбар нь холимог хүйсийн бүлэгт оролцох хүсэлтэй оролцогчдод зориулсан гуравдахь бүлэг бий болгох явдал юм.

Жендэрийн онцлог бүлгүүдэд зориулсан БЦБ-ын төлөвлөлт, арга зүй, хүргэх арга барил нь охид, хөвгүүдийн бүлэгтэй ижил байх боловч зарим онцлог нь бүлэг тус бүрд өөр өөр шинжтэй байдаг. Энэ хэсэгт судалгааны ном зохиол болон хүүхэд, залуучууд, хөтөлбөр хэрэгжүүлэгчдийн түршлага дээр үндэслэн тэр бүр яригддаггүй зарим зүйлсийг онцолсон болно.

3.1.1 Охид, залуу эмэгтэйчүүд

Хөтөлбөрийн төлөвлөлт ба боловсруулалт

- **Хамгийн ихээр нийгмээс гадуурхагдсан бүлгийн охидыг тодорхойлж, байршлыг нь тогтоох:** Хөтөлбөрийг зохих ёсоор нь оролцогчдын хэрэгцээнд тохируулахын тулд охид, залуу эмэгтэйчүүдийн янз бүрийн дэд бүлгүүдэд тулгардаг онцлог эрсдэл, боломжуудыг ойлгох нь чухал юм. Зорилтот бүлгүүд нь 10-14 эсвэл 15-19 насны охид, уугуул гаралтай, гэр бүлтэй, гэрлээгүй, сургуулиас гадуур, гэрийн үйлчилгээний ажил эрхэлдэг, залуу ээжүүд байж болно. Хөтөлбөр нь хөтөлбөрт хамрагдах шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, тэднийг хэрхэн олж, элсүүлэх тал дээр хүчин чармайлт гаргах хэрэгтэй. Гэрээсээ гарах боломжгүй охидыг элсүүлэхийн тулд насанд хүрсэн хөтөлбөрийн идэвхжүүлэгчид гэрээр явж, шаардлага хангасан охидыг тодорхойлж, тэднийг урих нь үр дүнтэй байж болно. Энэ явцдаа хөтөлбөрийн талаар тухайн эрхийн насанд хүрсэн гишүүдэд тайлбарлаж өгөх нь зүйтэй (Эруклар нар, 2013).
- **Зорилтот бүлгийн охидыг аль болох багаас нь хамруулах, боломжтой бол бэлгийн бойжилт эхлэхээс нь өмнө хамруулах:** Охид бүсгүйчүүдийг эрүүл мэнд, нийгэм, танин мэдэхүйн болон эдийн засгийн мэдлэг, үр чадвараар аль болох эрт хангах нь сургууль завсардалт, өсвөр насны жирэмслэлт, бэлгийн хүчирхийлэл, хүүхдийн гэрлэлт, арилжааны сексээс урьдчилан сэргийлэхэд тусалдаг (Чае ба Нго, 2017; Австриан нар, 2018; Бандиера нар, 2020). Хөтөлбөрийн үрт хугацааны үр нөлөөг гаргахын тулд охидод шилжилтийн насны эхэн үеэс нь эхлэн хөтөлбөрийг хүргэх шаардлагатай (ЛеКроу нар, 2017; ЮНЕСКО нар, 2018).
- **Охидын өвөрмөц орчин нөхцөлд нийцүүлэн тэдний онцлог хэрэгцээг хангахуйц олон талт хөтөлбөрийг боловсруулах:** Охидод БЦБ, эрүүл мэндийн үйлчилгээ, нийгмийн сүлжээ, үлгэр дуурайлал, болон бичил хуримтлал, хөдөлмөр эрхлэлтийн үр чадварыг олгох олон талт хөтөлбөрүүд нь охидын гэрлэлтийн насыг хойшлуулж, ХДХВ-ийн халдварын эрсдлийг бууруулахад хувь нэмэр оруулдаг (НҮБДОХ, 2016b; Энгел нар, 2019).

Заах ба суралцах арга барил

- **Янз бүрийн дэд бүлгүүдийн онцлог ашиг сонирхлыг шийдвэрлэх:** Хөтөлбөрийн үйл ажиллагаа, арга зүй нь хүний эрх, жендэр, эрх мэдэл зэрэгт анхаарлаа төвлөрүүлсэн, ирээдүйн чадавхийг бүрдүүлэх арга хандлагыг БЦБ-ын сургалтын хөтөлбөртэй хослуулсан байх ёстой бөгөөд бага насны болон том болсон охид, гэрлэсэн болон гэрлээгүй охидын хэрэгцээг болон ээж болсон охидын хэрэгцээг харгалзан үзэх шаардлагатай. (Хүн амын зөвлөл, 2018).

Хөтөлбөрийн хэрэгжилт

- **Альтернатив үлгэр дууриал болохуйц залуучуу зөвлөгчдийг татан оролцуул:** Залуучуудын дундаас сонгосон зөвлөгчид нь окидоос арай ахмад бөгөөд тэдний биширдэг, итгэдэг, зааварчилгаа хүсдэг хүмүүсийг төлөөлөх хэрэгтэй. Эдгээр нь окидод чиглэсэн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлж буй бүлгээс сонгох ёстой (Хүн амын зөвлөл, 2016б).
- **Бусад салбар, платформуудтай үялдуулах замаар хөтөлбөрүүдийг институцчлах:** Окидод хүрч үйлчлэх идэвхтэй арга хандлагыг тогтвортой байлгахын тулд сургуулийн багш нар, олон нийтийн түвшний эрүүл мэндийн болон нийгмийн ажилтнуудтай хамтран ажиллаж мессеж түгээх, охидыг сургуульдаа үргэлжлүүлэн сурах эсвэл эргэн ороход нь дэмжлэг үзүүлж, эрүүл мэнд, хамгааллын үйлчилгээнд хамруулж болно.

Гол баримт бичиг ба сургалтын хөтөлбөр

- *Өсвөр насны охид, залуу эмэгтэйчүүдийг ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх нь: Өсвөр насны охид, залуу эмэгтэйчүүдийг ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, эрэгтэйчүүд, хөвгүүдийг татан оролцуулах нь* (НҮБДОХ, 2016)
- *Охидын хамгаалалтын нөөц боломжийг бий болгох: Хөтөлбөр боловсруулах арга хэрэгслийн цуглуулга* (Хүн амын зөвлөл, 2016)
- *M хөтөлбөр: Залуу эмэгтэйчүүдтэй ажиллах нь* (Промундо, nd)
- *Сахи Сахели: Жендэрийн тэгш байдлыг дэмжих, залуу эмэгтэйчүүдийг чадавхжуулах - Сургалтын гарын авлага* (Хүн амын зөвлөл, 2008)
- *Залуу эмэгтэйчүүдэд өөрчлөлтийг удирдах чадварыг олгох: Сургалтын гарын авлага* (НҮБХАС ба Дэлхийн YWCA, 2006)
- *Abriendo Oportunidades хөтөлбөр: Сургалтын хөтөлбөрийн нэгдсэн удирдамж* (Хүн амын зөвлөл, 2017)
- *Go Girls! Охидын олон нийтэд суурилсан амьдрах ухааны үр чадварууд: Сургалтын гарын авлага* (Жон Хопкинс Блүүмбергийн Нийгмийн эрүүл мэндийн сургууль / Мэдээлэл харилцааны хөтөлбөрийн төв, 2011)
- *YWCA Эмэгтэйчүүд, окидод зориулсан аюулгүй орчин: Глобал Өөрчлөлтийн загвар* (Дэлхийн YWCA)

3.1.2 Хөвгүүд ба залуу эрчүүд

Хөтөлбөрийн төлөвлөлт ба боловсруулалт

- **Бүлгээр боловсрол олгох олон бүрэлдэхүүн хэсэгтэй арга хэмжээг хэрэгжүүлэх:** Эрэгтэйчүүд, хөвгүүдийн жендэрийн хандлага, зан үйлийг өөрчлөхөд хувь хүн, олон нийтийн түвшинд үр дүнтэй байх стратеги нь үе

тэнгийнхний боловсрол олгох, эрэгтэй нөлөөлөгчдыг оролцуулах, хэвлэл мэдээллийн томоохон хөтөлбөрүүд, ажлын байран дахь хөтөлбөрүүд, нийгмийн хэм хэмжээг өөрчлөх замаар жендэрийн тэгш бус байдлыг бууруулах зорилготой олон нийтэд суурилсан болон хүний эрхэд суурилсан хөтөлбөрүүдийг хослуулан хэрэгжүүлэх юм. (ХСХ /IDS/, Промундо, Сонке Жендэр Шударга Ёсны Сүлжээ, 2015).

- **Залуу эрэгтэйчүүдэд дэмжлэг үзүүлэх үе тэнгийн сүлжээ, үлгэр дууриал бий болгох:** Хүмүүсийн шинэлэг сэтгэлгээ, зан үйлийн шинэ хэв маягийг дэмжин бэхжүүлдэг хөвгүүд, залуу эрэгтэйчүүдэд зориулсан клуб, нийгмийн сүлжээний бүлгүүд нь хандлага, зан үйлийн өөрчлөлтийг дэмжих үе тэнгийнхний эерэг шахалтыг бий болгож, бэхжүүлдэг (Нами нар, 2014; Торрес нар, 2014).

Заах ба сурах арга барил

- **Бүтцийн асуудалд оролцогчдыг буруутгахаас зайлсхийх:** Үйл ажиллагаанууд нь орон нутагт байгаа тэгш бус байдал, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудалд хөвгүүд, залуу эрэгтэйчүүдийг буруутгахгүй байхад анхаарах ёстой. Эрэгтэйлэг шинж байдал, бэлгийн амьдрал болон бэлгийн эрүүл мэндийн нарийн төвөгтэй нөхцөл байдлыг зөвхөн асуудалтай эрчүүдийн хандлага, зан авиараар тодорхойлж болохгүй. Нийгмийн төвөгтэй, бат бөх гүнзгий тогтсон бэрхшээлтэй асуудлыг шийдэх хариуцлагыг хувь хүнд үүрүүлэх ёсгүй; үүний оронд БЦБ-ын хөтөлбөр нь бүтцийн эдгээр хүчин зүйлсийг шийдэхэд чиглэсэн сурталчилгаа үхүүлгэ, олон нийтийг дайчлах явдлыг хөхиүлэн дэмжиж чадна (Дворкин нар, 2015).
- **Зөвхөн мэдлэг олгохоос илүүтэй хандлага, заах үр чадвараа өөрчлөхөд анхаарах:** Жишээлбэл, жирэмслэхээс хамгаалах хэрэгслийн талаар шийдвэр гаргах, бага насны хүүхдүүдтэй харилцах, живх солих эсвэл хүүхдийг хэрхэн усанд оруулахыг сурах зэрэг орно (Баркер нар, 2007).

Хөтөлбөрийн хэрэгжилт

- **Хамгийн хэцүү сэдвүүдийг хүргэхийн тулд харилцан ойлголцох оролцооны орчин бий болгон ашиглах талаар бодож үзэх:** Цугларалт болон интерактив аргууд болох дэлгэрэнгүй хэлэлцүүлэг өрнүүлэх, хувийн эргэцүүлэл хийх цаг өгөх нь гомофобия (ижил хүйстэнээс айх эмгэг), трансфобия (трансжендэр хүмүүсээс айх эмгэг), хүчирхийлэл гэх мэт нарийн төвөгтэй, эмзэг сэдвүүдэд хандах хандлагыг өөрчлөхөд үр дүнтэй байдаг (Нами нар, 2014).
- **Хэвшмэл ойлголтыг бататгасан үг хэллэгийг хуулбарлан ашиглахаас зайлсхийх:** Эрэгтэй хүний талаарх хэвшмэл ойлголтод суурилсан дүр төрхөд уриалах замаар хөвгүүд, залуу эрэгтэйчүүдийг татан оролцуулахыг хичээсэн үг хэллэг, дүрс зураг нь, тухайлбал “эр хүн шиг бай” гэх мэт уриалга нь эрэгтэйлэг хэв шинжийн хор хөнөөлтэй шинжийг эсэргүүцэхийн оронд улам дэмжиж байдаг. (Гиббс нар, 2015) .

Гол баримт бичиг ба сургалтын хөтөлбөр

- *Эрэгтэйчүүд болон өсвөр насны хөвгүүдэд зориулсан бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний олон улсын багц* (ОУГБТХ ба НҮБ-ЫН Хүн Амын Сан, 2017)
- *Эр хүн 2.0: Эрэгтэйчүүдийн жендэрийн эрх тэгш ирээдүйг сурталчлах сургалтын хөтөлбөр* (Промундо, 2018)
- *N хөтөлбөр: Залуу эрчүүдтэй ажиллах нь* (Промундо, 2018)
- *Ra хөтөлбөр* (Промундо нар)
- *Жендэрийн хэм хэмжээг өөрчлөхөд хөвгүүд, эрэгтэйчүүдийг татан оролцуулах нь: Бүлгийн боловсролын гарын авлага* (Промундо, 2008)
- *Эрэгтэйчүүд, хөвгүүдийг жендэрийн эрх тэгш байдал,*

- Эрүүл мэндийн үйл ажиллагаанд хамруулах нь: дэлхийн үйл ажиллагааны арга хэрэгсэл (НҮБ-ЫН Хүн Амын Сан, 2010)
- Яари Дости: Залуу эрэгтэйчүүд бэлгийн амьдралыг дахин тодорхойлж байгаа нь (Хүн амын зөвлөл, 2006)
- “Нэг эрэгтэй чадна” кампанит ажлын арга хэрэгсэл (Sonke Жендер Шударга Ёсны Сүлжээ, 2006)

3.2 Хөгжлийн бэрхшээлтэй залуучууд

Хөгжлийн бэрхшээлийн төрлийг нэрлэх олон нэр томъёо байдаг. Энэхүү удирдамжид дараах үндсэн ангиллуудыг ашигласан болно.

- **Бие махбодын хөгжлийн бэрхшээл нь** хүний хөдөлгөөн, бие бялдрын чадавх, тэсвэр тэвчээр, уян хатан байдалд нөлөөлдөг. Эдгээр эмгэгүүдэд цистик фиброз, нугасны бифида, бүлчингийн дистрофи, тархины саажилт, тархины гэмтэл, нуруу нугасны гэмтэл, олон төрөлт склероз зэрэг орно.
- **Оюуны хөгжлийн бэрхшээл нь** шинэ эсвэл төвөгтэй мэдээллийг ойлгох, шинэ үр чадвар эзэмших, ашиглах зэрэг хүний оюуны функцуудыг мэдэгдэхүйц буурахад хүргэдэг ба улмаар хүний бие даах чадварыг бууруулдаг. Эдгээр эмгэгүүдэд эмзэг Х хам шинж, Дауны синдром, Прадер-Виллийн синдром, ургийн архины спектрийн эмгэг зэрэг орно.
- **Мэдрэхүйн тогтолцооны бэрхшээл нь** нэг буюу хэд хэдэн мэдрэхүүд нөлөөлдөг, мэдрэхүйн мэдээллийг боловсруулах чадварт мөн нөлөөлдөг. Эдгээрт дүлийрэх, сонсгол муудах, хараагүй эсвэл сул хараатай болох, аутизмын спектрийн эмгэг зэрэг орно.
- **Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлд** шизоид эмгэгүүд орно. Ж нь: шизофрения, шизоаффектив эмгэг (хий юм харах г.м. шизофрения-н шинж тэмдэг дээр сэтгэл хөдлөлийн хямралтай зэрэг илэрдэг сэтгэцийн эмгэг), сэтгэл түгших эмгэг, үүнд, улигт, албадмал эмгэг (Obsessive-compulsive disorder), цочролын дараах сэтгэл зүйн эмгэг, агарофобия (нээлтэй орон зай, талбайгаас болон гэртээ шүүд харих боломжгүй байдлаас айх эмгэг), нийгмийн харилцаанаас айх эмгэг, сэтгэл хөдлөлийн хямралууд, тухайлбал сэтгэл гутрал, хоёр туйлт сэтгэцийн эмгэг зэрэг орно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусадтай адил бэлгийн харилцааны хэрэгцээ, сэрэл мэдрэдэг боловч хөгжлийн бэрхшээлээс хамаарч эдгээр хэрэгцээг хангахад бэрхшээлтэй байдаг (Бэлгийн эрүүл мэнд ба гэр бүл төлөвлөлт Австрали, 2013; НҮБ-ын Хүн амын сан, Women Enabled International байгууллага, 2018). Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудад янз бүрийн шалтгааны улмаас бэлгийн харилцаанд орох боломж маш хязгаарлагдмал байдаг; жишээлбэл, тэдэнд хувийн орон зай байхгүй, нийгмийн хүрээлэл нь хязгаарлагдмал байж болзошгүй (НҮБ-ын Хүн амын сан ба Women Enabled International, 2018). Эцэг эх, асран хамгаалагч нь бусадтай нийгмийн харилцаа, романтик харилцаанд орох боломжийг ихэвчлэн олгодоггүй бөгөөд эргэн тойронд байгаа хүмүүс нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудыг бэлгийн дүр хүслээ илэрхийлэх эсвэл бэлгийн хэвийн зан үйл гаргах үед нь сөрөг сэтгэгдлээр хүлээн авч, хүлээн зөвшөөрөхгүй байгаагаа илэрхийлж, тэднийг гэм буруутай, ичгүүртэй зүйл хийсэн мэт мэдрэмжийг төрүүлж магадгүй. (Траверс нар, 2014; Нью Сауф Уэльсийн Гэр бүл, олон нийтийн үйлчилгээний газар, 2016; Чаппелл нар, 2018). Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бэлгийн харилцааны талаарх хэвшмэл ойлголт, сөрөг хандлага нь тэдний нүүр тулж буй дорд үзэх үзэл, ялгаварлан гадуурхалтын асуудлыг улам бүр нэмж, сэтгэл хангалуун, тааламжтай бэлгийн амьдралтай болоход нь бэрхшээл үчрүүлдэг (Аддлаха нар, 2007). Ихэнх хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын

амьдралын сонголтууд бага байдаг нь тэдний өөрийгөө үнэлэх үнэлэмжид сөргөөр нөлөөлж, улмаар бэлгийн амьдралд ч мөн нөлөөлдөг. Тэд бэлгийн амьдралын талаарх төсөөлөл муутай болж, нийгмийн харилцаанд орох, болзох, дотно харилцаа бий болгох, бэлгийн асуудлаар шийдвэр гаргах, аюулгүй бэлгийн харилцаанд орохтой холбоотой үр чадвар дутагдалтайн улмаас; зохих бэлгийн харилцаанд орох боломж байхгүй байж магадгүй (Истгейт, 2008; Гужон, 2009; Сванго-Вилсон, 2010; Траверс нар, 2014; Холланд-Холл ба Квинт, 2017). Нэмж дурдахад, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучууд (ялангуяа охид) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй харьцуулахад бэлгийн, бие махбодын болон сэтгэл санааны хүчирхийлэлд өртөх магадлал илүү өндөр байдаг (Жонес нар, 2012; НҮБ-ЫН Хүн Амын Сан, 2018а). Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучууд хүчирхийллийн талаар мэдээлэх нь бага, асаргаа болон хууль эрх зүйн тусламж үйлчилгээний хүртээмж бага байгаа нь зарим талаараа хүчирхийллийн асуудлаарх хөтөлбөрүүд эдгээр залуучуудад анхаарал хандуулдаггүйтэй холбоотой (Эллери нар, 2011; Жонес нар, 2012).

Олон улс оронд эрүүл мэндийн үйлчилгээ нь биеэр очих боломжгүйн улмаас хүртээмжгүй байдаг бөгөөд дохионы хэл, брайль үсэг гэх мэт харилцааны бусад хэлбэрийн дэмжлэг байдаггүй (НҮБДОХ, 2017b). Ихэнх эрүүл мэндийн хөтөлбөрүүд буюу бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндтэй холбоотой эрхийн чиглэлээрх хөтөлбөрүүд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээг харгалзан үздэггүй. Үүнтэй адил хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст чиглэсэн хөтөлбөрүүд нь тэдний бэлгийн амьдрал, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн талаар тэдний хэрэгцээг үл тоомсорлодог байж болзошгүй юм (ДЭМБ ба НҮБ-ын Хүн амын сан, 2009; НҮБ-ын Хүн амын сан, 2018а).

3.2.1 Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудтай холбоотой ерөнхий зөвлөмжүүд

Эдгээр зөвлөмжүүд нь ямар ч төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудад хамаатай. Дараагийн хэсгүүдэд бие бялдар, оюун ухаан, мэдрэхүйн эрхтний болон сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцлог хэрэгцээг авч үзэх ба сонсголын бэрхшээлтэй, хараагүй эсвэл аутизмтай хүүхэд залуучуудын талаар тусад нь авч үзнэ. Хүүхэд, залуучуудыг бүлэг бүрд зориулсан зөвлөмжийн тоо харилцан адилгүй байгаа нь нэг талаасаа хөгжлийн бэрхшээлийн ангилал тус бүрд нотолгоо баримтууд харилцан адилгүй байдагтай холбоотой юм.

Хөтөлбөрийн төлөвлөлт ба боловсруулалт

- **Хөгжлийн бэрхшээлийг авч үзэх нийгмийн ба хүний эрхийн загварыг сурталчлах:** Хөтөлбөрүүд нь хүмүүсийн хөгжлийн бэрхшээлтэй байдал, ялгаатай байдал гэхээсээ илүүтэйгээр нийгмээс бий болгосон бэрхшээлүүд нь тэдний бүрэн оролцоонд саад болдог гэдгийг ойлгох ёстой. Хөгжлийн бэрхшээлийг авч үзэх нийгмийн загвар нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэмд тэгш оролцоход нь саад болж буй бэрхшээлийг авч үздэг бол эрхэд суурилсан загвар нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүний эрх талаас нь авч үздэг бөгөөд нийгэм, эдийн засаг, бие махбодын тэгш хүртээмж, оролцоог сурталчилж, хамгаалдаг.
- **Насанд хүрэгчдийг татан оролцуулах:** Бусад хүмүүсийн

хандлага, үйлдэл нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын, ялангуяа оюуны бэрхшээлтэй залуучуудын эрүүл бэлгийн амьдралыг хөгжүүлэхэд саад болж болзошгүй тул хөтөлбөрүүдэд аль болох хүүхэд эсвэл залуучуудын амьдралд чухал үүрэг гүйцэтгэдэг бүх насанд хүрэгчдийг хамруулах хэрэгтэй. Тухайлбал эцэг эх, асран хамгаалагч, хувийн асрагч, зөвлөгч, багш нар, тэдэнтэй үүлдэг бусад мэргэжилтнүүд багтана. (Мерфи ба Элиас, 2006; Гарбутт, 2008; Катц ба Лазкано-Понсе, 2008; Рохледер ба Сварц, 2009; Сванго-Вилсон, 2010; Чираву нар, 2014; Траверс нар, 2014; Холланд-Холл ба Квинт, 2017; Ханасс-Хэнкок нар., 2018b).

- **Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудад бага наснаас нь бэлгийн боловсрол олгоход нь эцэг эх, асран хамгаалагчдыг дэмжих, дэмжлэг үзүүлэх** (АНУБМБЗ, 2001; Гарбутт, 2008): Сургуульд ороогүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудад бэлгийн боловсрол олгоход эцэг эх, асран хамгаалагч нар илүү чухал үүрэг гүйцэтгэдэг. Хүүхдийн бие даасан байдал, хувийн амьдрал, нийгэмшлийг сурталчлах, охидын сарын тэмдэг ирэх, бэлэг эрхтнээ чангалах зэрэгт сургах байгалийн боломж болох “заах цаг мөч” -ийг хэрхэн ашиглах болон хөвгүүдийн дур тавих, нойтон зүүдний талаар бэлгийн бойжилтын өөрчлөлтөд урьдчилан бэлтгэх хэрэгтэй.
- **Оролцогч бүрийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөтөлбөрийг тохируулах:** Хүүхэд, залуучуудыг хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тодорхойлох үнэлгээ хийх нь чухал. Жишээ нь бие махбодын хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, давхар оюуны бэрхшээлтэй эсэхийг тодорхойлох хэрэгтэй. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ оролцогчдын онцлог хэрэгцээнд нийцүүлэн тохируулах ёстой.
- **Зарим хөгжлийн бэрхшээл нь бэлгийн амьдралд хэрхэн нөлөөлж болохыг анхаарах:** Дауны синдром, тархины үсжилттэй хүүхдүүдийн хувьд бэлгийн бойжилт эрт эхэлдэг бол тархины саажилттай хүмүүсийн бэлгийн бойжилт хожуу явагдаж магадгүй (Мерфи ба Элиас, 2006). Төрөлхийн болон удамшлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бэлгийн бойжилт хожуу илэрч болох бөгөөд Прадер-Виллийн синдромтой хүмүүст хожуу эсвэл огт илрэхгүй байж болно (АНУБМБЗ, 2001). Ийм тохиолдлууд хөтөлбөрийн агуулгыг зохих ёсоор тохируулах хэрэгтэй.
- **Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудад хүндэтгэлтэй хандах үүднээс холбон зуучлах үйлчилгээний жагсаалт гаргах:** Оролцогчдод зөвлөгөө өгөх, бэлгийн хүчирхийллийн хямралын үйлчилгээ зэрэг оролцогчдод үзүүлж болох шалгагдсан эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ, мэргэжилтнүүдийн жагсаалтыг гаргах (Чираву нар, 2014; Ханасс-Ханкок нар, 2018a). Хэрэв тохиромжтой зуучлах үйлчилгээ авах боломжгүй бол хөтөлбөр боловсруулагчид засгийн газарт үйлчилгээ бий болгоход нь нөлөөлөх, үйлчилгээ үзүүлэгчдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх нөлөөллийн ажилд нэгдэх ёстой.

Заах ба суралцах арга барил

- **Оролцогчдоос юу сурах сонирхолтой байгааг нь асууж, дараах нөхцөлийг бүрдүүлж өгөхийг хичээх:** Оролцогчид ганцаарчилсан, жижиг бүлгээр эсвэл том бүлгээр суралцахыг илүүд үзэж болно. Тэднээс сургагч багш нар хэрхэн санал дүгнэлтээ өгч, тэднийг суралцахад нь хэрхэн дэмжлэг үзүүлэх талаар асуух хэрэгтэй. Жишээ нь: зураг ашиглан хуудас хуудсаар нь ойлгоход нь туслах, агуулгыг унших болон судлах хугацааг илүү удаан аажуу байлгах, эсвэл сургагч багш нарын үлгэрчилсэн зан үйл, дүрд тоглох үзэгдлийг ажиглах зэрэг байж болно.
- **Оролцогчдын хувьд хамгийн тохиромжтой аргыг тодорхойлохын тулд заах арга зүйн олон арга техникийг түршиж үзэх:** Сургагч багш нар оролцогчдыг чадваржуулахын тулд тэдний нүднийх нь түвшинд суух

эсвэл зогсох (тэд хараагүй биш тохиолдолд); сургагч багш болон хөгжлийн бэрхшээлтэй залуучууд хоёр ижил тэгш гэдгийг тэдэнд тайлбарлах; оролцогч хэрхэн тусламж хүсч болох талаар тодорхой удирдамж байгаа эсэхийг баталгаажуулах, оролцогчид өөрсдөө үг хэлж, үйл ажиллагаагаа өөрсдөө үргэлжүүлэхийг нь дэмжихийн тулд зөвхөн тэдний хүссэн үед нь тусламж үзүүлэх хэрэгтэй.

- **Холбогдох нийгмийн үр чадварыг онцлох:** Үр чадварыг заахдаа тухайн хөгжлийн бэрхшээлтэй холбоотой нийгмийн олон төрлийн үр чадварыг хөгжүүлэхэд илүү их анхаарал хандуулах ёстой.

Хөтөлбөрийн хэрэгжилт

- **Хөгжлийн бэрхшээлтэй болон хөгжлийн бэрхшээлгүй хүүхэд, залуучууд хамтдаа БЦБ-ыг суралцах тохиолдолд оролцогчдыг үр чадвараар нь ангилж ялгаж болохгүй:** БЦБ нь хүмүүсийн олон талт байдлыг онцлон анхаарч, хөгжлийн бэрхшээл нь хүмүүсийн бэлгийн амьдралд хэрхэн нөлөө үзүүлдэг талаар ерөнхий тоймыг танилцуулах хэрэгтэй. Ингэхдээ зарим хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын бэрхшээлийг онцлон дурьдаж болохгүй. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудыг холимог үр чадвартай орчинд бусдаас ялгаж харилцаж болохгүй.
- **Сургагч багш нарт зохих арга зүй, арга техникийн талаар гүнзгийрүүлсэн сургалт явуулж, байнгын дэмжлэг үзүүлэх** (Свиини, 2007): Сургагч багш нар хөтөлбөрийн агуулгыг хөгжлийн бэрхшээлийн төрөл тус бүр дээр тусгайлан авч үзэхээс гадна ерөнхий агуулгыг зохих ёсоор заах чадвартай байх ёстой.
- **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэглэдэг үг хэллэгийг хүндэтгэж хэрэглэх:** Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй харилцахдаа “юуны түрүүнд-эхлээд хүн” гэсэн үг хэллэгийг (жишээлбэл, “тархины саажилттай хүмүүс”, “сурах хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс”) ашиглахыг зөвлөж байна. Гэсэн хэдий ч БЦБ-ын хөтөлбөрүүд нь тухайн хөтөлбөрт хамрагдаж буй хүүхэд, залуучуудтай зөвлөлдөж, тэд өөрийгөө хэрхэн дуудуулахыг хүсэж байгааг тодорхойлох хэрэгтэй.
- **Хувийн хил хязгаарыг баримтлахад анхаарах:** Сургагч багш нар оролцогчидтой өөрсдийнхөө хил хязгаарыг тогтоох, бусдын хил хязгаарыг (хувийн орон зай, хувийн болон олон нийтийн цаг, бодол санаа, харилцан яриа, биед нь хүрэх г.м) (Шидловски, 2016) хүндэтгэхийг чухалчлах, өөрсдийн бие махбодыг хянах, бусад хүмүүс биед нь хүрэхэд татгалзахын ач холбогдлыг үлгэрлэж, оролцогчидтой ярилцах ёстой.
- **Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудыг хөгжлийн бэрхшээлгүй үе тэнгийнхэнтэйгээ харьцах боломжоор хангах:** Шаардлагатай тохиолдолд ийм харилцах холбоог нэмэлт үйл ажиллагаагаар зохион байгуулж болно.
- **Сургагч багш нарыг дэмжлэг авах боломж, холбон зуучлах механизмаар хангах.** БЦБ-ын явцад эсвэл дууссаны дараагаар нь гарч болзошгүй дарамт, хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгийн талаар мэдээлэх тохиолдолд үйлчилгээнд холбон зуучлах шаардага тулгарч болно. Ялангуяа энэ сэдвийг заасны дараа мэдээлэх магадлалтай (Жонс нар, 2014; Ханасс-Ханкок нар, 2018a; Ханасс-Ханкок нар, 2018b).

3.2.2 Бие махбодын хөгжлийн бэрхшээлтэй залуучууд

Хөтөлбөрийн хэрэгжилт

- **Хөгжлийн бэрхшээлтэй ба хөгжлийн бэрхшээлгүй оролцогчдын холимог бүлгээр зохион байгуулах.** Хөгжлийн бэрхшээлгүй үе тэнгийнхэнтэй хамтарсан сургалтууд нь үе тэнгийнхнийхээ нэгэн адил боловсрол

эзэмшихийг хүсдэг, харагдахуйц хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудад маш их таалагддаг (Эсмайл нар, 2010b). Хөгжлийн бэрхшээлтэй оролцогчдод зориулсан нэмэлт мэдээлэл, нэмэлт материалыг бие даан онлайнээр үзэх эсвэл ганцаарчилсан болон жижиг бүлгээр аюулгүй, бусдаас тусдаа орчинд үзэх боломжоор хангах ёстой (Эсмайл нар, 2010a). Гэхдээ зарим бүлгүүд, ялангуяа олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, жишээ нь галаас амьд үлдсэн хүмүүс, зөвхөн өөртэйгээ ижил төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй хамт БЦБ-ын хөтөлбөрүүдийг судлахыг илүүд үзэж магадгүй юм (Парротт ба Эсмайл, 2010).

3.2.3 Оюуны бэрхшээлтэй залуучууд

Хөтөлбөрийн төлөвлөлт ба боловсруулалт

- **Оюуны бэрхшээлтэй хүүхэд, залуучуудад бэлгийн амьдралаа өөрсдөө тодорхойлох эсвэл чадавхижихад нь туслах зорилготой байх** (Гужон, 2009; Траверс нар, 2014; Жиневра нар, 2016): Энэ нь оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын бэлгийн эрүүл мэнд, нийгэмших үр чадварыг цогц байдлаар дэмжинэ гэсэн үг юм. Боломжтой бол энэ хөтөлбөрийг бие даан амьдрах хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах нь зүйтэй (Катц ба Лазкано-Понсе, 2008). Шийдвэр гаргахад нь дөхөм болох, насанд хүрэх үйл явцад эерэг шилжилт хийхийн тулд бэлгийн боловсролыг эрт эхлүүлэх хэрэгтэй.
- **Үе тэнгийнхний харилцааг бий болгох боломжоор хангах:** Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучууд ихэвчлэн насанд хүрэгчдийн байнгын хяналтанд байдаг бөгөөд энэ нь тэднийг үе тэнгийнхэнтэйгээ утга учиртай ярилцах, харилцаа холбоо тогтооход саад болж болзошгүй. БЦБ нь нийгмийн дэмжлэг, нийгэмшүүлэх хөтөлбөрүүд эсвэл хөгжлийн бэрхшээлтэй үе тэнгийнхэнтэй хамт хийх үйл ажиллагаатай хослуулах ёстой. Энэ нь тэдэнд жинхэнэ, хүртээмжтэй орчинд сурч мэдсэн үр чадвараа дадлагдажүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын бэлгийн амьдралын талаар шаардлагатай туршлагыг олж авах боломжийг олгодог (Истгейт, 2008; Катц ба Лазкано-Понсе, 2008; Гужон, 2009 он; Сванго-Вилсон, 2010; Траверс нар, 2014).
- **Бүлгийн бүрэлдэхүүнийг сайтар төлөвлөх:** Танин мэдэхүйн янз бүрийн түвшний оролцогчдыг хэрхэн яаж бүлэгт хуваахаа бодоорой (Чаппелл нар, 2018). Оролцогчдын бүлгийг насаар нь эсвэл үйл ажиллагааг төлөвлөхөд туслах чадвар дээр үндэслэн зохион байгуулж болно.
- **Агуулгыг бус арга зүйг нь нийцүүл:** Ерөнхийдөө, хөтөлбөрийн агуулга нь тэдний үе тэнгийнхнийхтэй ижил байх ёстой (хэдийгээр оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудыг хүчирхийллийн хэд хэдэн хэлбэрт илүү өртөмтгий болохыг ойлгуулах хэрэгтэй боловч). Гэсэн хэдий ч арга зүй нь тэдний хөгжлийн түвшинд тохирсон байх ёстой бөгөөд зарим ойлголтыг хялбарчилж, нарийсгаж эсвэл өөрчлөн боловсруулсан байх ёстой. Жишээлбэл, бэлгийн замаар дамжих халдварын талаарх сэдвийг халдварт өвчин тус бүрээр нарийвчлан ярихгүйгээр урьдчилан сэргийлэх үүднээс ерөнхийд нь авч үзэж болно.
- **Оролцогчийн хамгийн ойрын буюу нэн чухал хэрэгцээг шийдвэрлэхээс эхлэх.** Жишээлбэл Дауны синдромтой хүний хувьд аюулгүй байдал, нийгмийн зохистой байдал, бие даах чадварыг авч үзэж болно (Кувенховен, 2007).
- **Шаардлагатай зүйлсийг ялгаж сурах үр чадварт анхаарлаа хандуулах.** Хүү юу, охин уу, эрэгтэй эсвэл

эмэгтэй хүний угаалгын өрөө юу гэх мэт энгийн ялгааг ялгаж сурах нь оюуны бэрхшээлтэй хүүхэд, залуучуудад өдөр тутмын амьдралаа зохицуулахад тусалдаг. Түүнчлэн нүцгэн байх нь зохимжтой эсвэл зохисгүй хүмүүсийг хооронд нь ялгаж салгах, бие засах эсвэл сарын тэмдгийн үед бусдаас тусламж авах, биеийн зарим хэсэгт хүрэх, сургуулиас хэрхэн гарах зэрэгт тусламж авах талаар ярих нь чухал юм (Ханасс-Хэнкок нар., 2018a; Жонс нар, 2014; Герхардт, нар).

Заах ба суралцах арга барил

- **Үзүүлэн танилцуулгыг аль болох бодитоор үзүүлэх:** Жишээлбэл, жирэмслэлт, эцэг эх байх талаар ярилцахдаа нялх хүүхдийг хооллох, живх солих, бусад асаргаа зэргийг тайлбарлахын тулд хичээлд нялх хүүхдийг авчирч харуул (Бойнинг, 2006). Санал болгох сургалтын материалд гурван хэмжээст загварууд, анатомийн хувьд зөв бүтэцтэй хүүхэлдэй, фото зураг, зураг, видео, диаграмм орно.
- **Нийгмийн үр чадвар, биеэ авч явах соёлыг харуулах нөхцөлийг бүрдүүлэх:** Үр чадвар, зан авир тус бүрийг тодорхой байршилд байрлуул, жишээ нь дэлгүүрт байгаа хэн нэгэнтэй хэрхэн мөндлөх, энэ нь ажлын байран дээр эсвэл гэртээ байхтай харьцуулбал ямар ялгаатай гэх мэт.
- **Хангалттай цаг олгож, агуулгыг давтах:** Хүүхэд, залуучууд оюуны бэрхшээлтэй хүмүүст суралцах чадварыг дээшлүүлэхэд илүү их цаг хугацаа шаардагдана (Мерфи ба Элиас, 2006; Кувенховен, 2007; Жонс нар, 2014; Шафсма нар, 2017; King County, 2018). Үйл ажиллагааг жижиг, энгийн алхам болгон хуваа. Агуулгыг байнга давтаж, өөр орчин, нөхцөл байдал ашиглан, танихгүй хүмүүст зааж давтах хэрэгтэй. Мэдлэг, үр чадварыг цаашид тогтвортой хадгалахын тулд дэмжих хичээлүүд, давтамжтайгаар эргэн бататгах шаардлагатай байдаг (Сванго-Вилсон, 2010; Шафсма нар, 2015; Виссор нар, 2017). Дахин давтах нь Дауны синдромтой хүмүүст илүү тустай байдаг (Кувенховен, 2007).
- **Зан үйлийн эерэг бэхжүүлэлт, магтаалыг маш их ашиглах:** Энэ нь оролцогчдод бэлгийн амьдралын талаарх мэдлэгийг эерэг туршлага гэж ойлгоход тусална (Баксли ба Зэнделл, 2011).
- **Сургаж болох мөч болон санамсаргүй байдлаар зааж сургах боломжийг ашиглах:** Хэрэв өрөөнд байгаа хэн нэгэн жирэмсэн бол жирэмсний талаар заах сайхан боломж болно (хэрэв тэд зөвшөөрсөн тохиолдолд) эсвэл хичээлийн агуулгатай холбоотой дүү тавьж болно. (Мосс ба Блаха, 2001).
- **Бэлгийн хүчирхийлэл, дарамтыг мэдээлэх талаар хэлэлцэх үед оролцогчид хүчирхийллийн талаар мэдээлэх боломжтой хэн нэгнийг хамт оролцуулах:** Зарим оролцогчид хөгжлийн бэрхшээлийнхээ улмаас харж суралцдаг хүмүүс байж болох бөгөөд хэн нэгэнтэй утсаар болон имэйлээр холбоо барих нь илүү хэцүү байж болно. Хэрэв холбоо барих хүнийг байлцуулах боломжгүй бол оролцогчид хэнд хандах ёстойгоо тодорхой ойлгосон байх ёстой. Жишээлбэл, тэд өөрсдийн гарыг тойруулан гарынхаа зургийг зураад, хуруу тус бүр дээрээ эцэг эх, цагдаа, зөвлөх, нийгмийн ажилтан гэх мэт холбоо барьж болох хүмүүсийн нэр, утасны дугаарыг бичиж болно. Оролцогчид дор хаяж гурван хүний нэр, хаягийг бичсэн байх ёстой бөгөөд хэрэв эхний хүн холбогдохгүй бол тэд дараагийн хүнтэй нь холбоо барьж болно. Хүүхэд, залуучуудын аюулгүй байдал хамгийн чухал тул бичгээр гаргасан мэдээллийг хүчирхийлэгч байж болзошгүй этгээд олж илрүүлэх боломжтой эсэхийг оролцогчидтой хамт ярилцаж, хэрхэн хянамгай байх, нууцлалыг хадгалах арга зам, мөн холбоо барих мэдээллийг хэрхэн аюулгүй хадгалж, амьдралдаа итгэдэг насанд хүрэгчидтэй хэрхэн аюулгүй, болгоомжтой хуваалцаж болох талаар ярилцах хэрэгтэй.

Хөтөлбөрийн хэрэгжилт

- **Хичээлийг аажуу хурдаар явуулж, илүү олон завсарлага оруулах:** Оролцогчдыг хэт их мэдээллээр бүү дар.
- **Боломжтой бүх тохиолдолд оролцогчдын эх хэлийг ашиглах:** Энэ нь ялангуяа биеийн бусад хүн хүрч болохгүй хувийн хэсгүүд, бусдын биед хүрэх өөр арга хэлбэрүүд эсвэл эмзэг хувийн асуудлуудыг хэлэлцэхэд чухал байдаг (Чаппелл, 2018).
- **Агуулгыг маш тодорхой нэр томъёогоор дамжуулан олгох:** Аливаа тайлбарыг хийхдээ маш тодорхой, энгийн, шууд илэрхийлсэн үг хэллэгийг ашиглаарай (Катц ба Лазкано-Понсе, 2008; Гужон, 2009; Траверс нар, 2014; Холланд-Холл ба Квинт, 2017). Мэдээлэл нь шинжлэх ухааны үндэслэлтэй эсвэл бодитой байх ёстой, гэхдээ хэт техникийн байж болохгүй. “Хамтдаа унтана” гэх мэт хэт хялбаршуулсан үг хэллэг, давхар утгатай үгсээс зайлсхий (Холланд-Холл ба Квинт, 2017). Сургагч багш нар хөтөлбөрийн туршид “Энэ нь зөвхөн хувийн орон зай” гэх мэт түлхүүр үгс эсвэл ойлголтуудыг байнга давтах ёстой (Жон нар, 2014).
- **Зохисгүй зан авир гарсан тохиолдолд хэт их хариу үйлдэл үзүүлэх эсвэл хариу үйлдэл бараг үзүүлэхгүй байхаас зайлсхийх** (Мосс ба Блаха, 2001): Оюуны маш хүнд бэрхшээлтэй хүмүүсийн хувьд нь тэднийг зохисгүй зан үйл гаргах үед, тухайлбал олон нийтийн газар гар хангалга хийх, эсвэл хувцсаа тайчих үед нь идэвхжүүлэгч багш нар нь засаж, залруулж байх ёстой. Мөн өнгөрсөн хойно нь хичээлийн агуулгыг заахаас илүүтэйгээр дахин дахин залруулга хийх хэрэгтэй.
- **Биед нь бүдүүлгээр хүрэхээс зайлсхийх:** Оролцогчдод тэдний бие тэр чигээрээ хувийн орон зай гэдгийг, хэн нэгэн тэдэнд хүрэхээс өмнө тэдний зөвшөөрлийг асуух хэрэгтэй гэдгийг зааж өг; бие махбодынхоо талаар шийдвэр гаргах, ялангуяа үрийн сувгийг боолгох, жирэмслэлтээс хамгаалах, жирэмслэхтэй холбоотой шийдвэрийг бие даан гаргах эрхтэй талаар; тэд “үгүй” гэж хэлэх эрхтэй гэдгийг; тэврэлт, үнсэлтгүйгээр мэндчилэх аргууд (хөгжлийн бэрхшээлтэй залуучууд мэндчилэхдээ заавал бусдын хувийн орон зайд халдах шаардлагагүй гэдгийг ойлгуулах үүднээс); мөн “амаараа” “тийм” гэж хэлэх нь зөвхөн тийм гэсэн утгатай болохоос толгой дохих, инээмсэглэхийг хэлдэггүй (учир нь тэдний хөгжлийн бэрхшээл нь сүл дорой байдлыг бий болгодог тул тэд харилцан тохиролцоогүй бэлгийн үйлдэлд буруутгагдсан бол тэдэнд итгэхгүй байх шалтгаан болдог гэдгийг тайлбарлах хэрэгтэй).

3.2.4 Сонголгүй болон сонсголын бэрхшээлтэй залуучууд

Хөтөлбөрийн төлөвлөлт ба боловсруулалт

- **Өөрийн ухамсаргүйгээр өрөөсгөл хандлага гаргахгүйн тулд өөртөө шүүмжлэлтэй хандах:** БЦБ-ын хөтөлбөрийг боловсруулахад оролцож буй сонсголын бэрхшээлтэй хүмүүс ухамсаргүйгээр өрөөсгөл хандлагад хүргэдэг дүлий байх талаарх нийтлэг хэвшмэл ойлголтуудыг мэддэг байх нь чухал юм.
- **Бүх үр дүнтэй, тохиромжтой харилцааны арга хэрэгслийг ашиглахыг сурталчлах:** Үүнд:
 - **дохионы хэл**
 - **мэдээллийн цогц харилцаа** (мэдээлэл харилцааны бүхий л хэрэгслийг агуулсан, үүнд: албан ёсны дохионы

хэл, байгалийн дохио зангаа, хурууны үсэг, биеийн хэл, сонсох, уруулаар унших ба уруулаар ярих)

- **хос хэл / хоёр соёл** (сонсох болон Сонсголгүйн соёлыг⁴ аль алинд нь үнэн сэтгэлээсээ хандах, ач холбогдолыг нь хүлээн зөвшөөрөх ба хоёулангийнх нь элементүүдийг хичээлүүдэд оруулж, нэгтгэж өгөх)
- **авиа болон дохионы хэлийг хослуулан ярих** (cued speech -ярианы хэлний бүх дуу авиаг харагдахуйц байдлаар амны хөдөлгөөнд оруулж, дохионы хэлний “дохио” -той хослуулдаг харилцааны систем)
- **уруулын хөдөлгөөнөөр унших аргууд**
- **бичлэг тоглуулах ба FM системүүд** (чанга яригч ашигладаг дамжуулагч ба сонсогчийн ашигладаг хүлээн авагчаас бүрдэх утасгүй сонсголын туслах хэрэгслүүд), мөн аудио-визуал мэдээллийн хэрэгсэл дээр тайлбар оруулах нь сонсголын бэрхшээлтэй хүмүүсийн харилцааны хүртээмжийг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг. (ДЭМБ, 2016б).
- **Сонсголын бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын гэр бүл, эцэг эх, асран хамгаалагчдыг дохионы хэл сурахыг сурталчлах:** Энэ нь харилцаа холбоог сайжруулж, бэлгийн амьдралын талаарх харилцан яриаг дэмжих ач холбогдолтой юм (Ламуре, 2014).
- **Боломжтой бол сонсголгүй, сонсголын бэрхшээлтэй хүүхэд залуучуудыг эцэг эхтэй нь хамтарсан хичээлүүдийг төлөвлөх:** Иймэрхүү арга хэмжээ нь сонсголын бэрхшээлтэй эцэг эхчүүд сонсголын бэрхшээлтэй хүүхэд, залуучуудыг бүлгийн ярианд татан оролцуулахад нь туслах болно.

Заах ба суралцах арга барил

- **Үзүүлэн, тэмтрэх, нүүрний хувирлын аргуудыг ашиглах:** Эдгээр аргууд нь сонсголгүй, сонсголын бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын сурах хэв маягт илүү тохиромжтой байдаг. Арга зүй нь бичгийн хэлэнд хэт найдах ёсгүй.
- **Биеэр шууд үзүүлэх аргыг ашиглах:** Театр, жүжиг, дүрд тоглох зэрэг нь дүлий буюу сонсголын бэрхшээлтэй хүүхэд, залуучуудад бусдын харилцаа, тэдгээрийн үр нөлөөг ажиглах боломжийг олгоно. Бусад ашиг тустай аргуудад жижиг бүлгийн хэлэлцүүлэг, дүлий буюу сонсголгүй зочин багш урих, анатоми, физиологийг заах гурван хэмжээст загвар, дохионы хэл дээрх видео бичлэгүүд орно (Ламуре, 2014). Боломжтой бол видеонуудад тайлбар хэсгийг нүүх эсвэл ил болгох сонголт байх ёстой. Хэрэв орчуулагч видео бичлэг дээр байгаа бол тэдгээрийг илүү том дэлгэц дээр, дагалдах илтгэгчийг жижиг видеонд харуулах ёстой.
- **Бичсэн материалыг оролцогчдын унших түвшинд тохирч буй эсэхийг баталгаажуулах:** Аливаа товхимол эсвэл бусад баримт бичигт зураг, зураг гэх мэт дүрслэлийг багтаасан байх. Үгнээс илүү тод дүрслэлийг илүү анхаарч, энгийн үг хэллэг ашиглахыг хичээ (Ламуре, 2014). Хэл яриа муутай, эсвэл боловсруулалтын хурд бага, эсвэл ойлгох чадвар буурсан оролцогчдын хувьд сургагч багш нар нэг ойлголтыг олон давтах, олон удаа эсвэл удаан хугацааны турш харуулах шаардлагатай болж магадгүй юм.

Хөтөлбөрийн хэрэгжилт

- **БЦБ-ыг дохионы хэлээр зааж буй багш нар дохионы хэлээр чөлөөтэй ярьдаг, сонсголгүйн соёлыг хүчтэй мэддэг сургагч багш нар зааж буй эсэхийг баталгаажуулах:** Сургагч багш нарын оролцогчидтой чөлөөтэй бөгөөд сайн харилцах чадвар нь сонсголын бэрхшээлтэй хүүхэд,

⁴“D” гэсэн том үсгээр бичсэн Сонсголгүй соёлтой хүн өөрийгөө соёлын хувьд Сонсголгүй хүний соёлыг бүрэн эзэмшсэн, өөрийгөө Сонсголгүй гэж тодорхойлдог. “Жижиг” үсгээр бичсэн сонсголгүй хүмүүс бол сонсголгүй хүний соёлтой тийм ч хүчтэй холбоогүй хүмүүсийг хэлнэ.

залуучуудад зориулсан БЦБ-ын хамгийн чухал хүчин зүйл бөгөөд энэ нь тэдний хувьд ямар ч боловсролын хөтөлбөрт чухал байдаг. Зөвхөн уруулаар уншихад найдах нь суралцахад үр дүн багатай байдаг, учир нь тухайн хүн зөвхөн хэлсэн зүйлийн тодорхой хэсгийг л ойлгодог. Сонсголын аппарат эсвэл дунгийн суулгац гэх мэт үлдэгдэл сонсголтой эсвэл туслах хэрэгслийг ашигладаг хүмүүст ярьж тайлбарлаж болох боловч тухайн суралцагч сонсож буй хүний хэлсэн зүйлийн ихэнхийг эсвэл бүгдийг нь ойлгож чадаж байгаа тохиолдолд л хэрэглэж болно.

- **Сургагч багшийн ашиглаж буй дохионы хэл нь оролцогчдын ашигладаг аялга мөн эсэхийг баталгаажуулах:** Янз бүрийн бүлгүүдийн дохионы хэлний аялгуу өөр өөр байдаг тул энэ нь чухал юм (Ламуре, 2014).
- **Дохионы хэл дээр байхгүй холбогдох үг хэллэгийг нөхөх:** Заримд нь дохионы хэлэнд бэлгийн амьдралын талаарх үгсийн санд зориулсан стандарт тэмдэг дохио байхгүй, эсвэл оролцогчид хар ярианы хэл ашиглаж байж болно. Эдгээр тохиолдолд оролцооны аргуудыг ашиглаж, эдгээр тэмдэглэл дохиог сургагч багш нар болон оролцогчид хамтран боловсруулах хэрэгтэй.
- **Хэрэв сургагч багш нар дохионы хэлний мэдлэггүй бол орчуулагчтай хэрхэн үр дүнтэй ажиллах талаар сургалтанд хамрагдсан эсэхэд анхаарах:** Сургагч багш богино өгүүлбэр ашиглаж, дохионы хэлээр тайлбарлах эсвэл уруулаар уншихад цаг гаргах хэрэгтэй бөгөөд ингэхдээ сонсголын алдагдал нь оролцогчдын оюуны чадавхид нөлөөлөхгүй гэдгийг анхаарч байх ёстой. Аливаа визуал хэрэгслийг дохионы хэлмэрчийн хажууд байрлуулсан байх ёстой. Сонсголгүй эсвэл сул сонсголтой оролцогчид дохионы хэлний орчуулагчаас хараагаа сольж, аливаа зурган мэдээлэлд анхаарлаа хандуулахад тодорхой хугацаа шаардагддаг тул сургагч багш нэгэн зэрэг ярих, үзүүлэн рүү заангаа ярихаас зайлсхийх хэрэгтэй.
- **Дохионы хэлний хэлмэрчид оролцогчдын унаган дохионы хэлийг ашиглах боломжтой эсэхийг баталгаажуулах:** Хэрэв хөтөлбөрийг дохионы хэлээр шүүд дамжуулах боломжгүй бөгөөд хөндлөнгийн дохионы хэлний орчуулагч ашиглах шаардлагатай бол орчуулагчийн ойлгох болон орчуулах үр чадварын түвшинг шалгана уу. Ингэхдээ орчуулагчийн дохионы хэл ойлгомжтой байгаа эсэхийг оролцогчдоос асуух замаар шалга.
- **Сургагч багш нар хүчирхийллийн шинж тэмдгүүд, түүний дотор бэлгийн хүчирхийллийг хэрхэн танихаа мэддэг байх:** Сонсголын бэрхшээлтэй хүүхэд, залуучууд бусдын яриаг сонсож, эсвэл радио, телевиз болон бусад аудио эх сурвалжаас бэлгийн зохистой харилцааны талаар сурч авах боломжгүй бөгөөд эцэг эх, асран хамгаалагч эсвэл бусад итгэмжлэгдсэн насанд хүрэгчид нь дохионы хэл мэдэхгүй, өөрсдөө хэл яриагаараа илэрхийлэх боломжгүй байвал хүчирхийллийн талаар мэдээлэхэд бэрхшээлтэй байдаг.

3.2.5 Хараагүй залуучууд

Хөтөлбөрийн төлөвлөлт ба боловсруулалт

- **Хүүхэд, залуучууд бэлгийн амьдралын талаарх ойлголтыг нүдээр ажиглах замаар хэрхэн сурдаг болохыг харгалзан, хараагүй хүмүүст хэрхэн үүнийг хүргэхийг авч үзэх:** Хөтөлбөр боловсруулагчид бэлгийн амьдралын эдгээр шинж чанарууд болон түүнтэй холбоотой хүний зан үйлийг тодорхойлж, БЦБ-ын хөтөлбөрт тусгах ёстой. Үүнд: албан болон албан бус орчин дахь ердийн биеийн

хэл, дохио зангаа; хүмүүстэй ямар харилцаатай гэдгээс хамаарч тэднээс хэр хол зайнд зогсох; хөшиг татаагүй бол хүмүүс цонхоор харах боломжтой гэдгийг тайлбарлах.

Заах ба суралцах арга барил

- **Боломжтой бол зохих материалуудыг буюу брайл үсгийг ашиглах:** Сургагч багш нар дэлгэц унших хөтөлбөр хангамж, брайл гар, ярианы синтезаторыг ашиглаж болно (Давиес, 1996). Брайл үсэг байхгүй тохиолдолд доор жагсаасан аргууд нь суралцахад дэмжлэг үзүүлнэ. Харааны бэрхшээлтэй оролцогчдын хувьд том хэмжээтэй хэвлэмэл материал, зурган тэмдэглэл, тод өнгө бүхий өндөр контрасттай материалыг ашиглах, өрөөнд хангалттай гэрэлтүүлэгтэй эсэхийг шалгах.
- **Хараагүй оюутнуудад сургалтын материалуудыг тэмтрэх, хүрч мэдрэх аргыг ашиглах боломжийг олгох:** Жишээлбэл, анатоми, бэлгийн хариу үйлдэл, бэлгэвчний хэрэглээ зэргийг заахдаа анатомийн зөв загварыг ашиглаарай (Крупа ба Эсмэйл, 2010).
- **Үгийг төсөөлөхөд баялаг, гүнзгий, тодорхой, илэн далангүй, олон мэдрэхүйн тодорхойлолт ашиглан тайлбарла:** Өндөр, богино, булчинлаг гэх мэт харааны бүрэлдэхүүн хэсэгтэй ойлголтуудыг тайлбарлаж өгөх нь чухал юм.
- **Танил биш ойлголтуудыг нарийвчлан тайлбарлах:** Бүрэн хараагүй хүүхэд ба залуучууд хүйс, биеийн төрх байдал, хувийн орон зай, хувийн хил хязгаар, анатомийн ялгаа, бэлгийн зан үйл, бэлгийн холбогдолтой үг хэллэгийн талаар өөр ойлголттой байж болно.

Хөтөлбөрийн хэрэгжилт

- **Хараагүй болон хараатай хүмүүсийг сургагч багшаар ажиллуулах:** Хараагүй сургагч багш нарыг оролцуулахыг зөвлөдөг боловч хараагүй оролцогчид хараатай сургагч багшаас суралцах нь чухал байдаг, учир нь тэд хараатай хүний үзэл бодлыг сонсох, харсан зүйлийг нь дүрслэн яриулах нь тэдэнд тустай байдаг.
- **Оролцогчдод сайтар анхаарлаа хандуулах:** Тэмтрэх аргыг ашиглаж буй БЦБ нь ганцаарчилсан хэлбэрээр, эсвэл тэмтрэх арга нь тохиромжгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг оролцуулаагүй жижиг бүлгүүдээр хүргэх ёстой. Хараагүй оролцогчдод сул хараатай үе тэнгийнхнээсээ асуулт асуух боломж олгоорой (Ханасс-Хэнкок нар, 2018а).
- **Оролцогчдын биеийн хил хязгаарыг хүндэтгэх:** Сургагч багш нар биеэр үзүүлэх аргыг ашиглаж болно, гэхдээ тэд биед хүрэхээсээ өмнө оролцогчдоос үргэлж зөвшөөрөл авч байх ёстой, ингэснээр тэдэнд мэдээлэлтэй, бэлтгэлтэй байхад туслахаас гадна, тэдний биед хэн хүрч болохыг хянах боломжтой гэдгийг баталгаажуулдаг.

3.2.6 Аутизмын спектрийн эмгэгтэй залуучууд

Ерөнхийдөө аутизмын спектрийн эмгэгтэй, үйл хөдлөлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудад, ялангуяа танин мэдэхүйн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст Бүлэг 3.2.3. дэх оюуны хөгжлийн бэрхшээлийн талаар зөвлөмжүүдийг ашиглана. Үйл хөдлөлийн чадвар маш өндөртэй хүүхэд залуучууд ердийн сургуульд хамрагдах магадлалтай бөгөөд тэнд БЦБ-ыг заадаг бол сургууль дээрээ хамрагдах боломжтой.

Заах ба суралцах арга барил

- Аутизмтай хүүхэд, залуучуудад заах, суралцах явцыг нь бэхжүүлэх зорилгоор тусгайлан боловсруулсан арга зүйг ашигла. Үүнд:
 - хэрэглээний зан үйлийн дүн шинжилгээ⁵
 - нийгмийн түүхийн арга техник⁶
 - салангид туршилтын сургалт⁷
 - үзүүлэнгээр дэмжлэг үзүүлэх: оролцогчийн хийх ёстой зүйлийг цуврал зураг эсвэл визуал дүрслэлээр сануулж, бие даан хийх боломжийг олгох.
 - дөхүүлэх: чиглүүлэгч багш нар зааж буй хүссэн зан үйлийг ойролцоогоор илэрхийлэх, бэхжүүлэх зан үйлийг ашиглах
 - танин мэдэхүйн давтлага сургуулилт хийх: сургагч багш, оролцогч тодорхой асуудлыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлж, дадлага хийхэд хамтран ажиллах
 - хувийн түүхүүд: нийгмийн нөхцөл байдлыг тайлбарласан түүхүүдийг оролцогчдын онцлогт нийцүүлэн ашиглах, ж.нь. тэдний эсвэл тэдний гэр бүлийн гишүүд, найз нөхдийн зургийг оруулах зэргээр оролцогчдод эдгээр нөхцөл байдалд юу хүлээж байгаа, хэрхэн биеэ авч явахыг заах.
 - зан үйлийг үлгэрлэх: биечлэн эсвэл видео ашиглан үлгэрлэх (Герхардт, 2013).
- Хичээлүүдийг нөхцөл байдал тус бүрээр бэлтгэн хүргэх: Аутизмын спектрийн эмгэгтэй хүмүүст олон дахин давтахаас илүү нөхцөл байдалд тохируулсан байх нь чухал байдаг. Олон давталт ашиглахаас илүүтэйгээр оролцогчдын ойлголтыг шалга. Зарим ойлголтын нийтлэг дүр зургийг бататгахын тулд олон жишээнүүдийг оруул (Герхардт, nd).
- Оролцогчдоос хамааран бүлгийн ажил эсвэл ганцаарчилсан үйл ажиллагааг зохион байгуулах: Аутизмын спектрийн хөнгөн буюу дунд зэргийн эмгэгтэй хүмүүст жижиг бүлгээр ажиллахыг зөвлөдөг, гэхдээ хүнд хэлбэрийн аутизмтай хүмүүст зөвхөн богино хугацааны бүлгийн ажлыг зөвлөдөг ба ихэнхдээ ганцаарчилсан үйл ажиллагааг зөвлөдөг.
- Ашиглах харааны эх сурвалжийг аль болох энгийн байлгах: Зураг нь төвөгтэй, олон мэдээлэл агуулсан байх ёсгүй, учир нь оролцогчид тухайн зургийн ерөнхий утга санаанаас илүүтэйгээр нарийн ширийн зүйл дээр анхаарлаа төвлөрүүлж болзошгүй юм (Герхардт, nd). Зургийн гол санааг оролцогчид шууд тодорхойлох боломжтой байх ёстой. Оролцогчдод зураг дээрх царайны

хувирал, биеийн хэлэмжийг тайлбарлахад тусламж шаардлагатай байж болно (Жонс нар, 2014).

- Нарийвчилсан мэдээлэл гэхээсээ илүү ухагдахуунууд дээр илүү анхаарах: Аутизмын спектрийн эмгэгтэй оролцогчид нэг үндсэн ойлголт дээр төвлөрөхөөсөө илүүтэйгээр тухайн ойлголтын нарийвчлан хэсгүүдэд илүү анхаарч авч үзэж болно. Нийгмийн ухагдахуунуудыг ойлгоход тэдэнд хэцүү байж болох тул сургагч багш нар бүх зүйлийг энгийн алхамуудаар зааж, тухайн ойлголтыг тэд хэрхэн ойлгож байгаад анхаарлаа төвлөрүүлэх хэрэгтэй (Жонс нар, 2014).

3.2.7 Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй залуучууд

Заах ба суралцах арга барил

- Танин мэдэхүйн боловсруулалт хийх эсвэл ярианы бэрхшээл тулгарч болзошгүйг харгалзан үзэх: Сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс тэдний өвчний шинж тэмдгүүдээс эсвэл эм тариа зэргээс болж бэрхшээлтэй тулгардаг бөгөөд энэ нь тэдний анхаарлаа төвлөрүүлэхэд саад болж, нойрмоглох, амархан цочирдох, хэл яриа удаашрах байдалд хүргэдэг. Энэ тохиолдлуудад оюуны бэрхшээлтэй хүмүүст зөвлөдөг аргуудтай ижил төстэй аргуудыг ашиглах шаардлагатай.
- Боломжтой тохиолдолд тодорхой жишээнүүд, мэдрэхүйн олон талт үйл ажиллагаа, дүрд тоглох зэргийг ашиглах: Эдгээрийг залуучуудын нөхцөл байдалд тохируулан боловсруулсан байх ёстой. Дүрд тоглох нь сэтгэлзүйн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудад нөгөө талын дүрд орж дадлага хийхэд тустай байдаг, учир нь тэдэнд өөрсдийгөө бусдын оронд тавьж үзэх илүү хэцүү байдаг.

Гол баримт бичиг ба сургалтын хөтөлбөр

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, өсвөр насныхны амьдралын үе шат бүр дэх бэлгийн амьдрал (Флоридагийн хөгжлийн бэрхшээлийн зөвлөл, 2011)
- Сурагчдад зориулсан бэлгийн эрүүл мэндийн боловсрол
- Ялгаатай чадварууд (Alberta Health Services, 2017)
- Бэлгийн эрүүл мэндийн боловсролын FLASH сургалтын хөтөлбөр: Тусгай боловсролын хичээлийн төлөвлөгөө (Public Health Seattle & King County, 2005-13)
- Хувийн аюулгүй байдлын төлөвлөлтийг ухамсарлах сонголт хийх эрх мэдэл олгох (SPACE): Эмэгтэйчүүдэд зориулсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр (Арк Мэриленд)
- Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд ба залуучууд: Жендэрт суурилсан хүчирхийлэл, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн эрхэд суурилсан ба жендэрийн хариу үйлчилгээ үзүүлэх удирдамж (НҮБ-ын Хүн амын сан, 2018)
- Харааны бэрхшээлтэй оролцогчидтой бэлгийн амьдралын талаарх асуудлыг шийдвэрлэх нь (Перкинсийн Хараагүйчүүдийн сургууль, 2014 он, видео)
- Аутизмын спектрийн эмгэгтэй сурагчдын дунд боловсролын төв (CSESA) (вэбсайт)
- Бэлгийн харилцаа ба хөгжлийн бэрхшээл (вэбсайт)
- Суралцах бэрхшээлтэй хүмүүсийг бэлгийн болон романтик харилцаа хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх (Тэгш хамруулах асуудлаарх үндэсний хөгжлийн баг, 2016)

⁵ Холбоосыг үзнэ үү. <https://www.autismspeaks.org/applied-behavior-analysis-aba-0>

⁶ Холбоосыг үзнэ үү. <http://best-practice.middletonautism.com/approaches-of-intervention/social-stories/>

⁷ Холбоосыг үзнэ үү. <https://www.autismspeaks.org/expert-opinion/what-discrete-trial-training>

- Хөгжлийн бэрхшээлтэй залуучууд: Жендэрт суурилсан хүчирхийллийг таслан зогсоох, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхээ хэрэгжүүлэх асуудлаарх олон улсын судалгаа (НҮБ-ын Хүн амын сан, 2018)
- Секс ба дотно харилцааны талаар ярилцах: Суралцах бэрхшээлтэй залуучуудын үзэл бодол (ӨӨРЧЛӨЛТ, 2009)
- Энэ бол чадвар: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцийн тайлбар (НҮБ-ын Хүүхдийн сан, 2008)
- Эрүүл харилцаа, бэлгийн амьдрал ба хөгжлийн бэрхшээл:
- Ашиглах материалын удирдамж 2014 Edition (Массачусетсийн Нийгмийн эрүүл мэндийн газар, 2014)
- Үр нөлөө: Бэлгийн харилцаа ба оюуны, хөгжлийн болон бусад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн зарим асуудал (Олон нийтийн интеграцчилал судалгааны хүрээлэн ба Олон нийтийн хамтын амьдралын сургалтын төв, Миннесотагийн Их Сургууль, 2010)
- Тусгай хэрэгцээт оюутнуудад зориулсан хүний бэлгийн боловсрол (MarshMedia, 2007)
- Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудыг бэлгийн харилцаанд сургах: Би юу гэж хэлэх вэ? Би үүнийг яаж хэлэх вэ? (Өсвөр насны жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх арга зүйн төв, вэбсайт)
- Мэдрэхүйн бэрхшээлтэй хүмүүст нийгмийн ур чадвар ба бэлгийн боловсролыг олгох ашиглах материалын жагсаалт (Перкинсийн хараагүйчүүдэд зориулсан сургууль, 2014)
- PleasureABLE: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан сексийн төхөөрөмжийн гарын авлага (Хөгжлийн бэрхшээлийн эрүүл мэндийн судалгааны сүлжээ, 2009)
- Хөгжлийн бэрхшээл ба ХДХВ (ДОХ-той тэмцэх НҮБ-ын хөтөлбөр, 2017)

3.3 Хүмүүнлэгийн нөхцөл дэх залуучууд

Хүмүүнлэгийн хямрал нь олон тооны хүмүүсийн сайн сайхан байдал, аюулгүй байдал, эрүүл мэндэд заналхийлсэн үйл явдал эсвэл цуврал үйл явдлын улмаас бий болдог. Хямрал гэнэт, мөчлөгт эсвэл аажмаар эхэлдэг. Эдгээр нь байгалийн шалтгаантай эсвэл хүний хүчин зүйлийн улмаас бий болсон байж болзошгүй бөгөөд энэ нь байгалийн гамшиг, зэвсэгт мөргөлдөөн, хавчлага ба геноцид, тахал, уур амьсгалын өөрчлөлт, өлсгөлөн, эдийн засгийн бөөнөөр шилжих шилжилтийн улмаас бий болсон ядуурал, тэгш бүс байдал зэрэг байж болно.

Хүмүүнлэгийн нөхцөлд байгаа залуучуудад дараах залуучууд багтаж болно. Үүнд:

- **Дотооддоо нүүлгэн шилжүүлэгдсэн**, энэ нь тэд одоо ч гэсэн эх орондоо амьдарч байгаа ч, гэрээ орхин явах шаардлагатай болсон гэсэн үг.
- **Дүрвэгсэд**, ихэвчлэн өөрийн эх орноо орхин хөрш зэргэлдээх улс орон руу нүүх шаардлагатай болсон гэсэн үг.
- **Тусгаарлагдсан**, энэ нь эцэг эхээсээ хоёулангаас нь эсвэл тэдний хууль ёсны болон ёс заншлын дагуух анхдагч асран хамгаалагчаасаа тусгаарлагдсан, гэхдээ бусад хамаатан саднаас тусгаарлагдаагүй байж болох хүүхдүүд (өөрөөр хэлбэл 18 нас хүрээгүй хүн) гэсэн үг юм. Тэд гэр бүлийн бусад насанд хүрсэн гишүүдээ дагалдаж байж болно.
- **Хараа хяналтгүй**, энэ нь эцэг эх, бусад хамаатан саднаас хоёулангаас нь тусгаарлагдсан хүүхдүүд бөгөөд хууль ёсны болон ёс заншлын дагуу тэднийг асран хамгаалах үүрэгтэй насанд хүрэгчид байдаггүй хүүхдүүд юм.

- **Харьяалалгүй хүн**, энэ нь тэдгээрийг хуулийн дагуу аль ч улсын иргэнд тооцдоггүй гэсэн үг юм.

Нийт дүрвэгсдийн талаас илүү хувь нь 18-аас доош насны хүмүүс байдаг гэсэн тооцоо байдаг (НҮБДАХДКГ, nnd). 2017 онд хараа хяналтгүй, тусгаарлагдсан 173,000 гаруй хүүхэд байсан (НҮБ-ын Хүний эрхийн хороо, 2017). Дүрвэгсэд болон дотооддоо нүүлгэн шилжүүлсэн хүмүүсийн дийлэнх нь хуаранд биш, хотуудад амьдардаг (НҮБДАХДКГ-д АНУ-аас, 2018). Тэдний нөхцөл байдал ихэвчлэн тогтворгүй байдаг: тэд байнга шилжин нүүдэл хийж, замд явж, шилжин нүүж, эсвэл тодорхой газарт гацсан байдаг. Заримдаа тэд эзэнгүй талд эсвэл гудамжинд амьдардаг, эсвэл тэднийг хоргодох байранд байрлуулж, цагдан хорих төвүүдэд хорьж байж ч болно.

Хүмүүнлэгийн хямралын үеэр хүүхэд, залуучуудын эрүүл өсөлт, хөгжлийг дэмждэг өдөр тутмын бүтэц зохион байгуулалттай, байгууллагууд тасалддаг: тэдний хичээл сургууль ихэвчлэн тасалдаж эсвэл завсарддаг, олон нийтийн болон нийгмийн сүлжээ задарч, гэр бүлүүд ихэвчлэн бие биеээсээ тусгаарлагддаг. Ийм нөхцөл байдалд байгаа хүүхэд, залуучууд өсвөр насандаа хэрэгцээтэй боловсрол, мэдээлэл, орчин нөхцөлөөр хангагдаж чадахгүй, үйлчилгээний хүртээмж, хамгаалалт багатай байдаг. Гэр бүлээсээ тусгаарлагдсан эсвэл өрх тэргүүлж буй хүүхэд залуучууд хоол хүнс, орон байр, хамгааллын хэрэгцээгээ хангахын тулд сургуулиа хаях, мөлжлөгийн хөдөлмөр эрхлэх, биеэ үнэлэх, эсвэл гэрлэх шаардлагатай болдог (Кернер нар, 2012). Түүнээс гадна хүмүүнлэгийн хямралын үеэр болон дараах эмх замбараагүй үед тэд бэлгийн хүчирхийлэл, хүчирхийлэл, мөлжлөгт өртөх эрсдэл өндөр байдаг (Кернер нар, 2012).

Дээр дурдсан бүх зүйлүүдийн улмаас хүмүүнлэгийн орчинд байгаа хүүхэд, залуучууд эрт жирэмслэх, аюултай үр хөндөлт хийлгэх, бэлгийн замаар дамжих халдвар ба ХДХВ, нийгмийн гутаан доромжлол, сэтгэлзүйн хямрал, цочролд өртөх эрсдэлтэй болдог (Кернер нар, 2012). Дүрвэгсэд эсвэл орогнол хүсэж буй хүүхэд, залуучууд тэднийг хүлээн авсан улс орныхоо бэлгийн амьдрал, бусадтай бий болгох харилцаатай холбоотой соёлын ялгаатай байдлыг давж гарах хэрэгтэй болдог. Ялангуяа тэд консерватив үзэлтэй улсаас либерал улс оронд шилжиж ирсэн тохиолдолд бэлгийн харилцааны үнэлэмж, үг хэллэг, ёс заншил болон холбогдох хууль тогтоомжийг ойлгохгүй байж болно.

Хөтөлбөрийн төлөвлөлт ба боловсруулалт

- **Онцгой байдлын үеийн бэлэн байдлын төлөвлөгөөнд БЦБ-ын хөтөлбөрүүдийг оруулах:** Онцгой байдлын үед хүүхэд, залуучуудын бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндэд үзүүлэх үйлчилгээ, түүний дотор БЦБ-ыг орхигдуулахгүй байх нь чухал юм. Хэрэгцээ нь гамшгийн үеийн бэлэн байдал, эрсдлийг бууруулах; наад захын хариу арга хэмжээ; цогц хариу арга хэмжээ; сэргээн босгох зэрэг хүмүүнлэгийн хариу арга хэмжээний үе шатуудаас хамааран харилцан адилгүй байдаг (Эмэгтэйчүүдийн дүрвэгсдийн комисс ба бусад, 2012).
- **Хүмүүнлэгийн орчин дахь хүүхэд, залуучууд ихэвчлэн маш их хөдөлгөөнд байдгийг анхаарах:** Зарим хүүхэд, залуучууд нэг газарт удаан хугацаагаар байх боломжгүй тул хичээлүүдийн хооронд хэт их хугацаа авч завсарлахгүйгээр аль болох тодорхой хугацаанд төвлөрч зохион байгуулах нь тэдэнд хүрэх илүү үр дүнтэй арга байж болох юм. Мөн хичээл тус бүр нь салангид бие даасан мэдээллийг агуулсан байх ёстой (өөрөөр хэлбэл нэг сэдвийг дараагийн хичээл дээр үргэлжлүүлэхийн оронд тухайн сэдвийг бүрэн хамрах). Хичээлүүдийг янз бүрийн хугацаатайгаар

өөр өөрөөр зааж болохоор төлөвлөх, нэг удаагийн, хүрдэвчилсэн хичээлээс эхлээд дэлгэрэнгүй мэдээлэл бүхий иж бүрэн хичээлүүд, хөтөлбөрүүд хүртэл өөр өөр хувилбараар боловсруулах.

- **Хүмүүнлэгийн орчинд байгаа лесби, гей, бисексуал, трансжендэр хүүхэд, залуучуудын эмзэг байдалд онцгой анхаарал хандуулах:** Эдгээр залуучууд хүмүүнлэгийн орчинд аюулгүй, хүртээмжтэй, тэдний хэрэгцээнд тохирсон хөтөлбөрт хамрагдах боломжгүй тул эмзэг байж болно. (Эмэгтэйчүүдийн дүрвэгсдийн комисс /WRC/, 2016).
- **Боломжтой бол БЦБ-ыг бусад үйлчилгээнүүдтэй, түүний дотор бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндтэй үялдуулах буюу холбох:** Цогц, олон салбарыг хамарсан, нэгдсэн арга барил нь БЦБ-той холбоогүй амьдрах үр чадварууд, бичиг үсгийн ба математикийн сургалт, мэргэжлийн үр чадварын сургалт, амьдрах ухааны үр чадвар зэргийг багтаасан байж болно (Эмэгтэйчүүдийн дүрвэгсдийн комисс ба бусад., 2012). БЦБ-ыг жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд нэгтгэн бусад одоо хэрэгжиж буй эсхүл төлөвлөсөн үйл ажиллагаатай үялдуулах нь ашигтай байж болох юм.
- **Боломжтой бол орон нутгийн эсвэл хүлээн авагч орон нутгийн иргэдтэй хөтөлбөрүүдийг нэгтгэх:** Дүрвэгсэд эсвэл дотооддоо нүүлгэн шилжүүлэгдсэн хүмүүсийг орон нутгийн хүн амтай нэгтгэх боломжтой газруудад хөтөлбөрүүдийг нэгтгэж, энэ хоёр бүлгийг аль алиныг нь хамарч болно.
- **Уламжлалт соёлд бэлгийн амьдралын асуудлыг авч үзэх боломжгүй гэж битгий бод:** Энэ нь тухайн соёлын гаднаас оролцож буй хөтөлбөр боловсруулагчдад нэн чухал юм. Тухайн нөхцөл байдалд үгийн байгаа зүйлс эсвэл ижил төстэй газруудад аль хэдийн хэрэгжиж байгаа зүйлсийг судлаарай. Дүрвэгсдийн орчин нөхцөлд байгаа хүмүүс нь илүү олон янзын хүмүүстэй харьцдаг бөгөөд ингэснээр тэд шинэ туршлага, санаа, мессеж, хөтөлбөрүүдийг хүлээж авч байж болзошгүй юм

Заах ба суралцах арга барил

- **Оролцогчдын бичиг үсгийн түвшинг харгалзан үзэж, хүн бүр тэгш оролцох боломжийг баталгаажуулах:** Онцгой байдлын үед, ялангуяа удаан үргэлжилсэн хямралд өртсөн хүүхэд, залуучууд сургууль ихээр завсардсан, боловсролын салбараас урт хугацаанд холдсон байх магадлалтай. Тиймээс тэд бичиг үсэг мэдэхгүй эсвэл бичиг үсгийн үр чадвар багатай байж болох юм. Суралцагчийн бичиг үсгийн түвшинд тохирсон аргуудыг ашиглах хэрэгтэй.
- **Охидод нийгэмших боломж, холбоо сүлжээ тогтоож, охид өөрсдөө зохион байгуулалтанд орох боломжоор хангах:** Охидод найзлах нөхөрлөх боломжийг бий болгох, орон нутаг дахь үе тэнгийнхэн болон насанд хүрэгчдийн харилцан дэмжлэгийг олж авах цаг хугацаа, орон зайг гаргаж өгөх замаар охидыг хамгаалах, чадавхийг нь бэхжүүлж болно (Эмэгтэйчүүдийн дүрвэгсдийн комисс ба бусад, 2013 ; ОУААХ, 2017).

Хөтөлбөрийн хэрэгжилт

- **Хүмүүнлэгийн нөхцөл байдлаас хамааран БЦБ-ын хүргэх олон сүвгийг авч үзэх:** Үүнд засгийн газрын шүүд үйлчилгээ, төрийн бус байгууллага эсвэл НҮБ-аар дамжуулан хүргэх; залуучуудын төвүүд, эмэгтэйчүүд, охидын уулзах боломжтой аюулгүй газрууд, залуучуудын клиник эсвэл бусад эрүүл мэндийн үйлчилгээ гэх мэт

тогтмол байршлуудад хүргэх; сургагч багш нар хүн амд очиж зааж сургах боломжтой явуулын сургалт, ангиуд; эсвэл технологийг ашиглан алсын зайнаас хүргэх зэрэг орно. Мөн БЦБ-ын хөтөлбөрийг нэгтгэх хүргэх боломжтой охид, хөвгүүд эсвэл залуучуудын бүлгүүд байж болно.

- **Аюултай орчин нөхцөлд, хүрч очиход хэцүү газруудад байгаа хүүхэд, залуучууд, ялангуяа охидыг хамруулахын тулд бүтээлч, уян хатан стратегиудыг ашиглах:** Хөтөлбөрт хамрагдах уян хатан нөхцөлийг санал болгох замаар хөтөлбөрийн оролцоог нэмэгдүүлэх, эсвэл оролцогчид хамгийн олноороо оролцох боломжтой үед сургалтыг зохион байгуулах хэрэгтэй. Хөтөлбөрүүд нь тээврийн зардлыг төсөвлөх ёстой (Эмэгтэйчүүдийн дүрвэгсдийн комисс, 2012).

Гол баримт бичиг ба сургалтын хөтөлбөр

- "Охидууд гэрэлтэж байна" хөтөлбөрийн загвар, ашиглах материалын багц (ОУААХ, 2018)
- Миний аюулгүй байдал, миний сайн сайхан байдал: Өсвөр насны охидод жендэрт суурилсан хүчирхийллийг бууруулах, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахад туслах тулхуур мэдлэг, үр чадвар эзэмшүүлэх нь (ОУААХ, 2016)
- Нүүдэллэж буй хөвгүүд: Хараа хяналтгүй өсвөр насны хөвгүүдийн амьдрах үрч чадварыг дээшлүүлэх нь: Сургагч багшийн гарын авлага, оролцогчийн ном, товхимол (НҮБ-ын Хүн амын сан, 2019)
- Хүмүүнлэгийн орчин дахь өсвөр насны бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн гарын авлага: Хүмүүнлэгийн орчин дахь нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх агентлаг дундын анхан шатны гарын авлагын хавсралт (НҮБ-ын Хүн амын сан, 2009)
- Эрүүл харилцаа, эрүүл олон нийт-Сургалтын хөтөлбөр: Бэлгийн хамтрагчийн хүчирхийллийг бууруулахад сэтгэцийн эрүүл мэнд, нийгмийн хэм хэмжээ, нөлөөллийн арга зүйг тусгах нь (АВААД Жендэрийн тэгш байдлыг хангах мэдээллийн төв, 2018)
- Таны аюулгүй байдал, миний аюулгүй байдал (Хүүхдийг ивээх сан, 2006)
- Таны эрх тэгш байдал, миний эрх тэгш байдал (Хүүхдийг ивээх сан, 2010)
- Хүмүүнлэгийн орчин дахь өсвөр үеийнхний бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн eLearning (онлайн курс) (Хямралын үеийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн байгууллагууд хоорондын ажлын хэсэг, 2016)

3.4 Уугуул залуучууд

Уугуул хүмүүс бол тухайн газарзүйн бүс нутагтаа янз бүрийн соёл, угсаатнаас өмнө суурьшиж, орчин үеийн улс, хил хязгаар бий болохоос өмнө оршин сууж байсан хүмүүсийн үр удам юм.⁸ Дэлхийн хэмжээний тооцооллоор дэлхийн 90 гаруй улс оронд 370 сая гаруй уугуул иргэд тархжээ (Дэлхийн банк, 2019). Уугуул оршин суугчид колоничлолын өмнөх нийгмийг санагдуулам нийгэм, соёл, эдийн засаг, улс төрийн ялгаатай байгууламжуудыг хадгалан үлдсэн байдаг бөгөөд тухайн газарзүйн бүс нутаг дахь давамгайлсан буюу үндсэн соёлоос ялгарах өвөрмөц онцлог бүхий зан үйл, итгэл үнэмшил, нэл аялгуутай байдаг (ДЭМБ, 2007б). Ерөнхийдөө тэд олон нийтээрээ өөрсдийгөө тодорхойлох хүчтэй мэдрэмжтэй, амьдардаг газар нутагтайгаа нягт үялдаа холбоотой байдаг (НҮБХХ, 2019).

Уугуул хүүхэд, залуучуудын өөрийгөө тодорхойлох үзэл баримтлал нь зөвхөн өөрсдийн бие махбод, бэлгийн болон нөхөн үржихүйн эрхтэй хамааралтай төдийгүй тэдний соёл, олон нийт, түүх, газар нутагтайгаа хүчтэй холбоотой байдаг. Уугуул хүүхэд, залуучуудын бэлгийн амьдралыг тэдний соёлын дадал зуршил, итгэл үнэмшил, зурхай судлалын хүрээнд ойлгох ёстой. Жишээлбэл, насанд хүрсэнийг тэмдэглэх уламжлалт зан заншил, ёслолууд нь уугуул залуучуудад өөрсдийн соёл ёс заншилд нийцсэн аргаар бэлгийн амьдралаа илүү сайн ойлгож, өөрсдийн үүргээ биелүүлэх боломжийг олгодог зан үйл юм.

Цаг хугацааны явцад колоничлогдоос гаралтай хүн ам давамгайлах болсон тул олон газар нутагт уугуул иргэд цөөнхийн статустай болжээ. Колоничлол эсвэл давамгайлсан шашин, соёлд хүчээр уусгаж, албадан нүүлгэн шилжүүлэх (жишээлбэл, орчны доройтлын улмаас) болон албан ёсны боловсролын системд хүчээр нэгтгэх зэрэг нь тэдэнд үе дамжсан олон нийтийн сэтгэл санааны гэмтлийг бий болгосон байдаг (Рединг ба Вейн, 2013). Өнөөдөр уугуул иргэд дэлхийн хамгийн эрх чөлөөгүй хүн амын бүлгүүдийг төлөөлж байна (ДЭМБ, 2007б). Тэд хүний хөгжлийн индекс бараг бүх үзүүлэлтээр, түүний дотор эрүүл мэнд, боловсрол, орлого зэрэгт тэгш бус байдалтай нүүр тулж байгаа бөгөөд уугуул хүүхэд, залуучууд өндөр чанартай эрүүл мэндийн үйлчилгээ, боловсрол, шударга ёсны үйлчилгээнд хамрагдах боломжгүй, улс төрийн оролцоо хангалтгүй байна (ДЭМБ, 2007б; Уугуул иргэдийн асуудлаарх агентлаг дундын дэмжих бүлэг, 2014).

Олон уугуул хүүхэд, залуучуудад хоёр өөр соёлын үүлзвэр дээр өсч хөгжих бэрхшээл тулгардаг бөгөөд энэ нь тэдний сэтгэлзүйн ба бэлгийн амьдралын эрүүл байдал, хөгжилд зарим талаараар нөлөөлж болзошгүй юм. Ихэнх эмзэг бүлгүүдэд тулгардаг бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн нийтлэг саад бэрхшээлүүд, үүнд бэлгийн боловсролгүй байдал, асрамж халамжийн хүртээмжгүй байдал, эрүүл мэндийн үндсэн нөхцөл байдал, хүйсийн тэгш бус байдал зэргээс гадна олон уугуул хүүхэд, залуучууд онцлог зарим бэрхшээлтэй тулгардаг, үүнд уламжлалт урьдчилан сэргийлэх асаргаа дэмжлэг, уламжлалт анагаах ухаан, эм тан зэргийг харгалзан үзсэн, соёлын хувьд мэдрэмжтэй тусламж, үйлчилгээ дутмаг байх зэрэг бэрхшээлтэй тулгардаг (Уугуул иргэдийн асуудлаарх агентлаг хоорондын дэмжих бүлэг, 2014). Ялгаварлан гадуурхал, тогтолцоонд үл итгэх байдал зэргээс үүдэлтэй үйлчилгээнүүд нь тэдэнд зохисгүй, хэрэгцээг нь хангаж чадахгүй байгаагаас олон уугуул хүүхэд,

залуучууд тусламж үйлчилгээ эрэлхийлэх, ялангуяа бэлгийн эрүүл мэндийн чиглэлээр тусламж үйлчилгээ авахаа хойшлуулах, эсвэл огт тусламж үйлчилгээ авахгүй байхад хүргэдэг (Квинсланд муж, 2013). Зарим бүс нутагт уугуул хүүхэд, залуучуудад ХДХВ-ийн халдвар тархах зан үйлийн эрсдэлт хүчин зүйлс, үүнд хорт зуршлийн хэрэглээ, өсвөр насны жирэмслэлт, бэлгийн эрсдэлтэй зан үйл, бэлгийн эрүүл мэндийн зохисгүй байдал зэрэгт өртөх нь харьцангуй өндөр байна (ПАЭМБ, 2011).

Уугуул хүүхэд, залуучуудын БЦБ-ын хэрэгцээний талаар хэвлэгдсэн ном зохиол олон байхгүй тул энэ хэсгийн ихэнх зөвлөмжийг олон нийтийн төлөөлөгчидтэй хийсэн ярилцлагад үндэслэн гаргасан болно.

Хөтөлбөрийн төлөвлөлт ба боловсруулалт

- **Уугуул иргэдийн амьдралын нөхцөл байдал, соёлд тохирсон арга хэмжээнүүдийг авах:** Хөтөлбөрүүд нь уугуул хүн амын эрүүл мэнд, өвчин эмгэгийн талаарх одоогийн болон уламжлалт ойлголтууд, тэдний уламжлалт анагаах ухааны мэдлэг, дадал зуршилд хариу өгөхүйц, түүнтэй уялдаатай байх ёстой (Нэгдсэн Үндэстний Байгууллага, 2014). Хөтөлбөр боловсруулагчид уугуул иргэдтэй хамтран ажиллахдаа уугуул хүн амыг бүхэлд нь сэтгэцийн гэмтэл цочролд оруулсан колоничлол (түүхэн эсвэл одоогийн), дарангуйлал, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл, соёл иргэншлийг устгасаны үр дагавар, нөлөөг харгалзан үзэх ёстой. Мөн түүнчлэн тэдний нийгэм, эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлыг, үүнд үйлчилгээ авах боломжгүй алслагдсан бүс нутагт амьдарч буй хоорондоо нягт холбоотой жижиг бүлгүүдийн дунд гэмт хэрэг, амиа хорлолт, олон нийтийн болон гэр бүлийн орчин дах хүчирхийлэл өндөртэй байдлыг харгалзан үзэх ёстой (ПАЭМБ, 2011).
- **Олон соёлт хандлагыг ашигла:** Хөтөлбөрүүд нь уугуул иргэдийн соёлыг хүндэтгэж, түүнд суурилсан, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн бүхий л бүрэлдэхүүн хэсгүүдийг шийдвэрлэхэд оролцогчдын биологийн, оюун санааны болон сэтгэл хөдлөлийг уялдуулан авч үзсэн үзэл баримтлалыг боловсруулсан байх ёстой (Рединг ба Вейн, 2013; Нэгдсэн Үндэстний Байгууллага, 2014).
- **Хөтөлбөрүүдийг цогц байдлаар, олон нийтийг бүхэлд нь зориулсан байдлаар боловсруулах:** БЦБ-ыг уугуул хүүхэд, залуучуудын эцэг эх, өвөө эмээ нарт чиглүүлж, эдгээр асуудлаар үе хооронд харилцан ярилцах чадавхийг бэхжүүлэх ёстой (НҮБ, 2014).
- **Уугуул иргэдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, ба хүний эрх нь НҮБ-ын уугуул иргэдийн эрхийн тухай тунхаглал дахь бусад эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангахтай харилцан уялдаатай гэдгийг хүлээн зөвшөөрөх:** Үүнд уугуул иргэдийн хувьд эрүүл мэндийн хамгийн чухал үзүүлэлт гэж тодорхойлогдсон тэдний өөрсдийгөө тодорхойлох эрх бөгөөд мөн тэднээс чөлөөтэй, урьдчилан, мэдээлэлд үндэслэн зөвшөөрөл авах эрх орно (НҮБ, 2007). Ийм учраас хөтөлбөрийг төлөвлөх, боловсруулахад уугуул хүүхэд, залуучуудын идэвхтэй оролцоо онцгой чухал юм.
- **Цаг хугацаа, төсвийн зохих нөөцийг хуваарилах:** Хоорондоо ижил төсгүй, ихэвчлэн алслагдсан нутагт амьдардаг уугуул иргэдтэй харилцаа холбоо тогтоож, хамтран ажиллахад хүний нөөцийн болон санхүүгийн ихээхэн нөөц шаардлагатай.
- **Оролцогчдын бүхий л хэрэгцээг тодорхойлж, тэдний хэрэгцээ, сонирхол, хүсэл эрмэлзлийг хангахын тулд**

⁸ Хүний эрхийн зарчмуудын дагуу “Уугуул иргэд” гэдэгт өөрийгөө уугуул гэж тодорхойлдог хувь хүмүүс, мөн уугуул иргэдийн олон нийтийн зүгээс гишүүнээр хүлээн зөвшөөрөгдсөн хүмүүс багтдаг байх ёстой.

хөтөлбөрийг өргөн хүрээтэй боловсруулах: Хөтөлбөр нь тэдний нийгэм, эрүүл мэнд, эдийн засгийн боломж нөөцийг нэмэгдүүлэхийн тулд БЦБ-оос илүүг буюу төлөвлөлт, зорилго тодорхойлох, боловсрол, сургалт, хөдөлмөр эрхлэх боломж зэргийг хамарч болно. БЦБ нь сургуульдаа эргэж орох, диплом авах, мэргэжлийн боловсрол эзэмших гэх мэт уугуул хүүхэд, залуучуудын хүртэх боломжтой бусад хөтөлбөр, арга хэмжээтэй уялдаж байх ёстой.

- **Хэлний хэрэгцээ шаардлагыг төлөвлөх:** Зарим улс оронд хүн амын бүлгүүд өөр өөр хэлээр ярьдаг. Нэмж дурдахад уугуул хэлэнд бэлгийн амьдралын талаарх бүх ойлголтуудыг нэрлэсэн нэр томъёо байхгүй эсвэл өөр өөр нэр томъёо ашигладаг байж магадгүй тул олон нийтийн дунд байгаа хөтөлбөрт ашигласан бүх нэр томъёог ойлгодог хүмүүстэй хамтран хийх урьдчилсан бэлтгэл ажил шаардагдаж болно.
- **Харилцан ойлголцлыг бий болгох:** Бүх уугуул иргэд хөдөө орон нутагт амьдардаггүй ч гэсэн алслагдсан эсвэл тусгаарлагдсан уугуул иргэдийн хамт олонд гаднаас очиж буй хөтөлбөр боловсруулагчид нь тухайн олон нийттэй харилцан ойлголцлыг бий болгоход цаг зав гаргаж, олон соёлд нийцэх арга барилыг ашиглан тэдний уламжлалт зан үйлд нээлттэй хандах хэрэгтэй. Сэдэв бүрийн хувьд тэд тухайн хамт олны гишүүдтэй хамтран хамт олны итгэл үнэмшил, мэдлэг, дадал туршлага юу болохыг олж мэдэж, ойлгох ёстой.

Заах ба суралцах арга барил

- **Заах ба суралцахдаа соёлын мэдрэмжтэй арга барилыг хүндэтгэж ашиглах, БЦБ-ыг соёлын хувьд аюулгүй байдлаар хүргэх:** Соёлын аюулгүй байдал нь соёлын мэдрэмжийн үзэл баримтлалаас илүү өргөн хүрээтэй юм. Үүнд эрх мэдлийн тэнцвэргүй байдал, институцийн ялгаварлан гадуурхалт, колоничлол, колоничлогчидтой хэрхэн харилцдаг ба эрүүл мэндийн боловсрол, үйлчилгээнд ноёрхсон соёл иргэншилд дүн шинжилгээ зэрэг хийх орно. Соёлын аюулгүй байдал нь уугуул хүүхэд, залуучуудын бие бялдар, итгэл үнэмшил, оюун санаа, сэтгэл хөдлөлийн уулзварыг танихад чухал үүрэг гүйцэтгэдэг. Соёлын хувьд аюулгүй бэлгийн боловсролын жишээнд бэлгийн амьдрал ба бусадтай харилцах харилцаатай холбоотой үе тэнгийн боловсрол, халамжлан зөвлөгч зэргийг багтаасан зан үйлийн хослол, хүчирхэгжүүлэхэд чиглэсэн, мэдлэгт суурилсан, гутаан доромжлол, сайн муу гэсэн үнэлэмжээс ангид соёлын сургаалуудыг багтаасан байдаг (НҮБ, 2014).
- **Сэтгэцийн гэмтэлд суурилсан арга барилыг ашиглах:** Ихэнх уугуул ард иргэд соёлын доромжлол, үе дамжсан хамтын сэтгэцийн гэмтэл шарх, хүчирхийлэлд өртөж байдаг ба энэ нь хамтын, институцлагдсэн, хүмүүсийн хоорондын эсвэл өөрийгөө буруутгасан хэлбэрээр илэрдэг. Энэ нь уугуул хүүхэд, залуучуудын хувьд ноцтой асуудал байдаг (УНДЕСА, 2015; УНДЕСА, 2017b; ПАЭМБ, 2018). Сэтгэцийн гэмтлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хуудас 14-өөс үзнэ үү.
- **Уугуул иргэдийн урлаг, уран сайхны үйл ажиллагааг нэгтгэх:** Олон тохиолдолд уугуул соёл, урлаг нь олон нийтийн өөрийн үнэлэмж, шинж чанарыг илэрхийлэх, мэдээлэл түгээх суваг болж байдаг тул БЦБ-д уран сайхны үйл ажиллагааг оруулах нь зүйтэй.
- **Уугуул иргэдийн газар нутагтайгаа гүнзгий холбоо, харилцаатайг хүлээн зөвшөөрөх:** Боломжтой бол БЦБ-ыг гадаа агаарт явуулж болно. Арга хандлага нь хүмүүс ба газар нутгийн хоорондын харилцааг ажиглаж, хөгжүүлэх замаар суралцах боломжтой гэдгийг хүлээн зөвшөөрч, уугуул иргэдийн үзэл бодол, үнэт зүйл, практикийг дэмжих ёстой. БЦБ-д үүнийг өөрсдийгөө эмчлэх, арчлах аргууд, уугуул ард түмний эм танг багтааж болно.

- **Хортой зуршлууд эсвэл өөртөө хор хөнөөл учруулах зан үйлийн талаарх сэдвийг заахдаа хор хөнөөлийг бууруулах хандлагыг баримтлах:** Уугуул хүүхэд, залуучуудтай тэдний юу мэдэж байгаагаас эхлэн ажиллаж, аюулгүй байдлыг хангах үүднээс олон янзын стратегид суралцахад нь туслах нь чухал юм. Хор хөнөөлийг бууруулах арга хэмжээ нь хувь хүн, олон нийтийн тодорхой хэрэгцээг тусгасан байдлаар боловсруулсан байх ёстой.
- **Оролцогчдын бичиг үсэг тайлагдалтын түвшинг харгалзан үзэх:** Бичиг үсгийн чадвар сул байгаа тохиолдолд хэвлэмэл материалыг хамгийн бага хэмжээнд ашиглах. Зарим хэл дээр бичгийн хэл байхгүй гэдгийг анхаарах хэрэгтэй.

Хөтөлбөрийн хэрэгжилт

- **Соёлын чадамжтай сургагч багш нарыг сонгох:** Уугуул хүүхэд, залуучууд, тэдний хамт олон нь уугуул иргэдийн болон үе тэнгийнхэний удирдсан арга барилыг эрс илүүд үздэг, учир нь эдгээр хүмүүс нь өөрсдийгөө тодорхойлохын ач холбогдлыг хүлээн зөвшөөрөх соёлын мэдрэмжтэй байдаг (НҮБ-ын Хүн Амын Сан, 2015a). Бусад арга барил нь бэлгийн амьдралын талаарх гадаад зоренцийн үзэл, хандлагыг илүүд үзэж, тулгаж, уугуул бүс хүнд давуу тал бий болгож, эрх мэдлийн тэнцвэргүй байдлыг бий болгож болзошгүй. Уугуул нутгийн залуучууд соёлын талаар мэдээллийг тэдний дунд онцгой чухал үүрэг гүйцэтгэдэг ахмадуудаас эрэлхийлж болох юм. Хөтөлбөрүүд нь олон нийтийн гишүүдэд сургалтыг зохион байгуулж, өөрсдөө бие биедээ боловсрол эзэмшүүлэх чадварыг олгох эсвэл залуучуудад сургалт явуулах талаар сургалт явуулж, тэдний тусламжийг хүсэх хэрэгтэй.

Удирдамж болон бусад гол баримт бичигүүд

- Уугуул иргэдийн эрүүлжүүлэх зан заншил, ёслолын байнгын дадал хэвшил (Spruce Woods Sundance Family, 2017)
- Тэгш байдлыг сурталчлах, олон янз байдлыг хүлээн зөвшөөрөх: Латин Америкийн уугуул иргэдийн соёл хоорондын бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн кейс ба түүхүүд (НҮБ-ын Хүн Амын Сан, 2010)
- “Хоёр хүйстэй” залуучуудад зориулсан аюулгүй, халамжтай сургууль: Багш, оюутнуудад зориулсан гарын авлага (Аюулгүй, халамжтай сургуулиуд ба олон нийтийн нийгэмлэг, 2011)
- Нутгийн уугуул Охидын бэлгийн эрүүл мэндийн боловсролд хандах олон нийтийн практик арга барил (Канадын Хүүхэд, өсвөр үеийнхний сэтгэцийн академийн сэтгүүл, 2006)
- Америкийн уугуул иргэдийн бүлгүүдэд зориулсан ХДХВ / БЗДХ-аас урьдчилан сэргийлэх удирдамж: Америкийн индианчууд, Аляскийн уугуул иргэд, Хавайн уугуул иргэд (Америкийн уугуул ДОХ-оос урьдчилан сэргийлэх төв, 2004)
- Хор хөнөөлийг бууруулах уугуул иргэдийн аргууд (Уугуул залуучуудын бэлгийн эрүүл мэндийн сүлжээ, nodd)
- Уугуул иргэдийн эрхийн тухай НҮБ-ын тунхаглал (НҮБ, 2007)

3.5 Лесби, гей, бисексуал залуучууд ба эрчүүдтэй бэлгийн харилцаанд ордог бусад залуу эрэгтэйчүүд

Удирдамжийн энэ хэсэгт лесби, гей, бисексуал хүүхэд, залуучуудыг трансжендэр хүүхэд, залуучууд, болон интерсекс хүүхэд, залуучуудаас тусад нь авч үзсэн болно. Энэ нь бэлгийн чиг баримжаа, хүйсийн шинж чанар, бие махбодын бэлгийн онцлог зэрэг нь тухайн хүний өөрийн тодорхойлолын ялгаатай хэсгүүд бөгөөд эдгээр бүлэг тус бүр өөрийн гэсэн онцлог хэрэгцээтэй болохыг хүлээн зөвшөөрч байгаа юм.

Энэхүү шалтгаанаар энэ удирдамжид илүү нийтлэг “LGBTQ+” товчлолыг биш харин ЛГБК+” гэсэн товчлолыг ашигласан болно. ЛГБК+ нь зөвхөн (гетеросексуал бус) бэлгийн чиг баримжааг хэлнэ. Хэдийгээр “К” нь (“queer” гэсэн үг) товчлолын нэг хэсэг боловч энэхүү удирдамж нь товчлолоос цааш илүү тайлбарлахаас зайлсхийсэн ба учир нь энэ нь бүх үлс оронд түгээмэл хэрэглэгддэггүй.

Зарим үлс оронд, интерсекс хүмүүс өөрсдийгөө аюулд оруулж болзошгүй тул ЛГБК+ гэж нэрлэгддэг нийгэмлэгийн нэг хэсэг гэж үзэхийг хүсэхгүй байж болно. Интерсекс шинж чанартай хүүхэд, залуучууд бэлгийн чиг баримжаа, хүйсийн шинж чанарын хувьд олон төрөлд хуваагдаж болох бөгөөд доорх хэсгүүдийн холбогдох зөвлөмжүүд түүнд мөн хамаарна. Гэсэн хэдий ч эдгээр бүлгүүд ихэвчлэн ЛГБК+ нэр томъёон дор нэгдэж, бүгд ижил төстэй нийгмийн дарлал, гутаан доромжлол, ялгаварлан гадуурхалттай тулгардаг тул эрхээ хамгаалахын тулд хүчээ нэгтгэдэг. Бэлгийн боловсролтой холбоотой тодорхой хэрэгцээтэй шаардлагатай тулгарч байгаа гэсэн ч эдгээр бүлгүүд бие биенээ илүү сайн таньж мэдэх, ойлголцохын тулд нэгдэх нь ашигтай байж болох юм.

Бэлгийн чиг баримжаа нь тухайн хүний романтик болон, эсвэл бэлгийн харилцаанд татагддаг хүмүүсийн хүйсийг хэлнэ.

- **Гетеросексуал (стрейт)** хүмүүс ерөнхийдөө эсвэл зөвхөн өөрийн хүйсийн эсрэг хүйсийн хүмүүст татагддаг.
- **Ижил хүйстэн хүмүүс (ижил хүйстэн, лесби хүмүүс)** үндсэндээ эсвэл зөвхөн өөрийн хүйстэй ижил хүйстэй хүмүүст татагддаг.
- **Бисексуал** хүмүүс өөрийн хүйстэй ижил болон өөр хүйсийн аль алиных нь хүмүүст татагддаг
- **Пансексуал** хүмүүс хүйсийн бүх шинж чанарууд (эрэгтэй, эмэгтэй, трансжендэр гэх мэт) -д татагддаг.
- **Асексуал** хүмүүс бэлгийн дүр хүслийг мэдэрдэггүй, эсвэл бэлгийн харилцаанд орох сонирхол бага эсвэл огт байдаггүй.

Бэлгийн чиг баримжааг тасралтгүй үргэлжлэх шүлүүн гэж үзэх хэрэгтэй. Хүний бэлийн чиг баримжаа нь тогтмол байх албагүй бөгөөд амьдралын туршид өөрчлөгдөж магадгүй юм. Зарим хүмүүс өөрсдийгөө ямар нэгэн тодорхой ангилалд оруулахыг хүсдэггүй. Бэлгийн чиг баримжаа (хүний сэтгэл татам мэдрэмж) нь хүйсийн баримжаанаас (хүн өөрийгөө хэрхэн тодорхойлдог), бэлгийн зан үйлээс (бодит байдал дээр юу хийдэг) ялгаатай байдаг. Жишээлбэл, “эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүд” гэдэг нь бусад эрчүүдтэй бэлгийн харилцаанд орсон бүх эрчүүдийг тодорхойлоход хэрэглэгддэг бөгөөд тэд бас эмэгтэйчүүдтэй бэлгийн харилцаанд орсон эсэх, эсвэл ижил хүйстэн, бисексуал, гетеросексуал гэдгээс үл хамаарна. Нийгмийн орчин, нөхцөл байдал (жишээлбэл, дотуур байр, цагдан хорих төв, засан хүмүүжүүлэх газар) нь бэлгийн хамтрагчаа сонгоход нөлөөлдөг. Эдгээр болон бусад шалтгааны улмаас (өөрийн бэлгийн чиг баримжаагаа илчлэхээс айх гэх мэт) дэлхий даяар ЛГБК+ хүүхэд, залуучуудын тоо тодорхойгүй байна. Тооцоолол нь ихээхэн ялгаатай бөгөөд маргаан нь өргөн байдаг.

Хэдийгээр зарим ЛГБК+ хүүхдүүд бэлгийн чиг баримжаагаа багаасаа мэддэг боловч ихэнх нь өсвөр насандаа романтик харилцаа, бэлгийн дүр сонирхол эхлэх үед үүнийг олж мэддэг. Ижил хүйстэндээ татагдахыг гутаан доромжилдог

эсвэл буруушаадаг соёлд энэ нь ихэвчлэн төөрөгдөл, ичгүүр, айдас, өөрийгөө буруушаах эсвэл өөрийгөө үзэн ядах зэргийн холимог хэлбэрээр илэрэхэд хүргэдэг ба энэ үед нь тэдэнд дэмжлэг, тусалцаа хүсэх хэн ч байхгүй байж болно.

ЛГБК + хүмүүс нэр төрөө хамгаалуулах, тэгш эрхтэй байх, ялгаварлан гадуурхахгүй байх, аюулгүй амьдрах, эрүүл байх, боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх эрхүүдээ эдэлж чаддаггүйгээс гадна эрүүдэн шүүх, харгис хэрцгий, хүнлэг бус хандах, хүний нэр төрийг нь гутаан доромжлох, дүр мэдэн цагдан хорихоос ангид байх эрхээ эдэлж чаддаггүй. ЛГБК+ хүмүүсийг ялгаварлан гадуурхсан хуулиуд нийтлэг байдаг бөгөөд үүнд ижил хүйстнүүдийн харилцааг хориглох, ижил хүйстнүүдийн гэрлэлтийг хориглох, ЛГБК+ байгууллага байгуулах эрхийг хориглох зэрэг заалтууд хуулинд түгээмэл байдаг. Тэднийг хүлээн зөвшөөрдөггүй нийгэм, соёл, уламжлал, шашинд амьдардаг хүмүүс гутаан доромжлол, ялгаварлан гадуурхалтанд өртөж, эрх нь ноцтой зөрчигдөж, хүнд хэлбэрийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэрэг, аллагад өртдөг.

Тэдэнд тулгардаг үзэн ядалтын улмаас ЛГБК+ хүмүүс, түүний дотор хүүхэд, залуучууд өөрсдийнхөө бэлгийн чиг баримжааг бусдаас нуух хэрэгтэй гэж бодож байж магадгүй юм. Зарим соёл иргэншилд ЛГБК+ залуучууд гэр бүл, олон нийтийн зүгээс ирж буй гутаан доромжлол, ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэлээс зайлсхийх, эсвэл хүүхэд төрүүлэх зорилгоор эсвэл гэр бүлийнхэн нь албадан гэрлүүлсний улмаас эсрэг хүйсийн хүмүүстэйгээ харилцаа тогтоож болно. Хэрэв тэдний бэлгийн чиг хандлага ба бэлгийн зан үйл нь мэдэгдвэл тэд гэр бүл, олон нийт, шашин шүтлэгээсээ татгалзахад хүрдэг. Тэднийг гэр бүлийнхэн нь гэрээсээ хөөсөн, багш, оюутнуудын дээрлэлт, дарамт шахалтаас болж сургууль завсардсан эсвэл сургуулиа орхисон, ажилгүй болсон байх нь бий.

Ижил хүйстний зан үйлийг гэмт хэрэгт тооцох, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчдийн зүгээс ялгаварлан гадуурхах зэрэг нь залуу ЛГБК+ хүмүүсийн эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдахад саад болж, эрүүл мэндийн байдал нь доройтоход хүргэдэг. Үүнд, эрэгтэйчүүдтэй бэлгийн хавьталд

ордог залуу эрэгтэйчүүдийн дунд ХДХВ-ийн халдвар нь хүн амын тооноос хамаагүй өндөр байдаг (НҮБ-ын Хүн амын сан ба бусад, 2015; Кейфер ба Аршад, 2016). Судалгаанаас харахад зарим улс оронд залуу ЛГБК+ эмэгтэйчүүд ижил насны гетеросексуал эмэгтэйчүүдийг бодвол жирэмслэх магадлал өндөр байна (Линдли ба Уолсеманн, 2015; Ходсон нар, 2017). ЛГБК+ хүүхэд, залуучуудад тулгарч буй нийгмээс тусгаарлалт, хүлээн зөвшөөрөхгүй байх, байнгын хүчирхийлэл дарамтын улмаас амиа хорлох оролдлого, амиа хорлох тохиолдол нийт залуучуудынхаас хамаагүй өндөр байгаа нь харагдаж байна (Хаас нар, 2011).

Хөтөлбөрийн төлөвлөлт ба боловсруулалт

- **ЛГБК+ хүүхэд, залуучуудыг БЦБ-д хамруулах, тэднийг татан оролцуулах хамгийн тохиромжтой арга замуудын талаарх хөтөлбөр болон орон нутгийн, үндэсний хэмжээний ЛГБК+ хүмүүсийн төлөөх бүлгүүдтэй зөвлөлдөх.** Улс орон бүрт хүчтэй идэвхтнүүд байдаг.⁹ Гей болон эрэгтэйчүүдтэй бэлгийн хавьталд ордог бусад залуучуудад чиглэсэн БЦБ болон тэдний ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх сүлжээтэй холбогдож болно.
- **Бүх ЛГБК+ шинж чанартай хүмүүст БЦБ-ыг хүргэх:** Зөвхөн ХДХВ-ийн халдвар авах эрсдэлтэй гэж тооцогдох хүмүүсээр хязгаарлагддаггүй ижил хүйстэн, бисексуал эрчүүд болон бусад эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрэгтэйчүүдэд хүргэх.
- **ЛГБК+ хүмүүсийн эрх зүйн байдлыг харгалзан үзэх:** Олон улс орнууд ижил хүйстний бэлгийн зан үйлийг гэмт хэрэгт тооцдог. Сургалтын хөтөлбөрийн агуулга, оролцогчдын нас, БЦБ-ыг хаана, хэрхэн хүргэх талаар шийдвэр гаргахдаа тухайн орон нутгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, оролцогчид болон хөтөлбөрийн ажилтнуудын аюулгүй байдлыг харгалзан хөтөлбөрийг төлөвлөх ёстой.
- **Хөтөлбөрт хамрагдах бүлгүүдийн соёл, үнэт зүйл, итгэл үнэмшлийн тогтолцоог ойлгох, түүнд зохицуулах:** ЛГБК+ залуучуудад тэдний бэлгийн амьдралын соёлтой зөрчилдөж болох нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээг тулгахасаа илүүтэйгээр тэдний бэлгийн соёлд нийцсэн шийдэл, стратегиудыг тодорхойлох эсвэл түүнд нь зохицуулах хэрэгтэй.
- **ЛГБК+ хүүхэд, залуучууд, эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог залуу эрэгтэйчүүд нэгэн бүхэл бүлэг бус дотроо ялгаатай хувь хүмүүс гэдгийг хөтөлбөрийг төлөвлөхдөө анхаарах:** ЛГБК+ залуучуудын өөр өөр бүлгүүд нь нийтлэг болон ялгаатай, хэрэгцээ шаардлага, сонирхолтой байж болох бөгөөд өөрсдийн хөтөлбөртэй болохыг ч хүсч магадгүй юм. Ялангуяа, жендерийн тэгш бус байдлын нөлөөллийн улмаас хөтөлбөр боловсруулагчид залуу лесби, бисексуал эмэгтэйчүүдтэй тэд өөрсдийн хэрэгцээг ижил хүйстэн эрэгтэйчүүдээс тусад нь авч үзэх хөтөлбөр хүсч байгаа эсэхийг хэлэлцэх ёстой. Хэрэв тусдаа хөтөлбөрүүд боловсруулсан бол жендерийн нэг хүйст харьяалагдахгүй хүмүүс эсвэл хүйсийн ангилалд үл нийцсэн хүмүүст мөн нээлттэй хандах ёстой бөгөөд тэдэнд аль бүлэгт хамгийн сайн тохирохыг шийдэх боломжийг олгох ёстой. Нэмж дурдахад эдгээр бүлэг тус бүр олон янзын шинж чанаруудад хуваагддаг бөгөөд энэ нь улс орон бүрд өөр өөр байж болно. Хөтөлбөр нь бүлэг доторх өөр өөр шинж чанарыг таньж, тэдний олон янзын ялгаатай хэрэгцээг авч үзэх ёстой.
- **Эрх мэдэлжүүлэлтийг бэхжүүлэх хамтарсан хичээлүүдийг авч үзэх:** ЛГБК+ хүүхэд, залуучууд гадуурхах, гутаан доромжлох, ялгаварлан гадуурхагдах тал дээр ижил төстэй

туршлагатай тулгардаг тул зарим хичээлүүдийг хамтарсан бүлгээр зохион байгуулах нь тэдэнд ижил хамт олон гэсэн мэдрэмжийг төрүүлж, хамтарсан сурталчилгааны ажлыг хийхэд нь дэмжлэг болдог.

- **ЛГБК+ хүүхэд, залууст хүндэтгэлтэй ханддаг мэргэжлийн холбон зуучлах үйлчилгээнүүдэд зуучлах:** Боломжтой бол БЦБ-ыг ЛГБК+ хүмүүст ээлтэй эрүүл мэнд, сэтгэцийн эрүүл мэндийн хөтөлбөрүүд эсвэл мэргэжилтэнүүдтэй холбон зуучилж өгөх нь маш чухал юм. Хэрэв тохиромжтой холбон зуучлах үйлчилгээ авах боломжгүй бол хөтөлбөр боловсруулагчид засгийн газруудад үйлчилгээ үзүүлэхэд нь нөлөөлөх, үйлчилгээ үзүүлэгчдийг мэдрэмжтэй болгох нөлөөллийн ажилд нэгдэх ёстой.
- **Онлайнаар хүрч үйлчлэх талаар бодож үзэх.** Хөтөлбөрт хамрагдах гэж байгаа хүмүүс интернэтэд нэвтрэх боломжтой бол онлайн сурталчилгаа нь үе тэнгийнхний сурталчилгааны хажуугаар нэмэлт болгон ашиглахад чухал байж магадгүй юм, учир нь үе тэнгийнхэн зөвхөн хязгаарлагдмал тооны хүмүүст, ихэвчлэн өөрсдийн сүлжээн дотроо л зарыг түгээдэг (НҮБ-ын Хүн амын сан ба бусад, 2015). Энэ нь ялангуяа эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог залуу эрэгтэйчүүдэд хамаатай байж болох юм, учир нь олон улс оронд тэд бэлгийн хамтрагчаа хайж олохын тулд онлайнаар холбогддог болсон (НҮБ-ын Хүн амын сан ба бусад, 2015).

Заах ба суралцах арга барил

- **Сэтгэцийн гэмтэлд суурилсан аргыг ашиглах:** Хэрэв ЛГБК+ байх нь тухайн хөтөлбөр хэрэгжиж байгаа газарт сэтгэцийн гэмтэл учруулж байгаа бол сэтгэцийн гэмтлийн талаар мэдээлэл өгөх БЦБ-ыг ашиглах хэрэгтэй (хуудас 14-ийг үзнэ үү).
- **Оролцогчдод ярих хангалттай боломжийг олгох:** Оролцогчдод ЛГБК+ байх туршлагынхаа талаар бусад ЛГБК+ хүмүүстэй ярих боломжийг олгодог хэлэлцүүлэгт суурилсан аргууд нь тэдний ихэнхийн даван түүлж буй нийгмээс тусгаарлагдсан байдлыг хөнгөлөхөд тусална.
- **Баримтанд тулгуурласан байх, тодорхой байх:** Хөтөлбөрүүд нь ЛГБК+ байх тухай ташаа ойлголтыг залруулж, худал мэдээллийг засаж өгөх ёстой.

Хөтөлбөрийн хэрэгжилт

- **Олон төрлийн шинж чанартай сургагч багш нарыг элсүүлэх:** Хэрэв үндсэн сургагч багш нь ЛГБК+ -д харьяалагддаггүй бол хамтрагч сургагч багшаар ЛГБК+ хүнийг сонгох ёстой. Оролцогчдын дунд төлөөлөл нь байгаа өөр өөр шинж чанартай олон тооны ЛГБК+ хүмүүсийг урьж авчран түүхийг нь яриулж болно.
- **Технологийг ашиглаж байгаа бол оролцогчдыг урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээг авах:** Мэдээллийн платформууд нь оролцогчдыг таних боломжгүй байх ёстой. Хөтөлбөр боловсруулагчид оролцогчидтой холбоо барих хамгийн найдвартай арга зам, хэр олон удаа сануулга илгээх, оролцогчид нууцлалын ямар сонголтыг ашиглаж болох талаар ярилцах ёстой. Оролцогчид тэднийг тодорхойлох мэдээллээс эсвэл сануулга мэдэгдэлээс татгалзах эсвэл зөвшөөрөх боломжтой эсэхийг шалгаарай. Тэд хувийн имэйл хаягаа ашиглан бүртгүүлэхийг хүсэхгүй байж ч болно.
- **ЛГБК+ -тай холбоотой хэвлэмэл материалыг ашиглахдаа болгоомжтой байх:** Оролцогчид материалыг сургалтын орчноос гадуур авч явах, хадгалах нь аюултай байж магадгүй.

⁹ Байгууллагуудын нэрсийг Wikipedia-аас харна уу. (https://en.wikipedia.org/wiki/List_of_LGBT_rights_organizations) эсвэл OutRightInternational байгууллагатай, дараах хаягаар (<https://www.outrightinternational.org/about-us>) эсвэл the International Lesbian, Gay, Bisexual, Trans and Intersex Association-тай холбогдоно уу. (ILGA) (<https://ilga.org/about-us/contacts>).

Гол баримт бичиг ба сургалтын хөтөлбөр

- Гадуур байх, аюулгүй байх: Лесби, ижил хүйстэн, бисексуал, күйир өсвөр насны хүүхдүүдийн бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтын хөтөлбөр (Нью Жерси мужийн Эрүүл мэндийн газар, ахлах үйлчилгээний алба, н.д.)
- ХДХВ, БЗДХ-ыг цогцоор нь хэрэгжүүлэх
- Эрэгтэйчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүдэд зориулсан хөтөлбөрүүд: Хамтын ажиллагааны хөндлөнгийн практик удирдамж (UNPFA, 2015)
- ХДХВ ба эрэгтэйчүүдтэй бэлгийн хавьталд ордог залуу эрэгтэйчүүд: Техникийн товч мэдээлэл (ДЭМБ, 2015)
- Итгэлийн удирдагчид ба ЛГБТ олон нийтийн багаж: Бурханы бүх хүүхдүүдийн аюулгүй, найрсаг итгэлийн байгууллагуудыг сурталчлах (Sonke Gender Justice Network, 2017)
- Лесби, Гей, Бисексуал, Трансжендэр (ЛГБТ)
- Дэлхийн өмнөд үеийн залуучууд: Баримтууд (Залуучуудын өмгөөлөгчид, 2016)
- Үүнтэй хамт: ХДХВ ба бэлгийн бусад эрүүл мэнд
- Эрэгтэйчүүдтэй бэлгийн хавьталд ордог залуу эрэгтэйчүүдэд анхаарах зүйл (Гей эрчүүдийн эрүүл мэнд, эрхийн төлөө MPact Global Action, 2018)
- Энэрэнгүй төвтэй Исламын сүлжээ (вэбсайт)

3.6 Трансжендэр залуучууд

Хүний хүйсийн тодорхойлолтын талаарх ойлголт нь дараах гурван элементүүдийн харилцан хамаарлаас хамааран цаг хугацааны явцад бий болдог.

- **тэдний бие махбод**, нь нийгмээс үргэлж оноож өгдөг хүйс буюу төрөхөд тодорхойлогдсон хүйс, улмаар бусад хүмүүс үүнийг хэрхэн хүлээж авч байгааг тодорхойлдог үндэс суурь юм.
- **тэдний хүйсийн баримжаа**, нь тэдний өөрийгөө ямар хүйсийн гэж мэдэрдэг гүнзгий дотоод мэдрэмж, тухайлбал тэд өөрсдийгөө эрэгтэй, эмэгтэй, хоёулангийнх нь холимог, эсвэл аль нь биш гэж үзэх мэдрэмж ба энэ нь тэдний төрөх үеийн хүйстэй тохирч эсвэл тохирохгүй байж болно.
- **тэдний хүйсийн илэрхийлэл**, нь тэдний бусдад өөрийнхөө хүйсийг илэрхийлж буй байдал, жишээ нь нийгмээс тэднийг эрэгтэйлэг, эмэгтэйлэг эсвэл аль нь ч биш гэж тодорхойлогдох гадаад төрх, хувцаслалт, үс засалт, хэв маяг, биеэ авч явах байдал, яриа, сонирхол, зан байдал зэрэг гадаад шинж чанаруудаар дамжуулан бусад хүмүүст өөрийн хүйсээ илэрхийлдэг.

Хүн өөрт оногдсон хүйсээ хэрхэн мэдэрч байгаа нь эдгээр гурван хүчин зүйлс хэр зэрэг давхцаж байгаатай холбоотой юм.

- **Трансжендэр** хүний хүйсийн баримжаа ба / эсвэл илэрхийлэл нь тэдний хууль ёсны эсвэл өгөгдсөн хүйснээс өөр байдаг; иймээс тэд өөрсдийн хууль ёсны болон хүйсийн шинж чанараас байнга асуудаг бөгөөд үүнийг өөрчлөхийг хүсэж болно.
- **Сизжендэр** хүний хүйсийн шинж чанар нь тэдний өгөгдсөн хүйстэй ижил байна, тиймээс тэд өөрийнхөө хүйсийн талаар асуух магадлал багатай.
- Хоёр туйлт эр эм хүйсийн хэм хэмжээнд нийцэхгүй **хүйсийн** илэрхийлэл бүхий хүмүүс шууд хатуу эрэгтэй, эмэгтэй гэж ялгадаггүй.
- **Ажендер** хүмүүс ямар ч хүйсээр тодорхойлогддоггүй.

- **Хүйсийн хувьд үл нийцэх хүмүүс** хүйсийн талаар нийгмийн уламжлалт ойлголтонд нийцдэггүй ба өгөгдсөн хүйсийнхээ илэрхийллээр илэрхийлэгддэггүй.

Энэхүү гарын авлагад “трансжендэр” -ийг (өөрөөр заагаагүй бол) бүх сизжендэр бүс бүх хүйсийн хүмүүсийг ерөнхийд нэрлэх шүхэр нэр томъёо болгон ашигласан. Өөрөөр хэлбэл хүйсийн шинж чанар ба / эсвэл хүйсийн илэрхийлэл нь төрөхдөө тэдэнд оноосон хүйстэй нийцдэггүй.

Дэлхий даяар трансжендэр хүмүүсийн тоо хэмжээ, мөн залуу трансжендэр хүмүүсийн тооны талаарх үнэн зөв мэдээлэл байхгүй байна.

Трансжендэр хүүхэд, залуучуудад өөрсдийнхөө хүйсийн тодорхойлолтыг таньж мэдэх баталгаажуулахад шаардлагатай мэдээлэл, мессеж, үлгэр дууриал олж авах боломж хязгаарлагдмал байдаг. Тэдний эцэг эх, багш нар, эрүүл мэндийн байгууллагууд болон өргөн олон нийт тэдний өөрийгөө илэрхийлж буй байдлын талаар, тэдний ялангуяа бэлгийн бойжилтын үеэр тохиолдож буй зүйлийнхээ талаар ихэнхдээ мэдээлэл, ойлголтгүй байдаг. Трансжендэр өсвөр насныханд жендэрийн нийцтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах нь эерэг үр дүнд хүргэж болох боловч (Дэ Вриес нар, 2014) бага, дунд орлоготой улс орнуудад амьдардаг залуучууд холбогдох мэргэжлийн үр чадвар эзэмшсэн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчдээс үйлчилгээ авах эсвэл био-анагаахын тусламж үйлчилгээ, үүнд: дааврыг зогсоох болон дааврын эмчилгээ гэх мэт эмчилгээнд хамрагдах боломжгүй байдаг. Олон улс оронд эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдахад албан ёсоор зөвшөөрөл авах нас нь 18 нас хүрсэн байхыг шаарддаг тул эцэг эхтэйгээ трансжендэр болох талаар нээлттэй ярилцдаггүй боловч дааврын эмчилгээ эсвэл мэс засал хийлгэхийг хүсэж буй залуу хүмүүст илүү их саад тотгор учирдаг.

Трансжендэр залуучууд өөрсдийнхөө аюулгүй байдалд санаа зовних, бусад хүмүүс хүлээн зөвшөөрөхгүй байгаа мэт мэдрэмжийн улмаас ихэвчлэн сургуулиа хаях, гэрээсээ оргох эсвэл гэр бүлдээ хаягдах шалтгаан болдог. Дараа нь тэд ажлын байран дахь ялгаварлан гадуурхалттай тулгарч болзошгүй бөгөөд энэ нь бүрэн бүс хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядууралд хүргэж болзошгүй юм. Ихэнх нь хүчирхийлэлд өртөж, эрүүл мэндэд нь хор хөнөөл учруулж болзошгүй нөхцөл байдал, зан үйлд өртөж болзошгүй байдаг. Тухайлбал бэлгэвч хэрэглэх боломжгүй нөхцөлд биеэ үнэлэх (Операрио нар, 2008); албан бусаар олж авсан дааврар ашиглах (жишээлбэл, гудамжинд худалдаж авсан), үүнд бохир зүү хувааж хэрэглэх; эсвэл архи, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэх зэрэг орно (НҮБХХ ба бусад, 2016).

Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлаас үл хамааран залуу трансжендэр хүмүүс нийгэм, эдийн засгийн тогтолцооны гадуурхалт, гутаан доромжлолт, ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл, жендэрийн нийцтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжгүй байдлаас болж эрүүл мэнд, сайн сайхан байдал нь ноцтой үр дагаварт хүргэж болзошгүй юм (НҮБ, 2011 ; Рейзнер нар, 2016). Үүний үр дүнд тэд сэтгэл гутрал, айдас, цочрол, амиа хорлох оролдлого, өөрийгөө санаатайгаар хохироох, ХДХВ ба бэлгийн замаар дамжих халдварт өртөх нь, мөн архи, мансууруулах бодисын хэрэглээ, хэтрүүлэн хэрэглэх нь нийт хүн амын дундажтай

харьцуулахад харьцангуй өндөр байна (Клементс-Нолле нар, 2001; Эрүүл мэндийн бодлогын төсөл, бусад, 2015; Рейснер нар, 2016; Виннер нар, 2016).

Трансгендер хүүхэд, залуучуудын БЦБ-ын хэрэгцээний талаар өргөн хэвлэгдсэн ном зохиол байхгүй тул энэ хэсгийн ихэнх зөвлөмжийг трансгендер байгууллагууд болон тэдний төлөөллийн гишүүдтэй хийсэн ярилцлагад үндэслэв.

Хөтөлбөрийн төлөвлөлт ба боловсруулалт

- **Трансгендерүүд, түүний дотор хүүхэд, залуучуудад зориулсан орон нутгийн, үндэсний бүлгүүдтэй зөвлөлдөх:** Ийм бүлгүүд байгаа тохиолдолд тэд хөтөлбөрийн талаар маш чухал мэдээлэл болон трансгендер залуучуудад хүрэх хамгийн тохиромжтой арга замыг зааж өгөх боломжтой болно.¹⁰
- **Хөтөлбөрт оролцогчид болон ажилчдын аюулгүй байдал, нууцлалыг хангах замаар хэвлэн нийтлэх хэрэгцээг тэнцвэржүүлэх:** Хичээлийн байршил, цагийг олон нийтэд зарлахаас илүүтэй холбоо барих мэдээллийг өгөх нь илүү аюулгүй байж болох бөгөөд ингэснээр боломжит оролцогчдыг илрүүлэх, анхан шатны мэдээллүүдийг цуглуулах боломжтой болгоно.
- **Хөтөлбөрт хамрагдсан залуу трансгендер хүмүүсийн хүйсийн онцлог шинж чанар, хэрэгцээг ойлгох:** Жишээлбэл, транс-эрэгтэй, транс-эмэгтэй хүмүүсийн хэрэгцээ, нөхцөл байдал нь ихэвчлэн өөр өөр байдаг тул зарим хөтөлбөр эсвэл хөтөлбөрийн хэсгүүдэд тусад нь авч үзэх шаардлагатай болдог.
- **Хөтөлбөрийн талаар тайлбарласан үг хэллэг нь ойлгомжтой байгаа эсэхийг шалгах:** Үг хэллэг нь бүх оролцогчдыг хамруулсан байх ёстой тул хөтөлбөрийг боловсруулагчид нь тухайн нийгмийн бүлэг эсвэл хүмүүсийн ашиглаж буй нэр томъёоны талаар олж мэдэж, ашиглах ёстой.
- **Залуу трансгендер хүмүүст хүндэтгэлтэй хандаж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд үйлчилгээнд холбон зүүчлэх:** Боломжтой бол БЦБ-ыг транс хүмүүст ээлтэй эрүүл мэнд, сэтгэцийн эрүүл мэндийн хөтөлбөрүүд эсвэл мэргэжлийн хүмүүс зэрэг шаардлагатай бүхий л үйлчилгээнүүдтэй холбох нь маш чухал. Хэрэв тохиромжтой зүүчлэх үйлчилгээ авах боломжгүй бол хөтөлбөр боловсруулагчид засгийн газруудад үйлчилгээ үзүүлэхэд нөлөөлөх, үйлчилгээ үзүүлэгчдийг илүү мэдрэмжтэй болгох нөлөөллийн ажилд нэгдэх ёстой.
- **Мэдээллийн нууцлалыг чанд хадгалах аюулгүй системийг бий болгох:** Оролцогчдын талаарх хувийн мэдээллийг трансгендер хүмүүст дайсагнаж болзошгүй хувь хүн, бүлэг, байгууллага олж авахаас хамгаална.
- **Хэрэв одоо байгаа сургалтын хөтөлбөрийг тохируулга хийн ашиглах бол энэ үйл явцад нухацтай, болгоомжтой хандах:** Энэ нь үг хэллэгийг илүү хүртээмжтэй болгох, эсвэл бүх нэршлийг хүйсийн хувьд саармаг болгон өөрчлөхөөс илүү их зүйл шаарддаг.
- **Боломжтой бол технологи, нийгмийн сүлжээний хэрэгслийг ашиглах:** Зарим трансгендер залуучууд трансгендер болох, шилжилт хийх гэх мэт мэдээлэл авахын тулд YouTube, технологи, вэбсайтыг ашигладаг. Тиймээс технологи, нийгмийн сүлжээ нь тэдэнд хүрэх үр дүнтэй арга байж болно.
- **Боломжтой бол хүйсийн тодорхойлолтын талаар эцэг эхчүүдэд мэдлэг олгох.** Хүүхдүүд өөрсдийгөө эерэгээр мэдрэх, өөрийгөө үнэлэх үнэлэмжийг хөгжүүлэх, эрүүл

мэндэд үзүүлэх янз бүрийн үр дагавраас урьдчилан сэргийлэхэд шаардлагатай тусламжийн талаар ярилц.

Заах ба суралцах арга барил

- **Сэтгэл зүйн эмгэгийн талаар мэдээллийн арга барилыг ашиглах:** Трансгендер залуучуудын олонх нь гутаан доромжлол, ялгаварлан гадуурхалт, эсвэл хүчирхийлэлд өртөх зэргээр олон удаа сэтгэл зүйн эмгэгт өртсөн байдаг. (Дэлгэрэнгүй мэдээллийг хуудас 14-ээс үзнэ үү.)
- **Бэлгийн болон нөхөн үржихүйн анатомийн талаар ярихдаа тайлбар диаграммыг багтаасан байх:** Диаграммыг эрэгтэй, эмэгтэй гэсэн шошготой, биеийн хэсгүүдийг нэг хүйсээр хуваарилж болохгүй. Анатомийн хичээл заахад оролцогчдоос хэсэг бүр дээр ямар үг ашигладаг болохыг асууж, олон янзын шошго өгөх боломжийг олгох.
- **Оролцогчдод хангалттай ярих боломжийг олгох:** Оролцогчид трансгендер болсон туршлагынхаа талаар ярилцах боломжийг олгодог хэлэлцүүлэгт суурилсан арга нь тэдний нийгмээс тусгаарлагдсан байдлаас ангижрахад тусална.
- **Сэтгэцийн эрүүл мэндийн талаар дэмжлэг үзүүлэх:** Боломжтой бол хөтөлбөрүүд нь сэтгэцийн эрүүл мэндийн талаар транс хүмүүст-ээлтэй зөвлөхүүдтэй байх ёстой. Хэрэв ийм боломжгүй бол сургагч багш нар эдгээр асуудлыг анхааралтай ажиглаж, сэтгэл санаа нь тавгүй мэт харагдаж байгаа бүх хүмүүст дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.
- **Ташаа ойлголтыг залруулж, худал мэдээллийг засах:** Хөтөлбөрийг хүргэж буй олон нийтийн дунд тархсан трансгендер хүмүүсийн талаарх буруу ташаа ойлголт, хуурамч мэдээллийг шууд няцаах ёстой.

Хөтөлбөрийн хэрэгжилт

- **Боломжтой бол трансгендер хүмүүсээс сургагч багш болгон ашиглах:** Ядаж нэг сургагч багш тухайн бүлгийнхэнтэйгээ ижил хүйсийн баримжаатай байх хэрэгтэй. Хэрэв гол чиглүүлэгч нь трансгендер хүн биш бол, эсвэл хөтөлбөр нь хэд хэдэн хүйсийн баримжаатай хүмүүсийг хамардаг бол трансгендер хамтран зохицуулагчтай байх нь үр дүнтэй байдаг. Хоёр чиглүүлэгчтэй байх боломжтой бол тэд өөр өөр хүйсийн шинж чанартай байх нь ашигтай байдаг. Агуулгаа сайн бэлтгэж, сайн эзэмшсэн л бол сизжендер хүн болон өөр нэг хүнтэй хамтран чиглүүлэгч хийх нь илүү хүчтэй ч байж болно.
- **Оролцогчдын дуудуулахыг илүүд үздэг хүйсийн төлөөний үгийг ашиглах:** Сургагч багш нар өөрсдийгөө танилцуулахдаа өөрсдийн нэр, хүйсийн төлөөний үгээр (жишээлбэл, тэр эрэгтэй, тэр эмэгтэй) танилцуулж, дараа нь оролцогчдоос өөрсдийгөө танилцуулахыг хүсэх. Ийм байдлаар оролцогчдод хэрэв хүсвэл ямар төлөөний үг хэрэглэхийг санал болгох боломжийг олгоно. Хэнийг ч заавал өөрийгөө ямар хүйсээр дуудуулахаа болон бусад хувийн мэдээллээ хуваалцахыг шаардах ёсгүй.
- **Хувь хүний түвшний сургалтыг олон нийтийн түвшний арга хэмжээтэй нэмэлт байдлаар эсвэл үялдуулах талаар бодож үзэх:** Эдгээр нь бүхэлдээ, трансгендер хүмүүсийн гутаан доромжлол, ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийг арилгах чиглэлээр нийгэмд боловсрол олгох ёстой. Энэ нь олон нийтийн сонирхлыг нэмэгдүүлж, трансгендер залуучуудад хөтөлбөрт хамрагдах эхлэлийн цэгийг бий болгоно.

¹⁰ Тодорхойлолтыг дараах холбоосоор үзнэ үү : https://en.wikipedia.org/wiki/List_of_transgender-rights_organizations, https://en.wikipedia.org/wiki/List_of_LGBT_rights_organizations.

Гол баримт бичиг ба сургалтын хөтөлбөр

- Трансжендэр хүмүүстэй ХДХВ ба БЗДХ-ын цогц хөтөлбөр хэрэгжүүлэх: Хамтын ажиллагааны практик удирдамж (НҮБХХ, 2016)
- ХДХВ ба Трансжендэр залуучууд: Техник арга зүйн товч (ДЭМБ, 2015)
- Ази, Номхон далайн транс хүмүүс болон транс нийгэмлэгүүдэд цогц тусламж үзүүлэх төлөвлөгөө (Ирээдүйн бүлэг, Эрүүл мэндийн бодлогын төсөл, 2015)
- Цогц тусламж үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөө: Карибын тэнгис болон бусад англофон орнуудын транс хүмүүс ба тэдний нийгэмлэгүүдэд зориулсан (John Snow, Inc, 2014)
- Транс хүмүүс, хүүхэд, залуучуудыг дэмжих гарын авлага (Хүүхдэд зориулсан үйл ажиллагаа, 2016)
- Трансжендэр эрүүл мэнд (Lancet, 2016)
- Йогьякартагийн зарчим: Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаатай холбоотой хүний эрхийн тухай хуулийг хэрэглэх зарчим (2007) ба Йогьякарта зарчим нэмэх 10 (2017)
- АНДТранС баримтууд: Ази Номхон далайн бүсэд транс байх нь (Ази, Номхон далайн транс сүлжээ, 2016)
- Транссексуал, трансжендэр, жендэрийн үл нийцэх хүмүүсийн эрүүл мэндэд үзүүлэх тусламж үйлчилгээний стандартууд, 7-р хувилбар (Дэлхийн трансжендэр эрүүл мэндийн мэргэжлийн холбоо, 2012)
- Доктор Радын нэрэмжит эрүүл мэндийн шоу - Бие даалтын шалгалт ба Үзлэг (RAD Remedy, бусад)
- Лусын дагина (вэбсайт)
- Жендэрийн спектр (вэбсайт)
- Анатомиас давсан №1: Транс хүмүүсийн түншүүдэд зориулсан бие махбод, бэлгийн чиг баримжаа олгох гарын авлага (Анархист Зайн Номын Сан, бусад)

3.7 Залуу интерсекс хүмүүс

Интерсекс хүмүүс биологийн хүйсийн хувьд эрэгтэй, эмэгтэйн аль нэгэнд нийцдэггүй шинж чанартай байдаг. Тэд хромосомын хэв маяг, бэлгийн булчирхай (ихэвчлэн төмсөг, өндгөвч) ба / эсвэл бэлгийн болон нөхөн үржихүйн эрхтний хувьд эхийн хэвлийд байхаасаа эхэлсэн бэлгийн хөгжлийн өөрчлөлтөөс болж ялгаатай байж болно. Эдгээр нь эмгэг, өвчин биш харин хүний бие махбодын ердийн өөрчлөлт юм. Интерсекс байх нь зөвхөн биологийн бэлгийн шинж чанартай холбоотой бөгөөд энэ нь тухайн хүний хүйсийн баримжаа, бэлгийн чиг баримжаагаас ялгаатай юм. Тиймээс интерсекс хүн хүйсээ эмэгтэй, эрэгтэй, хоёуланг нь эсвэл алинд нь я хамаарахгүй гэж тодорхойлж болох бөгөөд бэлгийн чиг хандлага нь шулуун, гей, лесби, бисексуал, асексуал эсвэл бусад байж болно.

Интерсекс хүмүүсийн өөр өөр хэв шинжүүд бодосноос ч илүү түгээмэл байж болдог. Учир нь тэдний өвөрмөц хэрэгцээ, шинж чанарыг бусад хүмүүс хүлээн зөвшөөрдөггүй. 1955-2000 онуудад хийсэн анагаах ухааны ном зохиолын судалгаагаар интерсекс хэв шинжийн давтамжийг судалж үзэхэд эдгээр нь амьд төрөлтийн 1.7% -д тохиолддог (Блаклесс нар, 2000) гэсэн дүгнэлт гарсан боловч энэ нь аль шинж чанарыг интерсекс гэж үзэж байгаагаас хамаарна.

Ихэнх хэв шинжүүд нь хүний амь насанд аюул учруулахуйц эрүүл мэндийн хүндрэл биш ч гэсэн олон жилийн туршид интерсекс нярай болон хүүхдүүдэд эмнэлэгт арга хэмжээ авч байсан түүхтэй. Эдгээр эргэлт буцалтгүйгээр өөрчилдөг мэс ажилбар нь эрт “залруулга” хийх нь тухайн хүнийг ‘хэвийн’ эрэгтэй, эмэгтэй хүн болгон төлөвшүүлдэг гэсэн маргаантай ойлголтоос үүдэлтэй байж болно. Эцэг эхчүүдэд хүүхдүүддээ өөрийг нь интерсекс гэдгийг хэлэхгүй байх, яагаад мэс засал хийлгэх шаардлагатай байгаа тухай үнэнийг нуун дарагдуулахыг ихэнхдээ зөвлөдөг байсан. Энэ нь интерсекс хүүхдүүдэд төөрөлдсөн, тусгаарлагдсан, ичгүүртэй мэдрэмжтэй болоход хүргэдэг. Ийм мэс ажилбар нь эрүүл мэндийн хувьд шаардлагагүй бол энэ нь нялхас, хүүхдийн хүний эрхийг зөрчдөг ба учир нь тэд чөлөөтэй, мэдээлэлтэйгээр зөвшөөрөл өгөх боломжгүй юм. Хүний эрхийн байгууллагууд интерсекс хүмүүсд инвазив, эргэлт буцалтгүй үр дагавартай эмчилгээ хийх урьдчилсан нөхцөл бол тэднээс бүрэн төгс, чөлөөтэй, мэдээлэлтэйгээр зөвшөөрөл авах явдал бөгөөд (ДЭМБ, 2014), боломжтой түүхийн ололдолд ийм эмчилгээ ажилбарыг хүүхэд шийдвэр гаргах үйл явцад оролцох боломжтой, мэдээлэлтэй шийдвэр гаргах хангалттай насанд хүртэл нь хойшлуулна гэж заасан (Европын Комиссын Захиргаа- Хууль зүйн ерөнхий газар, 2012; Дойчер Этикрат, 2012).

Хүүхдүүд өөрсдийгөө интерсекс гэдгээ шилжилтийн нас эхлэх үед мэддэг, хэрэв шилжилтийн үе эхлэхгүй бол (жишээ нь, сарын тэмдэг ирэх, биеийн зарим хэрэгт үс ургах, хөх ургах эсвэл булчингийн масс хөгжих гэх мэт) өөрсдийгөө интерсекс гэдгийг мэдэж болно. Хүүхэд, залуучууд өөрсдийгөө интерсекс гэдгийг мэдээд өөрсдийн хүйсээ шинээр харж эсвэл асуулт тавьж байж болно. Өөрсдийгөө гэрчилгээн дээр эсвэл мэс заслын аргаар буруу хүйс өгсөн гэдгээ мэдсэн хүмүүс хүйсээ солих сонголт хийж магадгүй юм.

Интерсекс хүний биологийн онцлог болон урьд өмнө мэдэж байсан хийлгэсэн эсвэл хийлгээгүй нь тэдний бэлгийн амьдралд нөлөөлж болзошгүй.

Бие махбодын зарим ялгаатай байдлын улмаас үтрээний хавьтал хүндрэлтэй эсвэл боломжгүй байж болно. Нөхөн үржихүйн эрхтнүүдийн мэдэж байсан нь тэдний бэлгийн харилцаанд нөлөөлж эсвэл бэлгийн харилцаа нь тэдний мэдэж байсан үүдэлтэй сэтгэцийн гэмтлийг сэдэрж болно. Тэд өөрсдийгөө интерсекс шинж чанартай цорын ганц хүн биш гэдэг олж мэдэх, дэмжлэгийн бүлгүүдийг олох, бусад интерсекс хүмүүстэй холбоо тогтоох нь маш чухал бөгөөд эмчилгээний ач холбогдолтой юм.

Интерсекс хүүхэд, залуучуудын БЦБ-ын хэрэгцээний талаар өргөн тархсан ном зохиол байхгүй тул энэ хэсэгт өгсөн зөвлөмжийг интерсекс хүмүүсийн байгууллагууд болон тэдний төлөөллийн гишүүдтэй хийсэн ярилцлагад үндэслэв.

Хөтөлбөрийн төлөвлөлт ба боловсруулалт

- **Хөтөлбөрийг боловсруулж, хүргэхэд орон нутгийн болон бүс нутгийн интерсекс нийгэмлэгийг татан оролцуулах:** Хэрэв тийм боломжгүй бол нэг буюу хэд хэдэн интерсекс хүмүүсийг хөгжлийн үйл явцад хамруулах нь чухал юм.¹¹
- **Тохиромжтой нэр томъёог тодорхойлох:** Зарим хэлэнд интерсекс гэсэн үг байхгүй эсвэл интерсекс, трансжендэр гэсэн ижил нэр томъёог ашиглаж байж болзошгүй. Хөтөлбөр боловсруулагчид тухайн олон нийттэй хамтран тэднийг хэрхэн нэрлэхийг тодорхойлох ёстой.
- **Хөтөлбөрийг заах орон нутгийн соёлд интерсексийн хэлбэрүүдийг хэрхэн авч үздэгийг ойлгох:** Зарим соёл иргэншилд интерсекс хүмүүсийг онцгойлон эсвэл гуравдагч хүйстэн гэж үздэг, эсвэл зарим соёлд бурханлаг гэж үздэг бол, харин зарим соёлд тэднийг гутаан доромжилж байж болно. Зарим улс орнуудад интерсекс хүмүүс янз бүрийн шалтгаанаар өөрсдийгөө ЛГБТК+ бүлэг, хувь хүмүүсээс ялгаатай гэж үзэж болно.
- **Интерсекс шинж чанартай залуучуудын олон янз байдлыг хүлээн зөвшөөрч, тэдэнтэй ярилцахад бэлэн байх:** Олон янзын шинж чанаруудаас гадна интерсекс хүүхэд, залуучууд өөрсдийн ялгаатай байдлын талаар харилцан адилгүй мэдлэгтэй байх ба үүнийгээ хүлээн зөвшөөрөх, ойлгох түвшин харилцан адилгүй байж болно. Тэд мөн интерсекс байхтай холбоотой олон өөр туршлагатай байж болно, ж.нь. зарим нь олон удаа мэдэж байсан хийлгэсэн байхад зарим нь хийлгээгүй байж магадгүй юм.
- **Оролцогчдыг хэрхэн тодорхойлох, тэдэнд хэрхэн хүрэх талаар бодож үзэх:** Сурталчилгаа болон хэвлэлийн мэдээ хүргэхдээ, имэйл, утасны дугаар эсвэл вэбсайт гэх мэт холбоо барих мэдээллээ заавал гаргаж байх хэрэгтэй. Ингэснээр хүмүүс хөтөлбөр лүү холбогдох боломжтой. Зарим тодорхой бүлгийн интерсекс хүмүүсийг дэмжих бүлгүүд бас байж болох бөгөөд залуу интерсекс хүмүүс тэдэнтэй ижил төстэй бусад хүмүүсийг мэддэг байж магадгүй юм. Зөвхөн “интерсекс” гэсэн нэршлийг биш, харин “хүйсийн онцлог шинж чанар бүхий хүмүүс”, “бэлгийн хөгжлийн ялгаатай хүмүүс” гэх мэт орон нутгийн хэмжээнд танигдсан бусад нэр томъёог ашиглах нь хүн бүр хөтөлбөрийг таньж тодорхойлоход тусална.

- **Хөтөлбөрт оролцогчид болон ажилтнуудын аюулгүй байдал, нууцлалыг хангах явдалыг хөтөлбөрийн сурталчилгааны хэрэгцээ шаардлагатай тэнцвэртэй авч үзэх:** Интерсекс залуучуудад дарамт үзүүлэх болон бусад төрлийн хүчирхийлэлд өртөх эрсдэл нь орчин нөхцөлөөс хамаардаг. Олон нийтийн сурталчилгааны компанит ажлын үеэр хичээлийн байршил, цагийг зарлахаас илүүтэйгээр хөтөлбөрийн талаар холбоо барих утас, мэдээллийг өгөх нь илүү аюулгүй байж болох бөгөөд ингэснээр боломжит оролцогчдыг шалгаж авах боломжтой болно.
- **Хувийн нууцлалыг хадгалахын тулд аюулгүй системийг бий болгох:** Оролцогчдын талаарх хувийн аливаа мэдээллийг тэдэнд дайсагнах хандлагатай хувь хүмүүс, бүлэглэл эсвэл байгууллагуудаас хамгаалах хэрэгтэй.
- **Залуу интерсекс хүмүүст хүндэтгэлтэй хандах үйлчилгээнүүдэд зуучлах лавлагаа бий болгох:** Боломжтой бол БЦБ-ыг хэрэгцээтэй бусад үйлчилгээнүүдтэй холбож өгөх хэрэгтэй, үүнд интерсекс хүмүүст ээлтэй эрүүл мэнд, сэтгэцийн эрүүл мэндийн хөтөлбөрүүд эсвэл мэргэжилтнүүдтэй холбох нь маш чухал юм. Хэрэв тохиромжтой лавлагаа үйлчилгээ авах боломжгүй бол хөтөлбөр боловсруулагчид засгийн газруудад үйлчилгээ үзүүлэхэд нөлөөлөх, үйлчилгээ үзүүлэгчдийг мэдрэмжтэй болгох нөлөөллийн ажилд нэгдэх ёстой.
- **Боломжтой бол зөвхөн интерсекс хүмүүсийн орон зайг бий болгох:** Энэ нь хамт олныг бий болгох, хувийн нууцыг хамгаалах, сэтгэлийн шархийг эдгээх зэрэгт чухал үүрэгтэй. Түүнчлэн дийлэнх интерсекс хүмүүс бусад хүмүүст өөрсдийгөө интерсекс гэдгийг мэдэгдэхийг хүсдэггүй тул тэдний хувийн нууцлалыг хадгалахад чухал ач холбогдолтой.
- **Эцэг эхчүүдэд зориулсан хичээлүүдийг оруулах талаар бодож үзэх:** Үүнийг хийх олон төрлийн шалтгааны нэг нь эцэг эхчүүд хүүхдэдээ эмнэлгийн мэдэж байсан хийлгэсэн шийдвэрийнхээ талаар ямар бодолтой багаа талаараа сэтгэл хөдлөлөө илэрхийлэх нь тэдэнд тустай байж болох юм. Хэрэв оролцогчид хүсвэл эцэг эхчүүдтэй хамтарсан хичээлүүдийг хийж болно.

Заах ба суралцах арга барил

- **Гэмтлийн талаар мэдээллийн арга барилыг ашиглах:** Олон интерсекс залуучуудын хүүхэд ахуй нас, өсвөр насанд тохиолдсон мэдэж байсан, гутаан доромжлол нь тэдний хувьд сэтгэл зүйн эмгэг цочролд оруулсан байж болзошгүй бөгөөд хөтөлбөрүүд үүнийг анхаарч үзэх хэрэгтэй. (Дэлгэрэнгүй мэдээллийг хуудас 14-ээс үзнэ үү.)
- **Бэлгийн болон нөхөн үржихүйн талаар ярихдаа анатоми, диаграммыг бүрэн цогц тайлбаруудыг оруулах:** Диаграммыг эрэгтэй, эмэгтэй гэж нэрлэсэн шошготой, биеийн эд хэсгийг нэг хүйсээр хуваарилж болохгүй. Анатомийн хичээл заахад оролцогчдоос хэсэг бүр дээр ямар үг ашигладаг болохыг асууж, олон янзын шошго оруулах боломжийг олгоорой.
- **Хүүхэд, залуучууд интерсексийн өөр өөр хэлбэрийн талаар юу мэддэгийг тодруулах аргуудыг ашиглах:** Тэднээс сурч мэдсэн зүйлээ болон мэдээллийн эх сурвалжаа хуваалцахыг хүс, үнэн үү / худал үү асуулт эсвэл тоглоомыг ашиглах. Энэ нь сургагч багш оролцогчдын буруу ойлголт, ташаа мэдээллийг олж мэдэж, засаж залруулах боломжийг олгодог.

¹¹ Байгууллагуудын жагсаалтыг дараах холбоосоор үзнэ үү: (<https://interactadvocates.org/resources/intersex-organizations/>) and Intersex Day (<https://intersexday.org/en/links/>).

Хөтөлбөрийг хүргэх

- **Оролцогчдын дуудуулахыг хүссэн хүйсийн төлөөний үгийг ашигла:** Сургагч багш нар өөрсдийгөө танилцуулахдаа өөрсдийн нэр, хүйсийн төлөөний үгээр (жишээлбэл, тэр эрэгтэй, тэр эмэгтэй) танилцуулж, дараа нь оролцогчдоос өөрсдийгөө танилцуулахыг хүсэх. Ийм байдлаар оролцогчид хэрвээ хүсвэл ямар төлөөний үг хэрэглэхийг санал болгох боломжийг олгоно. Хэнийг н ч заавал өөрийгөө ямар хүйсээр дуудуулахаа болон бусад хувийн мэдээллээ хуваалцахыг шаардах ёсгүй.
- **Боломжтой тохиолдолд аль болох олон тооны хүмүүст хүрэхийн тулд технологийг ашиглах талаар бодож үзээрэй.** Интерсекс хүмүүс хүн амын харьцангуй бага хэсгийг бүрдүүлдэг бөгөөд өөрсдийгөө энэ бүлгээр тодорхойлох хүсэлгүй байдаг тул тэд онлайн видеонууд, интерактив хэсэгтэй видео хурал эсвэл вебинар уулзалтаар дамжуулан санал болгож буй нэмэлт БЦБ-ын бүрэлдэхүүн хэсгүүдэд хамрагдаж магадгүй. Гэсэн хэдий ч хөтөлбөрт биечлэн оролцох боломжтой бүрэлдэхүүн хэсэг байх нь чухал.

Гол баримт бичиг ба сургалтын хөтөлбөр

- *InterACT* (Intersex залуучуудын өмгөөлөгчид) (вэбсайт)
- *Баримтын хуудас: Интерсекс* (НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газар)
- *Intersex vk.com дээр* (видеонууд)
- *dsdteens* (вэбсайт)
- *Сексийн хөгжил хэрхэн явагддаг вэ* (вэбсайт)
- *Интерсекс хүүхдээ дэмжих нь: Эцэг эхчүүдэд зориулсан арга хэрэгсэл* (Intersex International Europe Байгууллага, 2018)
- *Бүрэн фронтын идэвхтэн: Интерсекс ба Гайхалтай* (вэбсайт)
- *Интерсекс холбоотнуудын товч удирдамж* (Интертекс Интернэшнл Байгууллага, 2012 он)
- *Тодорхойлолт: Intersex* (вэбсайт)
- *Интерсекс залуучуудын танаас дэмжлэг хүсэж буй 9 арга зам* (Өдөр тутмын феминизм, 2015)
- *Өнөөдөр залуу, интерсекс байх нь юу гэсэн үг вэ?* (Dazed Digital, 2016)

3.8 ХДХВ-ийн халдвартай залуучууд

2019 онд дэлхийн хэмжээнд ХДХВ-ийн халдвартай 1.7 сая өсвөр насныхан амьдарч байгаа ба 10-19 насны өсвөр насныхны дунд ХДХВ-ийн халдвараар ойролцоогоор 170,000 орчим хүн шинээр бүртгэгдсэн байна (НҮБДОХ, 2020). ХДХВ-ийн халдвартай 15-24 насны 3.4 сая орчим залуучууд байгаа бөгөөд нийт халдварын 28 орчим хувь нь залуучуудын дунд тохиолддог (НҮБДОХ, 2020).

ХДХВ-ийн халдвартай ихэнх хүүхэд, залуучууд дараах хоёр замаар халдвар авсан байдаг. Үүнд: эхийн хэвлийд байхдаа төрөхийн өмнөх үед болон хөхөөр хооллох замаар (тохиолдлын 70 орчим хувь), эсвэл дараа нь хамгаалалтгүй бэлгийн харилцаанд орох, бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэрэг, мансууруулах бодисын тарилгын багаж, шалгаагүй бохир цус сэлбэх, эсвэл бохир зүү хуваалцах зэргээр авсан байдаг. ХДХВ-ийн халдвар авсан хүүхэд, залуучууд зарим талаар ижил төстэй байдаг боловч тэдний олон туршлага, хэрэгцээ нь ялгаатай байдаг (НҮБДОХ, 2016а; STOPAIDS ба бусад, 2016).

Эхийн хэвлийд байхдаа авах халдвараас гадна ХДХВ-ийн халдвар авсан хүүхэд, залуучууд, ялангуяа өсвөр насандаа ихэнх тохиолдолд хамгаалалтгүй бэлгийн замаар халдварладаг. Үүний шалтгаан нь ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг муу, ХДХВ-ийн халдвар тархах эрсдэл бага гэж үзэх, бэлгэвчийн хэрэглээ бага, олон бэлгийн хавьтагчтай болох, хүчингийн гэмт хэрэгт өртсөн, эсвэл хамгаалалтгүй бэлгийн хавьталд орохыг хүчилсэн, эрт бэлгийн харилцаанд орох зэрэг болно (ДЭМБ ба бусад, 2015а; ДЭМБ ба бусад, 2015б). ХДХВ-ийн халдвар тархах нийтлэг шалтгаан нь аруитгасан тарилгын дутагдалтай байдлаас үүдэлтэй тариураа хуваалцах явдал юм (ДЭМБ ба бусад, 2015б).

Үндсэн хүн амд хамаарах хүүхэд, залуучууд - ижил хүйстэн эрчүүд болон бусад эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүд, биеэ үнэлэгчид, трансжендэрүүд, мансууруулах бодис тарьдаг хүмүүс, хоригдлууд болон бусад эрхээ хасуулсан хүмүүс нь - ХДХВ-ийн халдвар авах эрсдэлтэй байдаг. Учир нь залуу настай холбоотой эмзэг байдлаас гадна тэдэнд тулгардаг ялгаварлан гадуурхал, гутаан доромжлол, хүчирхийлэл нь энэхүү эрсдэлийг нэмэгдүүлдэг (ДЭМБ нар, 2015а; ДЭМБ, бусад, 2015б). Цаашилбал, хэрэв тэд насанд хүрээгүй бол засгийн газраас явуулж буй эрсдэлт хүн амд зориулсан хөтөлбөрт хамрагдахгүй байж болно.

Ретровирусийн эсрэг эмчилгээний хүртээмжийг нэмэгдүүлснээр ХДХВ-ийн халдвартай төрсөн хүмүүсийн олонх нь өсвөр нас, залуу насандаа амьдрах боломжтой болсон. Гэсэн хэдий ч тэд дархлааны доголдолтой холбоотой хөгжлийн хоцрогдол болон сүрьеэгийн хавсарсан халдвар зэрэг эрүүл мэндийн бэрхшээлтэй тулгардаг (Бриджес 2011; Эйсон and Ким, 2018). Тэдэнд ХДХВ-ийн халдвартай хүмүүсийг гутаан доромжилж, ялгаварлан гадуурхах хандлагаас үүдэн сэтгэцийн эрүүл мэндийн асуудал, сэтгэлийн түгшүүр, сэтгэлийн хямрал их байдаг бөгөөд энэ нь тэдний амьдралын чанар, эм, эмчилгээг түүштай хэрэглэхэд нөлөөлдөг (НҮБ-ын Хүүхдийн сан, 2016). Өсвөр насандаа тэд бэлгийн амьдрал, нөхөн үржихүйн сонголтуудтай холбоотой төвөгтэй сэтгэл хөдлөлтэй байдаг бөгөөд бэлгийн үйл ажиллагаа, ХДХВ-ийн халдварын талаарх мэдээллээ хэрхэн бусдад хэлэх талаар шийдвэр гаргахад бэрхшээлтэй байдаг (АНДХДХВ+ХС, 2013).

ХДХВ-ийн халдвартай хүүхэд, залуучууд, бусад бүх хүүхэд, залуучуудын нэгэн адил боловсрол болон бусад үйлчилгээг шаарддаг (Бриджес, 2011). Гэсэн хэдий ч эрүүл мэндийн түслэмж үйлчилгээнд хамрагдахад эцэг эхийн зөвшөөрөл авах насны тухай хуулийн заалтаас улбаалан хүүхдүүд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, түүний дотор ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх, шинжилгээ ба эмчилгээнд хамрагдахад эцэг эхийн зөвшөөрөлгүйгийн улмаас хамрагдах боломжгүй байна. Гутаан доромжлол, ялгаварлан гадуурхал нь хүүхэд, залуучуудад аюулгүй сексийн талаар зөвлөгөө авах болон ХДХВ-ийн шинжилгээнд хамрагдах боломжгүй байдалд хүргэж, ялангуяа ихэвчлэн хожуу оношлогдог эрсдэлт бүлгийн хүмүүст саад болж байна.

Хүүхэд, залуучууд ХДХВ-ийн эм үүхаас хэд хэдэн шалтгаанаар зайлсхийж болно, ялангуяа өөрсдийгөө ХДХВ-ийн халдвартай гэдгээ хэн нэгэнд илчлэхээс зайлсхийж байж болно. Эмчилгээнд тулгардаг нийтлэг асуудал бол өсвөр насныханд зориулсан түсгэй үйлчилгээ байхгүй, эрүүл мэндийн байгууллагууд ХДХВ-ийн халдвартай өсвөр насныхны хэрэгцээг сайн ойлгодоггүй явдал юм. Бусад нөлөөлж буй хүчин зүйлсэд эмнэлэг хол зайтай, тээврийн зардал байхгүй, тэднийг эмнэлэгт үзүүлж байгааг хүн харахаас эмээх, очоод удаан хүлээлгэдэг, бэлгийн харилцаанд орсон залуучуудад хандан хандлага зэрэг багтана. Ихэнх эмнэлэгт өсвөр насны хүүхдүүдийг хүүхдийн эмчээс ХДХВ-ийн насанд хүрэгчдийн үйлчилгээнд шилжүүлэх протокол байхгүй, бэлтгэгдсэн ажилтнууд хомс байдаг (ОУГБТХ-ны Европын сүлжээ ба бусад, 2017).

Хөтөлбөрийн төлөвлөлт ба боловсруулалт

- **БЦБ-ыг ХДХВ-ийн халдвартай хүүхэд, залуучуудын хэрэгцээнд нийцүүлэн боловсруулах, гэхдээ зөвхөн бэлгийн эрсдлийг бууруулахад анхаарах ёсгүй:** Зарим газарт ХДХВ-ийн халдвартай хүүхэд, залуучуудад зориулсан БЦБ-ын тусгайлсан багцыг боловсруулж өгөх нь зүйтэй. Учир нь тэд эрсдэлт хүн амд харьяалагдах боловч тэдний асуудал өөр бөгөөд илүү төвөгтэй бөгөөд тэдгээрийг шийдвэрлэх хууль эрх зүйн, бодлогын орчин бас өөр байна.
- **Оролцогчдын нийгмийн сүлжээ, дэмжлэгийн тогтолцоон дахь гол хүмүүсийг татан оролцуулах:** Хөтөлбөрүүд нь эцэг эх, асран хамгаалагч, шашны удирдагч, эрүүл мэндийн байгууллагуудад ХДХВ-ийн халдвартай амьдарч буй хүүхэд, залуучуудын бодит байдал, эрх, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн хэрэгцээг ойлгоход нь туслах; тэдний хүүхэд, залуучуудтай ХДХВ-ийн халдвартай хэрхэн амьдрах, ХДХВ-ийн статусаа хэрхэн илчлэх, бэлгийн амьдрал, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар (Стангл нар, 2015) тэдэнтэй ярилцах, тэднийг хэрхэн эерэг амьдрахад нь туслах үр чадварыг хөгжүүлэх ёстой.
- **Хөтөлбөрийг хамгийн их хэрэгцээтэй байгаа хүмүүст хүргэхийн тулд тэднийг элсүүлэх стратегийг ашиглах:** Оролцогчдыг эмнэлэг, эрүүл мэндийн төвөөр дамжуулан элсүүлвэл зөвхөн ХДХВ-ийн халдвартай, асаргаа сувилалд хамрагдсан хүүхэд, залуучуудыг л хамарна. Ийм оролцогчид асаргаа үйлчилгээнд хамрагдаагүй бусад хүмүүс, жишээлбэл, гадуурхагдсан бүлгүүд, эмчилгээгээ эхлээгүй эсвэл завсардсан хүмүүс гэх мэт хүмүүстэй харьцуулахад бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үр дүнгүүд аль хэдийн сайн байх магадлалтай (Преториус нар, 2015). Боломжтой бол залуучуудтай онлайнгаар, нийгмийн сүлжээнд хаалттай бүлгүүдээр үулзаж болох талаар бодож үзээрэй.
- **БЦБ-ыг бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх нэмэлт мэдээллийн эх сурвалжуудаар хангаж, интернэтээр эсвэл эмнэлгийн хүлээлгийн хэсгээс болгоомжтойгоор мэдээлэл авах боломжоор хангах:** Үүнд мультимедиа мэдээллийн материал, видео, товхимол, залуучуудад чиглэсэн ухаалаг гар утасны аппликейшнууд болон тусламжийн утас гэх мэт багтана (Стангл нар, 2015).
- **“ХДХВ-ийн халдвартай хүмүүс” гэсэн нэр томъёог хөтөлбөрийн нэрэнд оруулах, эсвэл оруулахгүй байх талаар бодож үзэх:** Зарим нөхцөл байдалд ХДХВ-ийн халдвартай хүүхэд, залуучууд бусдад өөрсдийнхөө статусыг мэдэгдэхийг хүсдэггүй.
- **Мэдээллийн нууцыг хатуу хадгалах аюулгүй мэдээллийн системийг бий болгох:** Оролцогчдын талаарх хувийн мэдээллийг ХДХВ-ийн халдвартай хүмүүст дайсагнаж болзошгүй бусад хувь хүн, бүлэг, байгууллага олж авахаас хамгаал.
- **ХДХВ-ийн халдвартай хүүхэд, залуучууд аль хэдийн сайн мэдээлэлтэй байгаа гэж битгий бод:** Тэд ХДХВ-ийн талаарх, түүний явц хэрхэн явагддаг, ХДХВ-ийн халдвартай амьдрах гэж юу болох, вирусын эсрэг эм гэж юу болох, тэдгээрийн гаж нөлөө эсвэл дагаж мөрдөх жүрам зэргийн талаар мэдэхгүй байж болно. Эмч нар зөвхөн эцэг эх, асран хамгаалагчидтай нь харьцдаг, тэд хүүхдэдээ мэдээлэл өгдөггүй бол эсвэл тэдний мэдээлэл харилцаа нь залуучуудад тохиромжгүй тохиолдолд тэд энэ талаар мэдээлэлгүй байж болно.

Заах ба суралцах арга барил

- **ХДХВ-ийн халдвар авсан залуу өсвөр насныханд менторын зөвлөгөө өгөх:** ХДХВ-ийн халдвартай, бэлгийн амьдрал болон харилцаагаа удирдаж чадаж буй тэднээс насаар ах залуучуудын дэмжлэг тэдэнд үр ашигтай байж болно.
- **Үлгэр дууриал үзүүлэх:** ХДХВ-ийн халдвар авсан, өөрийн ХДХВ-ын статусаа ил болгосон, эсвэл эрүүл романтик харилцаа бий болгосон (үүнд ХДХВ-ийн халдваргүй хамтрагчтай байж болно) залуучуудыг урьж оролцогчидтой ярилцуулж болно (АНДХДХВ+ХС, 2013).
- **Шийдвэр гаргах болон харилцааны үр чадварыг бэхжүүлэх:** Оролцогчдод ХДХВ-ийн талаар тайлбарлах, ХДХВ-ын статусаа ил болгох талаар сургуулилт хийх хангалтай их боломж олгож, тэдний асуултанд хариулж, хариу үйлдлийг нь шийдвэрлэх боломжоор хангах.

Хөтөлбөрийн хэрэгжилт

- **Бүх оролцогчдын аюулгүй байдлыг хангах орон зайг бий болгох:** ХДХВ-ийн халдвартай хүүхэд, залуучуудын бүлэг янз бүрийн шинж чанартай тул тэднийг нэг газар цуглуулах нь зарим хүмүүст аюултай байж болно. Зарим тохиолдолд ХДХВ-ийн халдвартай гол эрсдэлт хүн амд, тухайлбал гей эрчүүд эсвэл трансжэндэр эмэгтэйчүүдэд зориулж, тэднийг ялгаварлан гадуурхагдах, статусаа илчилэхээс урьдчилан сэргийлж, бусад хүмүүсээс тусад нь хөтөлбөрийг хүргэх шаардлагатай байж магадгүй юм.
- **Оролцогчдын өдөр тутмын амьдралын хэвшлийг анхаарч, уян хатан хандах:** Хөтөлбөрийг оролцогчдын эн уух, хооллох цагийн хуваарьт саад учруулахгүй байх, нийгмийн амьдралын бусад асуудлууд, түүний дотор ХДХВ-ийн үе тэнгийнхнийг дэмжих бүлгүүдэд оролцоход саад учруулахгүйгээр зохион байгуулах хэрэгтэй.

Гол баримт бичиг ба сургалтын хөтөлбөр

- *iCAN багц:* ХДХВ-ийн халдвартай залуучуудын (ХДХВ) болон тэдний асрамжийн хүрээний ХДХВ, Бэлгийн амьдрал, бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудлаарх амьдрах ухааны цогц үр чадвар - Сургагч багшийн гарын авлага, Дасгал ажлын ном (SAFAIDS ба НҮБ-ын Хүн амын сан, 2016)
- *ХДХВ-ийн халдвартай өсвөр насныхан:*
- *Тусламж үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх үйлчилгээг хөгжүүлж, бэхжүүлэх нь* (НҮБ-ын Хүүхдийн сан, 2016)
- *Хүүхдийн ХДХВ-ийн Холбоо (CHIVA)* (вэбсайт)
- *Шилжилтийн насандаа алдагдсан залуус:* Ази, Номхон далайн орнуудад ХДХВ-ийн халдвартай өсвөр насныхны өмнө тулгамдаж буй асуудлууд (АНДХДХВ+ХС, 2013)
- *Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийг сайжруулах ба ХДХВ-ийн халдвартай хүмүүсийн хүний эрх:* Удирдамжийн багц (ОУХДХВ+ХС, 2009)
- *ХДХВ ба Өсвөр насныхан:* ХДХВ-ийн шинжилгээ өгөх удирдамж ба ХДХВ-ийн халдвартай өсвөр насныханд зөвлөгөө өгөх, арчилгаа хийх (ДЭМБ, 2013)
- *Эерэг сургалт:* ХДХВ-ийн халдвартай залуучуудын (YPLHIV) боловсролын салбарын хэрэгцээг хангах нь (ЮНЕСКО, 2012)
- *Эерэг эрүүл мэнд, нэр төр, урьдчилан сэргийлэлт:* Үйл ажиллагааны удирдамж (ОУХДХВ+ХС ба НҮБДОХ, 2013)

3.9 Мансууруулах бодис хэрэглэдэг залуучууд

Тамхи, согтууруулах ундаа нь хамгийн өргөн хэрэглэгддэг мансууруулах бодис бөгөөд хүүхэд залуучуудын бэлгийн зан үйл, эрүүл мэндэд ноцтой үр дагавар авчирдаг бол хууль бус мансууруулах бодис, ялангуяа тарьж хэрэглэдэг бодис нь ХДХВ-ийн халдвар тархаж эхэлснээс хойш хамгийн их анхаарал татсаар ирсэн. Залуучуудын сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээний талаарх дэлхийн хэмжээний мэдээлэл хязгаарлагдмал байгаа боловч хар тамхины хэрэглээ нь залуучуудын дунд ахмад настнуудаас хамаагүй өндөр байгааг харуулж байна. Ихэнх судалгаанаас үзэхэд 12-17 нас бол мансууруулах бодисын хэрэглээ эхлэх эрсдэлтэй үе бөгөөд 18-25 насны орчим оргил үедээ хүрч болзошгүй (НҮБМБГХТА, 2018).

Хүүхэд, залуучуудын мансууруулах бодисын хэрэглээ үлс орноос хамаарч өөр өөр байдаг бөгөөд нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлаас хамаардаг: хууль бус мансууруулах бодис хэрэглэдэг хүүхэд, залуучуудын ихэнх нь амьдарч буй нийгэмдээ харьцангуй ядуу байдаг тул бохир зүү хуваалцаж эсвэл мансууруулах бодисоор секс солих, зарах магадлалыг нэмэгдүүлдэг (НҮБМБГХТА ба бусад, 2017). Дэлхийн олон бүс нутагт хар тамхи мансууруулах бодис хэрэглэх нь үе дамжсан асуудал байдаг бөгөөд нэг өрхөөс олон гишүүн өртсөн байдаг ч энэ нь өсвөр насныхны түршил хийх, эрсдэлтэй зан үйл хийх оролдлого, ялангуяа үе тэнгийнхэн шахалт дэмжлэгийн нэг хэсэг байж болно. Мансууруулах бодис хэрэглэдэг залуучуудтай нийлэх нь энэ зан үйлийг хэвийн зүйл мэт болгож, бэхжүүлдэг. Зарим хүүхэд, залуучууд тэдэнд тулгарч буй сэтгэлзүйн болон физиологийн бэрхшээлээс зугтах, тухайлбал бие махбодын, бэлгийн эсвэл сэтгэл санааны хүчирхийлэл, үл хайхралт; гэр бүлтэй холбоотой бэрхшээлүүд; эсвэл бусдаас хөндийрөх, тэдэнд хорсох эсвэл сэтгэлийн хоосрох мэдрэмж зэргээс зугтахын тулд мансууруулах бодис хэрэглэж эхэлдэг. Ихэнх нь олон төрлийн бэрхшээлтэй эмзэг байдалтай нэгэн зэрэг тулгарсан байдаг (ДЭМБ ба бусад, 2015b).

Тэдний танин мэдэхүйн функцүүд дөнгөж хөгжиж байгаа тул хүүхэд, залуучууд мансууруулах бодис, донтолонд насанд хүрэгчдээс илүү өртөмтгий байдаг. Мансууруулах бодисын хэрэглээ нь залуучуудын сэтгэн бодох үйл явцыг дарангуйлж, тухайлбал бэлгийн харилцааны талаар, жишээлбэл бэлгэвч хэрэглэх эсэх талаар шийдвэр гаргахад саад болдлог (ДЭМБ ба бусад, 2015b). Бохир зүү болон бусад мансууруулах бодис ашиглах хэрэгслүүдийг хувааж хэрэглэх нь хүүхэд, залуучуудад зориулсан хор хөнөөлийг бууруулах арга хэмжээ байхгүй тохиолдолд эдгээр хүчин зүйлс нь мансууруулах бодис хэрэглэдэг залуучууд, ялангуяа мансууруулах бодис тарьж хэрэглэдэг хүмүүсийн дунд ХДХВ, бэлгийн замаар дамжих халдвар, гепатитын эрсдлийг эрс нэмэгдүүлдэг (ДЭМБ ба бусад, 2015b).

Мансууруулах бодис хэрэглэдэг залуучууд шаардлагатай үйлчилгээнд хамрагдах, жишээлбэл мэдээлэл, тарилгын ариутгасан багаж хэрэгсэлээр хангагдах, хар тамхины хамаарлыг эмчлэх эмчилгээнд хамрагдахдаа олон бэрхшээлтэй тулгардаг. Эдгээр саад бэрхшээлүүдэд залуучуудад чиглэсэн, хор хөнөөлийг бууруулах хүртээмжтэй үйлчилгээ байхгүй байх; 18 нас хүрээгүй хүмүүс хор хөнөөлийг бууруулах болон эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдахдаа эцэг эхийн зөвшөөрлийг авахыг шаардсан хязгаарлалтын улмаас нууцлал алдагдах; үйлчилгээ үзүүлэгчдийн тэдэнд шүүмжлэлтэй хандах хандлага; мансууруулах бодис хэрэглэснээс болж эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэхгүй байх зэрэгтэй холбоотой. Нотолгоонд суурилсан хор хөнөөлийг бууруулах, опиоидыг орлох эмчилгээ, эмчилгээгээ зогсоох шинж тэмдгүүдийн эмчилгээ дутагдалтай байна (ОУХДХВ+ХС ба ОУМБХХС, 2010; Ларни нар, 2017). Тиймээс мансууруулах бодис тарьдаг залуучууд эрүүл мэндэд

учрах эрсдэл, тарилгын аюулгүй байдал, ХДХВ-ээс урьдчилан сэргийлэх талаар мэдлэг нь бусад тэднээс дээш насны бүлгийн хүмүүсээс доогуур, ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээг хойшлуулдаг нь ХДХВ-ийн халдвар дамжих боломжийг нэмэгдүүлдэг (AVERT, 2019).

Эрүүгийн хариуцлага хүлээлгэх, шийтгэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа нь гутаан доромжлол, хэвшмэл ойлголт, ялгаварлан гадуурхалтыг нэмэгдүүлж, мансууруулах бодис хэрэглэдэг хүмүүсийг нууц байдалд оруулж, улам нийгмээс өөрсдийгөө тусгаарлахад хүргэж, үйлчилгээний хүртээмжийг бууруулдаг (ДЭМБ, 2016a). Жишээлбэл, мансууруулах бодис хэрэглэснээс үүдсэн хууль эрх зүйн үр дагавар, хүүхдүүдийнхээ асран хамгаалах эрхийг алдах эрсдэл зэрэг нь залуу жирэмсэн эмэгтэйчүүд эсвэл мансууруулах бодис хэрэглэдэг эхчүүдийг үйлчилгээ авахаас татгалзахад хүргэдэг (ОУХДХВ+ХС ба ОУМБХХС, 2010). Нийгэм, эдийн засгийн бусад үр дагаварт нийгмийн харилцааны доголдол, ажилгүйдэл, эрх чөлөөгөө хасуулах магадлал нэмэгдэх зэрэг багтана.

Хөтөлбөрийн төлөвлөлт ба боловсруулалт

- **Мансууруулах бодис хэрэглэдэг хүүхэд, залууст чиглэсэн арга хэмжээ нь агуулын хувьд тохиромжтой эсхийг баталгаажуулах:** БЦБ-ыг боловсруулж буй хүмүүс мансууруулах бодисын хэрэглээ хэрхэн үүсдэг, түүний олон янз байдал, хэрхэн өөрчлөгдөж, хор хөнөөлийг хэрхэн бууруулах, хэрхэн эмчлэх арга хэмжээ, хар тамхи, мансууруулах бодис хэрэглэдэг хүмүүст хууль сахиулахтай холбоотой хууль тогтоомж, хууль эрх зүйн чиг хандлагыг ойлгох хэрэгтэй. Мөн тэд мансууруулах бодис хэрэглэдэг хүүхэд, залуучуудын олон янзын хэрэгцээ, сэдэл, тэдний амьдралын нийгэм, эдийн засгийн динамик, хүүхэд, залуучуудыг мансууруулах бодис хэрэглэхэд хүргэдэг эмзэг хүчин зүйлсийг ойлгох ёстой.
- **Боловсролыг багтаасан цогц тусламж, үйлчилгээ төлөвлөх:** Хөтөлбөрүүд нь БЦБ-ыг мансууруулах бодис хэрэглэдэг залуучуудад зориулсан бусад хөтөлбөрүүдтэй холбох буюу нэгтгэхийг хичээх ёстой (ОУХДХВ+ХС ба ОУМБХХС, 2010; НҮБМБГХТА ба бусад, 2017). Хүүхэд, залуучуудын орон байр, хоол хүнс гэх мэт тулгамдсан асуудлыг хамгийн түрүүнд шийдвэрлэх хэрэгтэй, эс тэгвээс тэд оролцохгүй байж магадгүй юм. Хөтөлбөрүүд аль болох цогц дэмжлэг үзүүлэх, эсвэл оролцогчдыг ийм дэмжлэгийн бусад эх үүсвэртэй холбох хэрэгтэй. Үүнд (ОУГБТХ-ны Европын сүлжээ ба бусад, 2017) дараах дэмжлэг орно:
 - хор хөнөөлийг бууруулах (ариутгасан тарилгын тоног төхөөрөмж гэх мэт бараа бүтээгдэхүүний олгох гэх мэт) ба нотолгоонд суурилсан эмчилгээ
 - ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх, шинжилгээ, эмчилгээ, тусламж үйлчилгээ
 - гэр бүл төлөвлөлт, бэлгийн замаар дамжих халдвар, гепатит зэргийн талаарх бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ
 - сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ, үе тэнгийнхний удирдсан нийгмийн дэмжлэг
 - хүчирхийллийн даван туулагчдад үзүүлэх үйлчилгээ
 - эцэг эх байх, хүүхэд асран хүмүүжүүлэх асуудал, хүүхэд харах үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, хууль эрх зүйн үйлчилгээ, ялангуяа гудамжинд мансууруулах бодис хэрэглэдэг хараа хяналтгүй хүүхэд, залуучуудад үзүүлэх дэмжлэг, зөвлөгөө.
- **Хэрэв БЦБ нь цогц үйлчилгээтэй нэгтгэгдээгүй бол мансууруулах бодис хэрэглэдэг хүүхэд, залуучуудад зориулсан залуучуудад ээлтэй үйлчилгээ үзүүлдэг орон нутгийн нөөцийн жагсаалтыг гаргана уу.** Хэрэв тохиромжтой холбон зуучлах үйлчилгээ авах боломжгүй бол хөтөлбөр боловсруулагчид засгийн газруудад ойлголт өгөхөд нөлөөлөх нөлөөллийн ажилд нэгдэх ёстой.

Мансууруулах бодисын хэрэглээг гэмт хэрэг гэхээсээ илүү нийгмийн эрүүл мэндийн асуудал болгон хариу арга хэмжээ авах, зохих эмчилгээ хийх, мансууруулах бодис хэрэглэх талаарх ёс суртахууны хандлагыг прагматик хандлагаар орлуулах, эмнэлзүйн болон эмчилгээний практик үйл ажиллагааг шинжлэх ухааны нотолгоонд үндэслэх шаардлагатай (ОУХДХВ+ХС ба ОУМБХХС, 2010).

- **Нүүцыг чандлан хадгалах аюулгүй системийг бий болгох:** Оролцогчдын хувийн мэдээллийг хар тамхи мансууруулах бодис хэрэглэдэг хүмүүс, дайсагнах хандлагатай хувь хүн, бүлэг, байгууллага олж авахаас хамгаална.
- **Оролцогчдын зан үйлийг өөрчлөх арга хэрэгслээр хангах:** Хөтөлбөрүүд нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаарх үнэн зөв мэдээлэл, боловсрол олгоод зогсохгүй, эрсдлийг бууруулахад анхаарч, мөн эрэгтэй, эмэгтэй бэлгэвч олж авах гэх мэт оролцогчдод зан үйлээ өөрчлөх тодорхой арга хэрэгслийг заах ёстой (Дес Жарлайс ба Семаан, 2008).
- **Мансууруулах бодис хэрэглэдэг залуучуудын эцэг эхчүүдийг татан оролцуулах, гэхдээ зөвхөн тэдний зөвшөөрөлтэйгөөр:** Эцэг эхийн оролцоо нь залуучуудад зохих дэмжлэг үзүүлэхэд тусалдаг, гэхдээ эцэг эхчүүдийг оролцуулахаас өмнө залуучуудын зөвшөөрлийг авах нь чухал юм.

Заах ба суралцах арга барил

- **Оролцогчдод зан үйлийг өөрчлөх зорилго тодорхойлох боломжийг олгох:** Эрүүл зан үйлийн бодит зорилгыг хэрэгжүүлэхэд нь тэдэнд тусална уу (Эдлин нар, 2005; Дес Жарлайс ба Семаан, 2008).
- **Мансууруулах бодис хэрэглэхээс бүрмөсөн татгалзах нь үргэлж бодит зорилго биш гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй:** Хөтөлбөр нь мансууруулах бодис хэрэглэхгүй байх нь хэцүү бөгөөд амжилтанд хүрэхийн тулд хэд хэдэн удаагийн оролдлого шаардагдана гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Мансууруулах бодис хэрэглэсээр байгаа оролцогчдын хувьд эрсдлийг бууруулахын ач холбогдлыг онцлох хэрэгтэй.

Хөтөлбөрийн хэрэгжилт

- **Оролцогчидтой хүндэтгэлтэй харилцааг хөгжүүлэх:** Ёс суртахууны сургааль айлдах, оролцогчдод уурлаж бүхимдах зэрэг нийтлэг бэрхшээл гаргахаас зайлсхийх (Дес Жарлайс ба Семаан, 2008). Судалгаанаас харахад мансууруулах бодис хэрэглэдэг хүмүүст нэр төр, хүндэтгэлтэй хандах үед тэд өөрсдийн болон бусдын эрүүл мэндийн төлөө санаа тавьж хариу арга хэмжээ авахад бэлэн байдаг (Дес Жарлайс ба Семаан, 2008).
- **Хүүхэд, залуучуудыг мансууруулах бодис хэрэглэх эхэлснээс хойш аль болох хурдан тодорхойлж, хөтөлбөрт татан оролцуулахыг хичээх:** Төгс тохиолдолд тэднийг тариур хэрэглэж эхлэхээс нь хамруулах ёстой бөгөөд энэ үед ариутгаагүй тариур, багаж хэрэгслийг хуваалцах замаар ХДХВ-ийн халдвар авах эрсдлийг нэмэгдүүлдэг.
- **Оролцоонд саад болж буй бэрхшээлийг багасгах:** Жишээлбэл, мансууруулах бодис хэрэглэдэг хүүхэд, залуучууд аль хэдийн хамрагддаг, өөрсдийгөө тэнд аюулгүй гэж үздэг, эсвэл олон төрлийн үйлчилгээ авах боломжтой байршлуудад нь хөтөлбөрийг зохион байгуулах хэрэгтэй.

Гол баримт бичиг, сургалтын хөтөлбөр

- *Мансууруулах бодис тарьдаг хүмүүстэй ХДХВ ба ХПВ-ийн цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэх: Хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний практик удирдамж* (НУБМБГХТА, 2017)
- *ХДХВ ба мансууруулах бодис тарьдаг залуучууд: Техникийн товч танилцуулга* (ДЭМБ, 2015)
- *ХДХВ-ийн халдвартай мансууруулах бодис тарьдаг*

хүмүүсийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, ба хүний эрхийг сайжруулах: Бодлогын товч мэдээлэл (ОУХДХВ+ХС ба INPUD, 2010)

3.10 Секс үйлчилгээ үзүүлдэг залуучууд

Биеэ үнэлэгчид нь эмэгтэй, эрэгтэй, трансжендэр насанд хүрэгчид, 18-аас дээш насны залуучууд байдаг бөгөөд секс үйлчилгээг мөнгө эсвэл эд зүйлсээр тогтмол эсвэл хааяа сольж авдаг. Бэлгийн ажил гэдэг нь насанд хүрэгчдийн харилцан тохиролцсон бэлгийн харилцаа бөгөөд янз бүрийн хэлбэртэй байдаг. Энэ нь улс орон, орон нутаг дамнасан, тэдний хооронд болон дотор, “албан ёсны” эсвэл зохион байгуулалттай байх зэргээр харилцан адилгүй байдаг (Харкоурт ба Донован, 2005). НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцид заасны дагуу (сексийг зарах шийдвэрийг өөрсдөө гаргасан боловч / эсвэл өөрсдийгөө бэлгийн мөлжлөгт өртсөн гэж үзэхгүй байсан ч гэсэн) 18-аас доош насны хүмүүсийг биеэ үнэлэгч гэж биш буюу бэлгийн мөлжлөгт өртсөнд тооцдог.

Ихэнх улс оронд биеэ үнэлэх, санал болгох, олж авах, худалдан авах, хангахтай холбоотой нэг буюу хэд хэдэн үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг тул бэлгийн харилцааг зарж борлуулдаг залуучуудын тоог дэлхийн хэмжээнд үнэн зөв тооцоолоогүй байдаг (ДЭМБ нар, 2015а).

Биеэ үнэлдэг залуучууд орон гэргүй, цагаач эсвэл замд явж буй, өөрийн ууган гэр бүлээсээ хөндийрсөн, сэтгэцийн өвчтэй тэмцэж байгаа, гэр бүлийн гишүүд, дотны хамтрагч, үйлчлүүлэгчид, гуравдагч этгээдийн эсвэл цагдаагийн хүчирхийллийн золиос болох зэрэг олон төрлийн эмзэг байдалд өртсөн байж болно. (ДЭМБ ба бусад, 2015а). Мансууруулах бодис хэрэглэх, бэлгийн замаар дамжих халдвар, хүсээгүй жирэмслэлт, аюултай үр хөндөлт, ялгаварлан гадуурхах зэрэг нь тэдний сайн сайхан байдалд заналхийлж байж болзошгүй юм (ДЭМБ нар, 2015а). Биеэ үнэлдэг 18-аас доош насны хүмүүсийг аргачлалын хувьд мөлжлөг, хүний наймааны золиос болсон гэж үздэг бол бодит байдал дээр тэднийг цагдаа нар баривчлах эсвэл өөр хэлбэрээр дарамталдаг. Тэднийг 18-аас дээш насныхантай хамт гэмт хэрэгтэн гэж үздэг бөгөөд цагдан хорих, шоронд хийх болон бусад шийтгэлийн арга хэрэглэх, биеэ үнэлэхийг хуулиар зөвшөөрдөг улс орнуудад хүртэл хээл хахууль нэхэж, дарамт шахалт үзүүлдэг.

Бэлгийн мөлжлөгт өртөж буй 10-17 насны хүүхдүүд эдийн засгийн хэрэгцээ, насанд хүрэгчдийн эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглах, хүчирхийлэхийг заналхийлэх, харилцан тохиролцох туршлагагүй зэрэг шалтгаанаар биеэ үнэлэгчидтэй харьцуулахад үйлчлүүлэгчдийнхээ тоог өөрөө хянах боломж багатай байж болно (ДЭМБ, 2015а). Цаашилбал, олон оронд 18-аас доош насны насанд хүрээгүй хүмүүсээс хуулиар бие даан шийдвэр гаргах эрх өгөөгүй бол бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ, ХДХВ-ийн үйлчилгээнд хамрагдахын тулд эцэг эх, асран хамгаалагчийнх нь зөвшөөрөлгүйгээр хамрагдах боломжгүй байдаг (НҮБДОХ, 2012). Тэднийг баривчлах, цагдан хорих, ялгаварлан гадуурхахаас айдаг тул дэмжлэг, түслалцаа авах боломжгүй үед хүчирхийлэл, ялангуяа бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй болгодог.

Зарим залуучууд бэлгийн мөлжлөгийн зорилго бүхий хүний наймааны золиос болдог. Бэлгийн мөлжлөгийн зорилго бүхий наймааны золиос болсон хүүхэд, залуучуудын хүний эрхийг дээд зэргээр зөрчиж, өлсгөлөнд нэрвэгдэх, хорих, зодох, хүчиндэх, бүлэглэн хүчиндэх, хар тамхи мансууруулах бодис хүчээр хэрэглүүлэх, өөрт нь болон тэдний гэр бүлд хүчирхийллийн аюул заналхийлэх, гэр бүл, найзуудад нь тэдний оролцдог үйл ажиллагаагаа ил болох зэрэг эрсдэл тулгарч байж болно. Эрүүл мэндийн үр дагаварт бие махбодын гэмтэл, мансууруулах бодис, архины хамаарал,

бэлгийн замаар дамжих халдвар ба / эсвэл ХДХВ, жирэмсний хүнд хэлбэрийн хүндрэл, хүчээр үр хөндүүлэх, үргүйдэл зэрэг орно (ДЭМБ ба бусад, 2015а). Бие махбодын болон сэтгэл санааны хүчтэй цочрол, гэмтэл нь хохирогчдыг бусдын гарт амиа алдах, амиа хорлох, мансууруулах бодис, архи хэтрүүлэн хэрэглэх, ДОХ-той холбоотой өвчнөөс болж эрт нас барах эрсдэлд оруулдаг (ОУХБ, 2008; Коннер ба бусад, 2014; Оттисова ба бусад, 2018). Тэдний ихэнх нь бусдаас тусгаарлагдсан байдаг тул дэмжлэг, түслалцаа авч чадахгүй байдаг.

Насанд хүрээгүй хүүхдийг оролцуулсан сексийн аливаа үйл ажиллагааг бэлгийн мөлжлөг гэж үздэг тул тэднийг оролцохоос хамгаалсан байх ёстой учраас ийм төрлийн аливаа үйл ажиллагаанд оролцдог 18-аас доош насны хүмүүст ямар нэг үйлчилгээ үзүүлэхэд, үүнд БЦБ-ыг хүргэхэд хууль эрх зүй, улс төр, ёс зүйн бэрхшээл тулгардаг. Гэхдээ үүнийг 18-аас доош насны залуучуудыг мэдээлэл авах, урьдчилан сэргийлэх болон асран халамжлах үйлчилгээнд хамруулахгүй байх үндэслэл болгож болохгүй. Гэсэн хэдий ч төөрөлдөхгүйн тулд доорх зөвлөмжүүд нь зөвхөн 18 ба түүнээс дээш настай, сайн дураараа биеэ үнэлэх сонголт хийсэн хүмүүст хамаарна гэдгийг анхаарах хэрэгтэй.

Хөтөлбөрийн төлөвлөлт ба боловсруулалт

- **Зөвлөх чиг үүрэг бүхий холбодох байгууллагаас ёс зүйн зөвшөөрөл авах:** Биеэ үнэлдэг залуучуудад БЦБ-ыг хүргэх нарийн төвөгтэй тул хөтөлбөр нь ёс зүйн хувьд зарчимтай, үндэслэлтэй болохыг баталгаажуулж, хөтөлбөрт итгэх итгэл үнэмшил, хүлээн зөвшөөрөгдөх боломжийг олгохын тулд ёс зүйн хяналтыг эрэлхийлж үзээрэй. Хөтөлбөр нь сайн дураараа оролцох ёс зүйн зарчим, мэдээллийн нууцлалыг хадгалах, хөтөлбөрийн бүртгэл, мэдээллийн нууцлалыг хадгалах, эрүүл мэндийн болон бусад үйлчилгээнд шаардлагатай тохиолдолд холбон зуучилж өгөх ёстой.
- **Нууцлалыг чанд хадгалах аюулгүй системийг бий болгох:** Оролцогчдын хувийн мэдээллийг биеэ үнэлдэг хүмүүстэй дайсагналцах эрсдэлтэй хувь хүн, бүлэг, байгууллага олж авахаас хамгаална.
- **Биеэ үнэлэхэд шинээр элсэж буй хүмүүсийг үнэлэх, тэднийг албадлагаар, хүчээр оруулсан эсэх эсвэл 18 нас хүрээгүй эсэхийг тодорхойлох системийг бий болгох:** Үүнийг биеэ үнэлэгчдийн өөрийн удирдлагын зөвлөлөөр эсвэл биеэ үнэлэгч хувь хүмүүстэй хамтран зохион байгуулж болно. 18 нас хүрээгүй эсвэл өөрөө биеэ үнэлэхийг хүсэхгүй байгаа хүмүүст зөвлөгөө өгөх, дэмжих, нийгмийн үйлчилгээ, эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах шаардлагатай. Санал болгож буй хөтөлбөрүүд нь залуу хүн бүрийн өөр өөр хэрэгцээг хангах ёстой бөгөөд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нь биеэ үнэлж эхэлж буй залуучуудаас тэс өөр байдаг.
- **Залуучуудыг бэлгийн харилцааг зарж эхэлснээс хойш аль болох богино хугацаанд илрүүлж, тэднийг татан оролцуулахыг эрэлхийлэх:** Биеэ үнэлдэг олон хүмүүс залуу наснаасаа үүнийг хийдэг бөгөөд эхний саруудад хүчирхийлэл, эрүүл мэндийн сөрөг үр дагаварт хамгийн их өртдөг (Онянго нар, 2012; Бүсза нар, 2016). Хөтөлбөрүүд бэлгийн үйл ажиллагаанд оролцож буй залуучуудыг эхлээд секс ажилчид эсвэл биеэ үнэлэгч гэж тодорхойлж болохгүй гэдгийг анхаарах ёстой. Бичиг үсгийн сургалтын төл гэх мэт хоол, угаалгын өрөө, бусад үйлчилгээ үзүүлдэг залуучуудын очдог төвүүд нь бэлгийн худалдаа эрхэлдэг залуучуудыг олж тогтоох эсвэл тэдний хөтөлбөрт нэвтэрч орох эхлэлийн цэг байж болно (ДЭМБ ба бусад, 2015а). Биеэ үнэлдэг залуу эрэгтэйчүүд, трансжендэр хүмүүст хүрэхийн тулд хүчин чармайлт гаргах хэрэгтэй (Онянго нар, 2012).

- **БЦБ-ын агуулгыг биеэ үнэлж буй залууст зориулсан бусад хөтөлбөртэй холбох буюу нэгтгэх:** Биеэ үнэлдэг залуучууд тэдний эрүүл мэндэд учирч болзошгүй олон эрсдэл, хүний эрхийн зөрчлийг арилгахын тулд био анагаах ухаан, зан үйл, бүтцийн өөрчлөлтийг арга хэмжээг хослуулан хүргэхийг шаарддаг. Боломжтой бол тэдэнд, ялангуяа гудамжинд байрладаг, гэр оронгүй секс үйлчилгээ эрхэлдэг залуучуудад орон байр, усанд орох өрөө, хоол хүнс, эрүүл мэндийн үйлчилгээ, зөвлөгөө өгөх, хүчирхийлэлийн болон сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ, боловсрол, орлого олох боломж, хууль эрх зүйн түслалцаа үзүүлэх, эцэг эх байх дэмжлэг үзүүлэх, нийгмийн халамж, хүүхэд хамгааллын үйлчилгээ зэрэгт хамруулах эсвэл зуучлах цогц, хүн-төвтэй дэмжлэг үзүүлэх хэрэгтэй, (Онянго нар, 2012; Busza et al., 2016). Түүнчлэн байнга бэлгэвч хэрэглэх, ХДХВ-ийн халдварын өмнө болон дараах урьдчилан сэргийлэх профилактик, ХДХВ халдвар илрүүлэх шинжилгээ, зөвлөгөө өгөх үйлчилгээ, эмчилгээгээр хангах шаардлагатай (Онянго нар, 2012; ДЭМБ, 2016а).

Заах ба суралцах арга зүй

- **Биеэ үнэлэгч залуучуудад зориулсан БЦБ-ыг олон нийтийг чадваржуулах арга хандлагад тусгах:** Энэ нь тэднийг гутаан доромжлох, гадуурхах асуудлыг шийдвэрлэхэд тусалдаг бөгөөд хамтын эрх мэдэл, чадварыг нэмэгдүүлэх боломжтой юм.
- **Зөвхөн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн сэдвүүд дээр төвлөрөхгүй байх:** Оролцогчдын сонирхлыг татахуйц мэдээллийг танилцуулахын тулд янз бүрийн өнцгийг хайж олох (Мүүр нар, 2014; NSWP, 2016а). Жишээлбэл, жирэмслэлт, ХДХВ, бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар тайлбарлахдаа биеэ үнэлэгч хүмүүст чухал ач холбогдолтой байж болох гоо сайхан, эрүүл мэндийн өнцгөөс ярилцах.

Хөтөлбөрийн хэрэгжилт

- **Боломжтой бол оролцогчид бусад үйлчилгээнд хамрагдах боломжтой төвүүдэд хөтөлбөрийг хүргэх:** Үүнд: цай үүх зүйл, шүршүүр, амрах ба дасгал хийх өрөө гэх мэт. Гэхдээ зарим газарт биеэ үнэлэгчдийн гэрт эсвэл ажлын байранд, ялангуяа тэд олноороо хамт амьдардаг бол хөтөлбөрийг зохион байгуулах нь илүү үр дүнтэй байж болох юм.

Гол баримт бичиг ба удирдамж

- *Биеэ үнэлэгчдэд ХДХВ / БЗДХ-ын цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэх: Хамтын ажиллагааны практик хандлага* (ДЭМБ, 2013)
- *Бодлогын танилцуулга: Залуу биеэ үнэлэгчид* (БҮТС/NSWP, 2016)
- *ХДХВ ба Биеэ үнэлдэг залуучууд: Техник арга зүйн танилцуулга* (ДЭМБ, 2015)
- *Бие биенээ чадваржуулах нь: Этиоп дахь биеэ үнэлэгч залуучуудын- Link Up төслийн кейс судалгаа* (Frontline AIDS, 2015)
- *Секс ажилчдын судалгаа 15: Эсэргүүцэл ба тэсвэр тэвчээр* (БҮТС/NSWP, 2016)

3.11 Хорьж, саатуулагдаж буй залуучууд

Хоригдож, саатуулагдаж байгаа хүүхэд, залуучууд, мансууруулах бодис хэрэглэдэг, биеэ үнэлдэг, нийгэм-сэтгэл зүйн хөгжлийн бэрхшээлтэй залуучууд хоорондоо давхцаж болзошгүй тул энэ удирдамжийн холбогдох зөвлөмжийг хоригдож буй хүүхэд, залуучуудад анхаарч үзэх хэрэгтэй.

Хоригдож, саатуулагдаж байгаа хүүхэд, залуучуудад эрүүгийн хэрэгт холбогдсон эсвэл захиргааны журмаар цагдан хоригдож байгаа хүмүүс орно. Үүнд цагдаагийн газарт саатуулагдаж байгаа, ялын шийдвэрээ эсвэл шүүх хуралдааныг хүлээж байхдаа хоригдож байгаа, эсвэл ял шийтгүүлснийхээ дараа ял эдэлж байгаа, эсвэл насанд хүрээгүй, цагаачлалын эсвэл мансууруулах бодис хэрэглэсний улмаас саатуулах төв, нөхөн сэргээх төвд байгаа хүүхэд, залуучууд орно (ОУГБТХ ба НҮБ-ын Хүн амын сан, 2017b). Шүүхийн шийдвэрээр цагдан хорих үед залуу хүнийг эрүүгийн хэрэгт буруутгаж байгаа бол цагдан хорих шийдвэрийг шүүгч, холбогдох шүүх гаргадаг бол захиргааны хэргээр баривчлах шийдвэрийг гүйцэтгэх шатны буюу захиргааны байгууллага гаргадаг.

Дэлхий даяар хоригдож буй хүүхэд, залуучуудын тоог бүртгэсэн бүртгэл байхгүй, тэднийг хорьж болзошгүй олон тооны байгууллагууд байдгаас шалтгаалан тэдний тоо тодорхойгүй байна. 2009 онд НҮБ-ын Хүүхдийн сангаас 18-аас доош насны 1 сая гаруй хүүхдийг шүүх эрх мэдэл бүхий байгууллагууд цагдан хорьж байсан гэж тооцсон (НҮБ-ын Хүүхдийн сан, 2009), гэхдээ энэ нь маш дутуу тоо юм (Human Rights Watch, 2016). Хүүхэд, залуучуудыг цагдан хориход хүргэж болзошгүй харилцан хамааралтай хүчин зүйлсэд ядуурал, гэр бүлийн асуудал (үүнд эцэг эхийн хараа хяналт дутмаг байдал), боловсролгүй эсвэл ажил эрхлээгүй байдал, хүчирхийлэл, дарамт, мөлжлөг орно (НҮБМБГХТА, 2006).

Хүүхэд, залуучуудыг хорьж, саатуулж буй шалтгаануудад тэднийг гэмт хэрэгт сэжиглэж эсвэл ял шийтгэх; тэдгээрийг “гэмт хэрэгт өртөх эрсдэлтэй” эсвэл “нийгмийн таагүй бүлэг” гэж эсвэл “жирийн бус” гэж тооцдог; эсвэл хууль сахиулах байгууллагын зохисгүй буюу дүр мэдэн үйлдэл зэрэг болно. Цагаач хүүхдүүдийг олон улсын стандартаас гажиж цагаачдыг байрлуулах газруудад тогтмол байлгадаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон бусад хүмүүсийг хамгаалах нэрээр бөөнөөр нь байрлуулах асрамжийн газруудад байрлуулж байж болно. Захиргааны байгууллагаас баривчлах шалтгаан нь цагаачлал, хил дамнан шилжилт хөдөлгөөнийг хянах, аюулгүй байдалд саад болж буй хүмүүсийг хорих, сэтгэцийн эрүүл мэндийг нь эмчлэх, хар тамхи мансууруулах бодис хэрэглэдэг, хүчирхийлэл, мөлжлөгт өртөх эрсдэлтэй, эсхүл өөрөөр бол гудамжинд амьдрах байсан хүмүүсийг хамгаалах зэрэг орно. (Хамилтон нар, 2011).

Хоригдож байгаа хүүхэд, залуучуудын БЦБ-ын хэрэгцээний талаарх ихэнх ном зохиол нь өндөр орлоготой улс орнуудаас гаралтай боловч эдгээр залуучуудын нөхцөл байдлыг хүн амын дундажтай харьцуулбал эрүүл мэнд, сайн сайхан байдал нь эрсдэх эрсдэлтэй байгаа нь тодорхой байна. Тухайлбал өсвөр насны жирэмслэлт, бэлгийн замаар дамжих халдвар ба ХДХВ-ийн тархалт, гэр бүлийн хүчирхийлэл, гэмтэл бэртэл, бэлгийн хүчирхийллийн түүх, сэтгэцийн эрүүл мэндийн асуудал, мансууруулах бодисын хэрэглээ, гутаан

доромжлох, ялгаварлан гадуурхах, эрүүл мэндийн үйлчилгээ, боловсролын хүртээмж муу, бичиг үсэг тайлагдалт муу зэрэг орно (Шмиег нар, 2009; RACP, 2011; БЭМН, 2014). Эдгээр эрсдэлүүд нь өсвөр насны хөвгүүдтэй харьцуулахад хүйсийн болон эдийн засгийн статус нь доогуур байдаг тул хоригдож буй өсвөр насны охидын хувьд илүү хүнд байж болзошгүй юм (БЭМН, 2014). Хүүхэд, залуучууд цагдан хоригдож байхдаа бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй байдаг, ялангуяа насанд хүрсэн хоригдлуудтай хамт хоригдож байгаа тохиолдолд (Фройденберг нар, 2010; Human Rights Watch, 2016). ЛГБК+ болон трансжэндэр хоригдлууд нь хэл амаар доромжлуулах, бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэл өндөртэй байдаг (Жэймс нар, 2016).

Хүүхэд, залуучуудыг хорих нь тэдний өсвөр насны хэвийн хөгжил, амьдралын туршилтыг хязгаарладаг, учир нь тэд ихэвчлэн гэр бүлтэйгээ бараг эсвэл огт үүлдэггүй, ижил хүйсийн эсвэл эсрэг хүйсийн өсвөр насны үе тэнгийнхэнтэйгээ нүүр тулан харьцдаггүй, мөн тэд өөрсдийгөө бие даан авч явах хараат бус байдал орчинд байж чаддаггүй. Бусадтай үерхэж нөхөрлөх, эрүүл харилцааг үлгэрлэх насанд хүрэгчдийн зан үйлийн үлгэрлэл байхгүйгээр зарим нөхцөлд тэдний төлөвших хэвийн явц хойшлогдож эсвэл сөрөг үр дававар учруулж болзошгүй юм (Хорих газрууд дахь сексийн асуудлаарх комисс, 2015). Хоригдож байгаа хүүхэд, залуучууд суллагдсаны дараа бэлгийн харилцаа, дотно харилцаанд орохоос айдаг, ялангуяа хүчирхийлэлд өртсөн бол, мөн тэднийг үе тэнгийнхэнтэйгээ харьцуулбал тэдний романтик, бэлгийн туршлага дутмаг байгаа талаар ирээдүйн хамтрагч нь юу гэж бодох бол гэж санаа зовж магадгүй юм (Хорих газрууд дахь сексийн асуудлаарх комисс, 2015). Хоригдож байгаа олон хүүхэд, залуучууд гэр бүлийн харилцаа холбоогоо алдаж, үе тэнгийн сүлжээнд нь зөвхөн мансууруулах бодис хэрэглэдэг, хууль зөрчсөн, хэрэгт холбогдсон хүмүүс ордог (Мүүр нар, 2013), энэ нь суллагдсаны дараа тэдэнд сөргөөр нөлөөлж болзошгүй.

Хөтөлбөрийн төлөвлөлт ба боловсруулалт

- **Хөтөлбөр боловсруулахад эхнээс нь хорих байгууллагын албан тушаалтнуудыг оролцуулах:** Хорих байгууллага нь бэлгийн боловсрол, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах, нийгэмд нэвтрэх боломжгүй хүүхэд, залуучуудад хүрэх боломж юм. Гэсэн хэдий ч засан хүмүүжүүлэх газрууд нь өндөр хяналттай, хаалттай системтэй тул хүүхэд, залуучуудын бэлгийн амьдралыг дэмжсэн мэт хөтөлбөрүүдийг зөвшөөрөхгүй байх магадалтай тул янз бүрийн түвшний албан тушаалтнуудтай байнгын ярилцаж хэлэлцэх, ойлголцохыг шаардана (Сифунда нар, 2008).
